



Улс төрийн  
Боловсролын Академи

# ШИНЭ ТОЛЬ

78,2015



Улаанбаатар хот



# ШИНЭ ТОЛЬ

78,2015

Улаанбаатар хот



Konrad  
Adenauer  
Stiftung

Конрад-Аденауэр Сан ивээн тэтгэж  
“Мөнхийн үсэг”ХХК -д хэвлүүлэв.

Ерөнхий редактор:  
Редакцийн зохицуулагч:

Банзрагчийн Дэлгэрмаа  
Төмөрийн Сарантуяа

Редакци:

Эрдэнийн Бат-Үүл  
Бат-Эрдэнийн Батбаяр  
Даваадоржийн Ганболд  
Мэндсайханы Энхсайхан

## **Эрхлэн хэвлүүлсэн** **УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫН АКАДЕМИ**

---

Хаяг:

Сөүлийн гудамж – 22  
Брау хауз компаний байр, 2-р давхар  
Улс төрийн Боловсролын Академи  
Утас: 70110110

Э- шуудан: [shin\\_toli@academy.org.mn](mailto:shin_toli@academy.org.mn)  
[Httr://www.academy.org.mn](http://www.academy.org.mn)

## АГУУЛГА

• Д.Баярхүү	ШВЕЙЦАРИЙН ТӨВИЙГ САХИХ БА МОНГОЛ	6
• Ц.Бүжидмаа	ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ШИНЭТГЭЛ, АСУУДАЛ ШИЙДЭЛ	20
• А.Болормаа	ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, СУРГАМЖ	26
• Б.Батчулуун	“ТӨР БОЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА” ХЭМЭЭХ ДОМГИЙН ТУХАЙ, “МӨНГӨӨ АЛДСАНЫ БАЯР”	38
• Э.Гэрэлт-Од	МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛ, ХАНДЛАГА, ШИЙДЭЛ	47
• Ч.Лхагважав	УДИРДЛАГЫН ЁС ЗҮЙ	58
• Х.Батсуурь	МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ БҮТЦИЙН ГАЖУУДАЛ БА ХӨГЖИЛД ГАРСАН УХРАЛ	79
• О.Тунгалаг	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН	84
• М.Энхбат	МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ТӨЛӨВШИЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА	91





## *Мэнгүчилгээ*

*Улс төрийн Боловсролын Академи байгуулагдсаны 23 жилийн ойг тохиолдуулан тус Академид ажиллаж ирсэн үе үеийн захирал, эрхлэгч, багш, эрдэм шинжилгээний ажилтнууд, удирдах зөвлөлийн гишүүд болон ХБЧГУ-ын Конрад-Аденауэр Сангийн хамт олон, "Минэ толь" сэтгүүлийн редакци, "МБЕРЯМ" дээд сургуулийн эрдэмтэн, багш, судлаач нийт төгсөгч нартаа ойн баярын мэнд хүргэж, ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.*

УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫН АКАДЕМИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.ЭНХБАТ

2015.12.10  
УЛААНБААТАР ХОТ

## ШВЕЙЦАРИЙН ТӨВИЙГ САХИХ БА МОНГОЛ

*проф.Дашдоржийн Баярхүү*

### **Нэг. Европын улсын хувьд тэдний бодлого нь зөв**

УИХ-д өргөн баригдаад буй Монгол Улс байнга төвийг сахих тухай хуулийн III бүлгийн 1-р зүйлд “Энэ хууль нь Монгол Улс байнга төвийг сахихтай холбогдсон харилцаанд хамаарах бөгөөд тус улсаас бусад улстай улс төр, нийгэм, худалдаа, эдийн засаг, боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологи, хүмүүнлэг, батлан хамгаалах, гамшигтай тэмцэх зэрэг бусад салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэхтэй холбогдсон харилцаанд хамаарахгүй” хэмээн заасны үнэн мөнийг дэнслэхээр Швейцарийн Холбооны Улсын (ШХУ) ГХЯ-ны холбогдох нөхөдтэй зөвлөлдсөнөө дор толилуулж байна.

Төвийг сахина гэдэг нь Швейцарийн туйлын зорилго бус тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн халдашгүй дархан байдлыг нь хангах арга зам, төвийг сахих бодлого нь уян хатан байх ёстой. Манай улс байнга төвийг сахих бодлого сонгосноороо хоёр талын харилцаанд өөрчлөлт орохгүй төдийгүй харин ч эерэг талууд гарч ирнэ гэж тэд зөвлөж байв. “Хүйтэн дайн” дууссанаас хойш тус улс гадаад бодлогоо эрс идэвхжүүлсэн, ялангуяа олон улсын янз бүрийн мөргөлдөөн хямралыг зохицуулахад дипломат ур ухаан, авьяас чадвараа нээн ажиллуулж байгаа. Үүнд зааг, хязгаар, загварчлал байхгүй хэмээн өөрсдөө үздэг. Төвийг сахих зарчмуудаа ч уян хатан болгож байна.

“Швейцарийн нейтралитет” (Швейцарийн төвийг сахих) гэж онцгой, чухал, өвөрмөц бодлого байдаггүй, өөрөөр хэлбэл тус улсын гадаад бодлого, хамтын ажиллагааг хязгаарласан, боймлосон тусгай зүйл байддаггүй тул ямар гадаад бодлого явуулах нь өөрийнх нь үзэмжийн асуудал байдаг аж. Гэхдээ энэ улс нь аль ч цэргийн эвсэл, Европын Холбооны гишүүн биш. Харин Европт болон дэлхийн дахинд гарсан өөрчлөлтүүдийг гадаад бодлогодоо тусгахыг хичээх болсон. Европын Холбооны интеграц хүрээгээ тэлж буй тул төвийг сахих зарим зарчмаа зөөлрүүлж, 2001 онд Швейцарь-Европын Холбооны салбарын гэрээний эхний бүлэг гэрээ, 2004 онд хоёр дахь бүлэг гэрээ байгуулсан, үүгээр энэ улсыг Европын Холбоонд альтернатив байдлаар нэгдчихсэн гэж үздэг. 2005 онд явуулсан нийт үндэсний референдумаар Швейцарийг Шенгенийн гэрээнд оруулсан, гэвч Европын Холбоонд нэгдэх тухай асуудал бол стратегийн зорилт биш, зөвхөн хамтын ажиллагааны нэг боломж гарц юм гэх үзэл тэр улсад давамгайлсаар байна.

## **Хоёр. Дотооддоо төвийг сахисан туршлага**

“Швейцарь”, “Нейтралитет” гэдэг хоёр үг амьдрал дээр яг синоним үг болжээ. Швейцарийн эрдэмтэн Эдгар Бонжурын хэлснээр швейцарийн нейтралитет гэдэг ойлголт швейцарь улс үндэстэн үүссэн цаг үетэй хамт буй болжээ. XIII-XIV зууны үед феодалын олон гүнлэгүүд өвөр хоорондоо ширүүн тулалдаж, цус их урсаж байх үед «stille zu sitzen» (үгчилбэл номхон хүлцэнгүй, дуугүй сууж бай) гэдэг ийм нэг хэлц үг гарсан нь хожим нейтралитет буюу төвийг сахих гэж хэвшсэн аж. Швейцарь нь төвийг сахина гэдгээ тусгаар тогтнол, эв нэгдэл, Швейцарийн эрх ашгийг хамгаалах, өөрийн улс үндэстний онцлог төрхөө хадгалах гол хэрэгсэл, ялангуяа улс үндэстнээ нэгтгэх, зохион байгуулах нэгтгэгч үзэл суртал, конфедерацийн төрийн шинэчлэлд тулгуур үзэл хэмээн үздэг байна.

Тус улс 2324 коммун, тэдгээрийг нэгтгэсэн 26 кантонтой. Тэр 26 муж улс нь нэгдэж нийлээд нэг конфедерац буюу “Холбооны Улс”. Үндсэн хүн ам нь 4 хэлээр ярина: 64.9 хувь нь германаар, 22.6 хувь нь францаар, 8.3 хувь нь италиар, 0.5 хувь нь романш хэлээр, үлдэх 21 хувь нь гадаад хэлтэнгүүд. Бас олон шашинтантай: 38.2 хувь нь роман католик, 26.9 хувь нь протестант, 4.9 хувь нь лал, 7.3 хувь нь бусад шашин, 21.4 хувь нь шашингүйчүүд. Ийм олон аймаг, сум, хэлтэн, шашинтны улсад төвийг сахисан байдлаар л улс төрдөө хандсан байна.

Юуг хэлж байнав гэхлээр төр-засгийн бүтэц нь нэн энгийн, авсаархан, бүх төр, засаг нь нэг байшинд төвлөрсөн, холбооны улсын гүйцэтгэх засаглал нь Холбооны Зөвлөл, хууль тогтоох засаглал нь Холбооны Ассамблей, шүүх засаглал нь Холбооны Дээд Шүүх. Холбооны Зөвлөл буюу Засгийн газар нь 7 гишүүнтэй, 8 дахь гишүүн нь Холбооны канцлер. Тэр нь ЗГХЭГ-ын дарга нь бололтой. Ерөнхийлөгч гэж нэрлэгдээд байгаа хүн нь тэр улсын Төрийн тэргүүн биш гэхчлэн. Ерөнхийлөгч нь төр тэргүүлдэггүй цорын ганц улс л тэр байна.

## **Гурав. Авсаархан төрийн туршлага Монголд хэрэгтэй**

Авсаархан, цомхон төр гэдгийг ШХУ нь Ерөнхийлөгчгүй, Ерөнхийлөгчийн аппаратгүй, орон тооны нүсэр Засгийн газаргүй, байнгын бус гишүүд бүхий парламенттай гэдгээр хэлж буй хэрэг. Тус улсын Ерөнхийлөгч гээд байгаа тэр хүнийг нь ард түмнээс сонгохгүй, парламентаас нэг жилээр сонгоно. Тэрээр аль нэг яамны сайд байхын сацуу Засгийн газраа нэг жилээр тэргүүлнэ. Нэг жилийн настай танхимын тэргүүн. Танхимын дараагийн нэг сайд нь хойтон жил Ерөнхийлөгч болно. Бас нэг сайд нь Дэд ерөнхийлөгчийг ганц жил давхар хашина. Энэ мэт ээлжлээд байна. Одоогийн Ерөнхийлөгч нь Шүүх ба цагдаагийн яамыг 2010 оноос толгойлж буй хатагтай Симонетта Соммаруга. Тэрээр 2014

онд Дэд ерөнхийлөгчөөр хавсран ажилласан. Тэнд Холбооны Засгийн газрын яам нь “яам” гэж нэрлэгдэхгүй, Холбооны Департамент гэнэ, сайдыг нь “сайд” гэж нэрлэдэггүй, Холбооны зөвлөх гэнэ.

Энэ нь сайд дарга гэж онцгой эрх дархтай, нэр хүндтэй эрхмүүд байдаггүй, өөрөөр хэлбэл улс төрдөө төвийг сахиж буй хэлбэр нь тэр болох аж. Парламент нь хоёр танхимтай. Үндэсний Зөвлөлд нь 200 гишүүнийг 8.2 сая ард түмнээсээ пропорциональ санал хураалтаар 4 жилээр сонгоно. Төрийн Зөвлөлийн 46 гишүүнийг засаг захиргааны нэгж-кантонуудаас (муж улс) сонгоно. Хоёр танхим нь нийлээд Нэгдсэн Холбооны Ассамблей гэж нэрлэгддэг, дэлхий нийтийн жишгээр бол парламент нь. Парламент дахь суудлын тоогоор тэр 7 яамны сайд нь тодорно. Гэхдээ их хурлын 246 гишүүнийг улс тэжээж, цалинжуулж, тэднээр хууль тогтоолгож суугаа гэсэн үг биш. Бүгд дор бүрнээ хийдэг үндсэн ажлаа (багш, эмч, хуульч, инженер, банкир, фермер, төрийн албан хаагч, урлаг соёлын гэх мэт) хийгээд явна, чуулгандаа ирж оролцоно. Эндээс ажвал төр-засаг нь ч төвийг сахих нэрэндээ тохирсон мэт. Үнэндээ тэнд албан тушаал сонин биш юм байна. Төр-засгийг хэн ч сонирхохгүй.

Харин швейцарьчуудын байнга хийдэг, залхвал залхмаар нэг айхтар ажил байна. Тэнд байн байн ард нийтийн санал хураалт явуулна. Барилга байшин барих, зам тавих, гүүр барих нураахаас эхлээд НҮБ-д элсэх хүртэл бүх асуудлаар ард түмнээр шат шатанд санал хураалгаж байна. Консенсус ба компромисс гэдэг синоним үгс нийгэмд хэвшсэн. Нийтийн тохиролцоо ба буулт хийлт гэж буулгаж болно. Энэ нь ч төвийг сахисных нь бэлгэдэл, үр дүн ажгуу.

### **Дөрөв. Харьцуулах адил ба адилгүй тал**

Монголыг тус улстай харьцуулж, тэдний төвийг сахисан туршлагыг цаашдаа Монголын төвийг сахих бодлогод бүтээлчээр хэрэглэх тухайд эхлээд өнгөрсөн түүх, газар зүйн ба геополитикийн байршил, улсын жин нөлөөгөө харилцан авч үзэх шаардлагатай.

Түүхэн адил тал: Хоёул далайд гарцгүй, эх газарт түгжигдсэн. Хоёул их гүрнүүдээр хүрээлэгдсэн, хүрээлэгдэж явсан, хоёул жижиг улс. Монголд Орос, Хятад гэж хоёр гүрэн хөрш нь байж ирсэн. Түүхнээ энэ хоёрын эрхшээлд орж, чирэгдэж, зөрчил мөргөлдөөнд нь нэг талд нь цэргийн холбоотон болж, нөгөөхийг нь эсрэг дайнд бэлтгэж байлаа. Швейцарь нь түүхэн нэгэн үед Герман, Франц, Австри-Унгар, Итали гэсэн 4 гүрний хүрээлэлд, ялангуяа Герман, Францын хөлд чирэгдэн, тэдний өвөр хоорондын дайнд татагдаж орох, дагалдан дайнд орох, тэдэнд ялагдах эзлэгдэх, эсвэл нутгаа ашиглуулах эрсдэлтэй олонтаа тулгарч байсан зэрэг шалтгаанаар төвийг сахихаас аргагүй байдалд орсон гэж швейцарьчууд үздэг.

Түүхэн адилгүй тал: Швейцарь нь колонийн гүрэн байгаагүй, эзэнт гүрэн байгаагүй, тийм түүхгүй учраас төвийг сахихад илүү хялбар байсан бололтой. Түүхэндээ ямагт жижиг, ядуу, буурай улс байсан, цэрэг тэжээх зардалгүй байснаас дайн тулааны хөлд нэрвэгдэхгүй гэж, тэсч үлдэхийн тулд л төвийг сахисан, бас дотооддоо эв нэгдлээ бэхжүүлэхийн тулд төвийг сахисан гэж тэд ярьж байна. Тэгвэл Монгол бол дэлхийн түүхнээ эзэнт гүрэн явсан, ХХ зуунд Монгол нь хувьсгал, тэмцэл, хэлмэгдэл, дайн тулаанд оролцсон, нутагтаа дайн хийлгүүлсэн, “Хүйтэн дайн”-ы фронтын дорнод жигүүр явсан, хоёр хөршийн геополитикийн өрсөлдөөнд шатрын хүү болж явсан, герман эрдэмтэн Даниел Шмюкингийн онож хэлснээр, энэ орныг хоёр их хөрш—БНХАУ, ОХУ-ын зүгээс сүүдэрт шахаж байсан тохиолдол дэндүү олон юм.

ХХ зууны түүхэн их үйл явдлын өртөлтийн үе буюу дэлхийн II дайн, “Хүйтэн дайн” (1938-1990 он) Швейцарьт ёстой падгүй мэт өнгөрсөн бол Монгол нь энэ үед л чухам гоцолсон, өөрийгөө ч зөвшөөрүүлсэн, хөгжил дэвшил энэ үед жигдэрсэн. Харин “Хүйтэн дайн” дууссанаас хойш хоёул гадаад бодлогоо нэн идэвхтэйгээр явуулах болсноороо адил тал дахин давтагдана. Швейцарь нь төвийг сахих уламжлалт, тууштай бодлогоо шинэ агуулга хэлбэрээр баяжуулсан бол Монгол нь олон тулгуурт, идэвхтэй, тэнцвэртэй, прагматик бодлогоо ерөнхийдөө төвийг сахих хэлбэрээр шинэ шатанд гаргасан. Түүнийгээ ч хууль тогтоомжоороо баталгаажуулан мөрдөж байна.

### **Тав. Ранжан Гуптаг надтай андуурсан нь**

Монголдоо анхных нь болох геополитикийн онолын судалгааны нэгэн сэдэвт бүтээл 2002 онд миний бие туурвисан юмсан. Энэ ном гурван удаа хэвлэгдсэн, хэвлэх тоолонд нэмж баяжуулаад эцэст нь PhD горилсон бүтээл болгон ШУА-д өргөн барьсан. Мартагдаад 10 гаран жил болсон энэ бүтээлийг маань саяхан судлаач нэгэн бээр сөхөж, түүнийг нь “Монгол HD TV” эшлэн авч зохиогч намайг ам асуух маягаар мэдээлэл болгон цацжээ. Юу гэвэл Д.Баярхүү гэдэг нөхөр үзэл бодлоосоо ухарчээ, тэрээр төвийг сахихыг эсэргүүцэж байснаа одоо дэмжигч болсон байна гээд миний номоос үг үсэг гээлгүй эшлэжээ.

Тэр нь “Төвийг сахих Швейцарь загвар Монголд тохирохгүй (Ранжан Гупта)” гэсэн гарчгаар хүснэгтэд дараахи гурван өгүүлбэр байгаа: Швейцарийн хөршүүд түүнд хандаж байсан шиг Монголын хоёр хөрш Монголд тэгж хандаж байгаагүй; Төвийг сахина гэдэг нь тэр улс төвийг сахих амлалтдаа зайлшгүй үнэнч байхын сацуу эргэн тойрных нь улсууд хууль тогтоомж, үзэл баримтлалаараа төвийг сахисныг нь хүндэтгэсэн байх учиртай; Тэгвэл тийм хүндэтгэлийг бүрэн эрхт улсынх нь хувьд Монголд хоёр хөрш нь хэзээ ч үзүүлж ирээгүй гэжээ.

Энэ бол 1998 онд энэтхэг эрдэмтэн Ранжан Гуптагийн анхааруулах зөвлөх байдлаар бидэнд хандаж хэлсэн, Монгол-Энэтхэгийн эрдмийн II бага хуралд түүний хэлэлцүүлсэн илтгэл дэх мөрүүд юм. Тэр хурал 1998 оны 12 дугаар сард Нью Делид зохиогдоход би оролцож, зохион байгуулалцаж, мөн илтгэл хэлэлцүүлж байсны хувьд, мөн надад энэ дүгнэлт нь маш чухал санагдсан тул би хожим номдоо эшлэн оруулж, хаалтанд зориуд тэр эрдэмтний нэрийг бичсэнийг маань миний амыг асуугчид анзаарсангүй юу, хэргээр мэдэн будилав уу. Үнэндээ Р.Гупта доктор яг л зөв хэлжээ. Тэрээр Монголын хоёр хөршийг “өршөөлгүй” хэмээн тодотгож байв. Тэр бас яг зөв мэдэрчээ. Монголын гадаад бодлого ямар нэгэн хэмжээнд төвийг сахисан хандлагатай байна, хэтдээ төвийг сахихаа зарлах магадлалтай гэж тэрээр үзсэн бололтой. Тийм учраас энд анхааруулга, зөвлөлөгөө байдлаар бидэнд хандаж хэлсэн гэж орууллаа.

### **Зургаа. Цаг үе нь чухам мөн**

Монгол Улс байнга төвийг сахих статусаа тунхаглах цаг үе нь мөн үү, арай түргэдэв үү, эрх зүйн болон бодлогын үндэслэл гүйцэт үү гэх асуулт зарим нөхөд тавьдаг. Түүн дээрээ ч хатуу зогссоор буй. Хоёр хөрш юу гэхнэв гэсэн битүү айдас, болгоомжлолоо тэд аргумент болгодог.

Үүнд эргэлзэхгүйн үүднээс Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн эл санаачилга, түүнийгээ илэрхийлсэн нийтлэлийг эргэж сөхөж үзэхийг нөхдөд зөвлөж байна. “Юу гэвэл Монгол Улс төвийг сахих бодлого баримтлах тухай ярьж хэлэлцэхдээ бид юуны түүрүүнд доорхи хүчин зүйлүүдийг бодолцох нь зүйтэй” гэж тэрээр бичихдээ гурван үндэслэл гаргаж ирсэн байна. Үүнд:

- 1) Монгол Улс шинэ, ардчилсан Үндсэн хуулиа баталснаас хойш төвийг сахих бодлогыг агуулгын хувьд идэвхтэй хэрэгжүүлж иржээ. Харин хэлбэрийн талд түүнийгээ тунхаглаагүй байгаа юм. Энэ бодлогоо хэлбэржүүлж, баталгаажуулах үйл явц нь манай улсын хувьд зөвхөн цаг хугацааны асуудал болоод байна;
- 2) Манай улсын туулж ирсэн түүх, газар зүйн байршил, сонгож авсан замын онцлог, эрх ашигт төвийг сахих статусын зарчим, мөн чанар нийцэж байгаа юм. Уг бодлого нь тухайн оронд бусад улстай эрх тэгш, тэнцвэртэй харилцах боломж олгодог. Мөн бусад улс орон, олон улсын байгууллага ч тийм бодлогод хүндэтгэлтэй ханддаг;
- 3) Олон улсын байдал, дэг журам цагийн эрхээр өөрчлөгдөж, шинэчлэгдэх нь бий. Харин төвийг сахих үйл ажиллагаа нь хамгийн тогтвортой ордог. Учир нь уг статусыг хэрэгжүүлэгч улс оронд л тухайн бодлогоо засварлах, шинэчлэх, зогсоох онцгой бүрэн эрх хадгалагддаг гэжээ.

“Төвийг сахих бодлогыг агуулгын хувьд идэвхтэй хэрэгжүүлж иржээ” гэсэн дээр нь тогтож харахыг нөхдөд дахин зөвлөө.

Төвийг сахичихтай зэрэг манай гадаад бодлого хумигдаад, худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагаа зогсоод, ахмад нэгэн дипломатчийн хэлснээр, манай улсын гадаад бодлогод өөрчлөлт орж, төвийг сахина гэдэг олон асуудлаас хөндийрнө гэсэн үг, манай Монгол хөгжиж байгаа орнуудын дунд явдаг, хөгжиж байгаа орнуудын эгнээнд явах нь бидэнд ашигтай, ийм асуудлаас хөндийрнө гэсэн үг, Монголыг зарчимгүй, туйлбаргүй гэж үзэх улс орнууд гарч ирж байна гэж байгаа бол яг тэгдэг үү гэсэн асуултыг бид Берн хотод ШХУ-ын ГХЯ-нд зочлон байхдаа тавьж, хариулт авлаа. Юу гэвэл төвийг сахиснаараа дэлхий нийтийн болон бүс нутгийн ноцтой хурц асуудлаас өөрийгөө татаад авчихаж байгаа хэрэг бус, харин ч эвсэл бүлгийн эрх ашиг, нэгдмэл байр суурь гэхгүйгээр өөрийн байр сууриа илэрхийлэх эрхээр бүрэн хангагдана гэлээ. НҮБ дахь санал шүүмжлэл, санал хураалт, тогтоол санаачлах, хамтран оролцох эрхийг нь төвийг сахисан улс дээр хязгаарлана гэсэн заалт НҮБ-ын Дүрэмд байхгүй. НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Аюулгүйн Зөвлөл, хороодод жил бүр яригддаг хэдэн зуун (400 гаруй тогтоол, шийдвэр) асуудал бүрт манай улс байр сууриа илэрхийлж идэвхи зааж байх нь орчин цагийн манай гадаад бодлогын гол, чухал зорилт огтоос биш юм. Хөгжиж буй орон бүрийн төлөө дуу хоолойгоо нэмэрлэнэ гэдэг бүтэшгүй зүйл. Энэ бүхэнд хүчээ тарамдуулахгүй, харин эе эвийг сахиулах, зуучлах чиглэлээр олон талт дипломат бодлогоо төлөвшүүлбэл зөв болов уу. Ер нь энэ асуудалд “Хүйтэн дайн”-ы баригдмал сэтгэхүйгээр, НҮБ-ыг үзэл суртлын индэр болгон хэрүүл өрнүүлдэг тэр арга барилаар хандах бус ихээхэн уян хатан хандахыг зөвлөж байна.

ШХУ-ын хувьд идэвхтэй гадаад бодлого явуулдаг. Чингэхдээ улс гүрний хоорондын энх тайван, аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, улмаар улс орнуудын хөгжилд нь эерэг нөлөө үзүүлэх зэрэгт нэн тэргүүнд ач холбогдол өгдөг. Эдийн засгийн идэвхтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих зэргээр дамжуулан төвийг сахих бодлогоо баталгаажуулдаг гэж тэд ярьж байна. Тэдний хувьд эдийн засгийн ба хөгжлийн тусламж үзүүлнэ гэдэг нь дэлхийн энх тайвныг бататгаж байгаа, цаашлаад төвийг сахих бодлогод нь нийцэж буй явдал. Энэ ч хүрээнд тус улс бүхий л салбарын хөрөнгө оруулалтыг дэмжсээр ирсэн, үүний нэг илрэл бол Швейцарийн хамтын ажиллагаа, хөгжлийн агентлагийн үйл ажиллагаа хэмээн бахархан ярьцгааж байна. ШХУ нь НҮБ-ын мандаттай болон мандатгүй энхийг сахиулах ажиллагаанд оролцдог, НАТО-гийн энхийн төлөө түншлэлд оролцдог, батлан хамгаалахын өргөн хамтын ажиллагаатай улсын хувьд энэ бодлого нь төвийг сахисан статуст нь огтхон ч саад болоогүй гэж тайлбарлаж, нотолж байна.

## **Долоо. Швейцарь хэрхэн баталгаажив?**

ШХУ нь 400 жил төвийг сахих бодлого явуулсан, 200 жилд нь бусад улс орнууд төвийг сахисныг нь хүлээн зөвшөөрсөн ба түүх сөхвөл анх XIII зуунд буюу 1291 онд анхны гурван кантон нэгдэж нийлээд анхны төрт-улсаа байгуулсан, XVII зуунд буюу 1648 оны Вестфалийн энх тайвны гэрээгээр Швейцарийн Холбоог төрт-улс хэмээн анх удаа эргэн тойрныхон нь хүлээн зөвшөөрч, 1815 онд Парисын гэрээ, Венийн конгрессоор Швейцарийн төвийг сахисан байдлыг хүлээн зөвшөөрчээ. Швейцарийн байнга төвийг сахих болон түүний хил хязгаарын халдашгүй дархан байдлыг 1815 онд Венад ийнхүү Европын 4 гүрэн үндсэн гэрээнийхээ дагалт эрх зүйн хавсралт баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан. Ингэснээр тус улсын оршин тогтнох, хөгжих дэвжих нь гадны сөрөг нөлөөллөөс ангижирсан гэсэн үг. Төвийг тухай анхлан олон эрх зүйн талаар заасан түгээмэл хууль болох 1907 оны хоёр конвенцид ШХУ 1910 онд нэгдэж оржээ. 1919 онд Версалийн энх тайвны гэрээнд Швейцарийн төвийг сахисан байдлыг дурдаж тусгажээ. Дараа нь энэ улс Үндэстнүүдийн Холбоонд элсэж 1920-1938 онд түүний гишүүн байжээ. Тэгснээ 1938-1990 онд дэлхийн II дайн ба “Хүйтэн дайн”-д тууштай төвийг сахижээ. 1990 оноос идэвхтэй гадаад бодлого явуулсаар өнөөг хүрсэн. Харин бүр сүүлд 2002 онд НҮБ-д элсэж, төвийг сахисан улс гэдгээ дэлхий дахинд тунхаглажээ. Гэхдээ тэнд төвийг сахих тухай тусгай хууль, эсвэл Үндсэн хуулийн заалт, үзэл баримтлал гэж баримт бичиг алга байна.

Холбооны Үндсэн хуулийнх нь “Гадаад хэрэг” гэсэн 54-р заалтад “Швейцарийн тусгаар тогтнолыг хамгаалж, түүний сайн сайхан байдлын төлөө Холбоо ажиллана, тухайлбал даян дэлхийд хэрэглээ ба ядуурлыг бууруулах, хүний эрхийг хүндэтгэх, ардчиллыг хөхиүлэн дэмжих, улс түмнүүд энх амгалан орших, бодит амьдралын үндсийг хадгалахад Холбоо дэмжлэг үзүүлнэ” гэснээс өөр заалт алга. Харин “Гадаад бодлогын стратеги 2012-2015” гэсэн бодлогын баримт бичигт нь төвийг сахих тухай заалт бол байна. Үндсэндээ 1815 оны Парисын гэрээ, 1907 оны Хаагын хоёр конвенц, мөн олон улсын заншлын эрх зүйгээр төвийг сахих статусаа баталгаажуулсан байна. Салбарын хуульгүйгээр өдөр тутмын шийдвэржээ хэрхэн гаргадаг талаар бид тодруулахад төвийг сахих өдөр тутмын бодлоготой холбоотойгоор шийдвэр гаргах шаардлага үүсэхэд холбогдох чиглэлийн төрийн байгууллагуудаас санал авч ГХЯ-ны Олон улсын эрх зүйн газар эцсийн шийдвэрийг гаргаж асуудлыг зохицуулдаг хэмээн тайлбар өгч байв.

## **Найм. Зуучлалын оршил түүх**

Хельветийн (Швейцарийн) Холбооны Үндсэн хуулийг 1803.02.19-нд Наполеон Бонапартад швейцарийн комиссар ёс төртэй гардуулжээ. Хоёр талаасаа буулт хийх замаар эл Үндсэн хууль эцэслэгдэж улс оронд амгалан

тайван байдал тогтсоныг тэр үед германаар Mediationszeit, францаар Acte de mediation буюу “Зуучлалын гэрээ” хэмээн нэрлэсэн нь эдүгээ хүртэл хэвшиж хэрэглэгдэж буй. Швейцарь нь ийнхүү 19 кантоноос бүрдсэн холбооны төрт-улс болжээ. Гадаад болон дотоод аюул дэгдсэн тохиолдолд кантонууд нь бие биедээ тусламж үзүүлэх ёстой, өвөр хоорондоо дайтах эрхгүй, кантон нь өвөр хоорондоо болон гадаад бусад улстай гэрээ байгуулах эрхгүйг Холбооны Үндсэн хуулиар тунхаглажээ. Кантон нь дотооддоо өөрийгөө удирдах эрхээр бүрэн хангагдана.

1803.09.27-нд Швейцарь ба Франц нь Батлан хамгаалах ба давшилтын холбооны гэрээ гэдгийг байгуулснаар Францын армид 16 000 цэрэг илгээж алба хаалгах үүрэг хүлээж, энэ нь ч Швейцарьт хүнд дарамт болж, Наполеоны цэргийн үйлдвэрийг нутагтаа байгуулснаар вассаль улсын зовлонг амсав. Ийнхүү хаширсан Хельвет улс 1813 онд Лейпцигийн тулалдааны дараа Сеймээ хуралдуулж төвийг тууштай сахихаар зориг шулууджээ. Үүнийгээ ч дайтагч Европын гүрнүүдэд албан ёсоор мэдэгдэв. Тэр даруйд нь Оросын Александр I хаан Швейцарийн нейтралитетыг дэмжихээ илэрхийлж, харин Швейцарьт хяналтаа тогтоох далд санаархал бүхий, тэр утгаар Швейцарь дахь либерал хөдөлгөөнийг өөгшүүлэгч Австри нь Швейцарийн төвийг сахихыг дэмжсэнгүй. 1813.12.21-нд австрийн цэрэг Швейцарийг тойрч Рейн мөрнийг гатлан Франц руу дөхөж иржээ. Тэгэхтэй зэрэг өмнө нь засгийн эрхнээс зайлуулагдаад байсан австрийг талархагч аристократ засгийнхан толгойгоо өндийлгөн Берн, Фрибур, Золотурн, Люцерн кантонд засгийн эрхийг эгүүлэн авч, харин Холбооны Сейм нь 29-нд Цюрихт тусдаа цуглаад өмнөх зуучлалын гэрээгээ хүчингүй болгов. Берн тэргүүтэй 7 кантон Цюрих дэх Сеймтэйгээ тэрсэлдэн, Люцерн хотод өөр нэг Сеймийг байгуулав. Швейцарь орон хоёр хуваагдаж, дотооддоо иргэний дайн, хямралтай тулсан учраас их гүрнүүд хөндлөнгөөс оролцож, ялангуяа Оросын император шахалт үзүүлсний дараа Люцерний Сеймийг тарааж, эсэргүү кантонууд Цюрихийн Сейм рүү төлөөлөгчдөө илгээжээ.

Ийнхүү эргэж эвлэрэв. 1814.09.07-нд 19 кантоны төлөөлөгчид Холбооны шинэ гэрээ боловсруулж, Венийн конгресст (Венийн энх тайвны бага хурал) өргөн барьж, их гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлжээ. Венийн конгрессоос 1815.03.20-нд батлан гаргасан тунхаглалаар Швейцарийн Холбооны мөнхийн нейтралитетыг хүлээн зөвшөөрч, тус улсын хил хязгаарын бүрэн бүтэн байдал, халдашгүй дархан байдлыг баталгаажуулжээ. Дараа нь 19 кантон дэр Вале, Женев, Нёвшатель хот-мужууд Холбоонд нэгдэн орж 22-уулаа болжээ. Хэдийгээр тэд төвийг сахисан ч Наполеоныг эргэж төр барьмагц Францтай дахин дайнд татагдан орж, Парисын энх тайвны гэрээгээр дайны төлбөрт 3 сая франк, бяцхан газар нутаг авч салжээ. Төвийг сахихын өмнөх ба эхэн үеийн товч түүх ердөө энэ.

## Ес. Зуучлал буюу Mediation

Онолын талаас авч үзвэл арилжаа, санхүүгийн ажиллагаан дээр хөнгөлөлт үзүүлэх, эсвэл янз бүрийн харилцааны маргаантай асуудлыг зохицуулах хуулийн (гол төлөв байгууллага) ба бие хүн этгээдийн үйл ажиллагаа гэх тайлбар олон тааралддаг. Энэ ухагдахууныг тайлбарласан явдал лавлах ном, нэвтэрхий толиудад олон буй. Тэдгээрээс түүвэрлэсэнээ товчлон сонирхуулбал, маргаантай асуудлыг альтернатив хэлбэрээр зохицуулах технологийн нэг хэлбэр буюу олон улсад хэвшсэн нэршил үг нь медиац (англиар Mediation буюу alternative dispute resolution). Медиац хийх этгээдийн гол шалгуур вэ?

Уг маргаанд нь 1) оролцоогүй, 2) холбогдолгүй, 3) туйлширдаггүй, 4) төвийг сахисан гурав дахь этгээд (субъект) байх ёстой. Медиаторын үндсэн үүрэг нь маргаантай асуудлаар тодорхой оновчтой гэрээ, хэлэлцээр боловсруулахад туслах явдал. Харин уг баримт бичиг байгуулагдмагц хэрэгжилтэд нь маргалдагч асан хоёр тал хяналт тавих үүрэгтэй.

Маргалдагч талууд үндсэн нөхцлөө тавина, түүнийг нь гурав дахь медиатор анхааралдаа авна, маргаанаа эв зүйн аргаар шийдвэрлүүлэхээр талуудыг хэлэлцээний ширээнд суулгах зуучлагчийн тэр арга хэрэгслийг зуучлал хэмээмүй гэж олон улсын эрх зүй заадаг.

Хоёр буюу түүнээс олон субъектэд нейтраль субъектаас үзүүлэх нөхцөл, хөнгөлөлт, эвлэрүүлэх процедурыг ийнхүү “зуучлал” гэх ба хэлбэр нь олон янз байж болно. Тухайлбал маргалдагч талууд харилцан хүлээн авч болохуйц нөхцөл болзол, эсвэл бүх асуудлыг “0”-тэгээс эхлэх, маргалдагч талуудын хүсэлтээр зуучлах үүрэг хүлээх, маргаанд оролцоогүй их гүрнүүдийн санаачилгаар ийм үүрэг хүлээх гэх мэт. Энэ тухай 1899, 1907 оны Хаагын конвенц, НҮБ-ын Дүрэмд (33-р зүйл) тодорхой заажээ.

Швейцарийн гадаад бодлогод “найрсаг нөхцөл”, “сайн санааны болзол” гэх ухагдахуун байна. Тэр нь маргалдагч хоёр этгээдийн дунд гуравдагч этгээд болон оролцох гэсэн утга бүхий. Тус улсын зуучлах үүрэг олонтаа хэрэгжиж, амжилтад хүрч ирсэн. Швейцарийн Гадаад хэргийн сайд Дидье Буркхальтерын хэлснээр бол, тэрхүү «сайн санааны нөхцөл болзол» гэдэг нь энэ Конфедерацийн гадаад бодлогын үндсэн чухал хэсэг ажээ.

Дотооддоо кантонуудын хооронд зуучилж байснаас дээр цухас дурдлаа. Тэр тушлага дээрээ тулгуурлан хожим түүхнээ олон улсын томхон зуучлалыг 1870-1871 онд франц-германы дайны үед хэрэгжүүлжээ. Бүслэгдсэн Парист Бавар, Бадены гүнт улсын эрх ашгийг швейцарийн нэрт дипломатч Иоханн Конрад Керн анхлан төлөөлж гүйцэтгэсэнээс Швейцарийн олон улсын зуучлалын түүх эхэлдэг. Зөрчилдөгч хоёр улс дипломат харилцаагаа таслах үед тэдний

аль алин нь нейтраль зуучлагчийг хайдаг ба сонголт ямагт Швейцарь дээр бууж байсан түүхтэй.

### **Арав. Манай гадаад бодлогод нэмэгдэх зуучлалд Швейцарийн туршлага**

Швейцарь эрдэмтэн Даниэль Тракслер “Швейцарийн зуучлах үүрэг, уламжлалын сэргэлт” (“Schutzmacht Schweiz. Renaissance einer Tradition?”) номоо 2012 онд хэвлүүлжээ. Түүнд тус улсын арбитражийн зуучлах үүрэг багассан гурван шалтгааныг тоочжээ. Зуучилж өгнө үү гэх эрэлт хүсэлт багассан нь:

- 1) “Хүйтэн дайн” дууссанаар өмнө нь таслагдсан байсан олон харилцаагаа улс гүрнүүд өөрсдөө сэргээсэнтэй холбоотой.
- 2) Одоо ихэнхи мөргөлдөөн улс хоорондын түвшинд гэхээсээ, тодорхой улс орнуудын дотоодод дэгдэж байна. Мөргөлдөөнд улс орны зэвсэгт хүчин гэхээсээ хагас цэрэгжсэн төрийн бус бүлэглэлүүд оролцох боллоо. Тэдэнд дипломат зуучлагч төдийлөн хэрэг болохгүй.
- 3) Үүрэг багассанд Швейцарь өөрөө бас буруутай. Өөрт ач холбогдолгүй, цаадулдаа ч ач холбогдолгүй зарим мөргөлдөөнд “сайн санааны нөхцөл бозлол” дэвшүүлж 1990-ээд оны сүүлчээр оролцсон нь бас нэг шалтгаан хэмээн Д.Тракслер бичжээ.

Ийнхүү 1990 оноос хойш Швейцарийн зуучлалын цар хүрээ, давтамж багассан, цөөрсөн бол XXI зуун гараад глобал бодлого, глобал дипломатын ажил хэрэгт арбитражийн үүрэг дахин нэмэгдэж Швейцарьт медиацын үүрэг уламжлалаа сэргээх аятайхан боломж гарч ирлээ, үүнийг шүүрээд авах нь чухал хэмээн эрдэмтэн Д.Тракслер үзэж байна. Тэгж шүүрч авч оновчтой зуучилсан нь Орос-Гүржийн 2008 оны зэвсэгт мөргөлдөөн болжээ.

Энэ улс 1938-1990 онд төвийг тууштай (хэт удаан байж болно) сахисан боловч энэ үед зуучлалын “алтан эрин” тохиосон гэж үздэг. Ялангуяа “Хүйтэн дайн”-ы эринд сөргөлдөгч талууд Швейцариар зуучлуулсан, Швейцарьт уулзаж маргаанаа зохицуулсан баримт маш олон. Энэ улсыг тойрч дэлхийн нэг ба II дайн өрнөхөд дайн хийгээгүй цус урсгаагүй энэ улсын нэр хүнд аяндаа өсч, тийшээ хандах ядарсан зүдэрсэн хүн ардын цуваа үл тасран, II дайнаас хойшхи олон улсын олон зэвсэгт мөргөлдөөнд Швейцарь нь гурав дахь этгээд болж зуучилсан олон жишээ бий юм билээ. Тэр болгонд гадаад бодлого дээрээ нэмэх оноо авч байсан байна. Тухайлбал дэлхийн II дайнд энэ улс татагдан оролцоогүй хэрнээ нутаг дээрээ зуучилж олон бага хурал, уулзалт, хэлэлцээг зохион байгуулж байжээ. 1943-1944 онд дэлхийн 35 улс оронд тус хүргэсэн 219 зуучлалыг гүйцэтгэжээ. Ингэхдээ төвийг сахих имижээ зөв ашигласан

гэж байна. “Хүйтэн дайн”-ы үед “Швейцарьт уулзацгаая” гэх эрэлт хүсэлт огцом өссөн байна. Солонгосын дайн, Вьетнамын дайн, Афганистаны дайныг дуусгасан олон талт яриа хэлэлцээ, Зөвлөлт-Америкийн хооронд стратегийн довтолгооны зэвсэглэл хорогдуулах олон шатны хэлэлцээ, “Хүйтэн дайн”-ыг дуусгах эхлэл тавьсан Горбачев-Рейганы анхны уулзалт бүгд Швейцарьт болж байв.

Тэр утгаар Швейцарь нь сонгодог, үнэмлэхүй зуучлагч байх эрхээ эгүүлж олж авч байгаа аж. Үүнийг зөвтгөх нотлох олон шинжийг агуулдаг хэмээн эрдэмтэн Д.Тракслер үзээд жагсаажээ.

- Швейцарь—жижиг улс, тэр утгаар хэнд ч аюул занал учруулахгүй.
- Швейцарь—ямар нэг онцгой, хувиа хичээсэн зорилго бүхий гадаад бодлого явуулдаггүй. Тэр утгаар Швейцарь нь олон улсын тавцанд “худалдааны жинхэнэ шударга зуучлагч” гэсэн имижтэй.
- Швейцарь—НАТО-д ордоггүй, Европын Холбооны гишүүн биш, колоничлогч гүрэн явсан түүхгүй.
- Швейцарь—сөргөлдөгч бүх талтай хэлэлцээ хийх ур ухаан чадавхитай.
- Швейцарь—хэлэлцээ явуулахад бэлтгэсэн дэд бүтэцтэй, санхүүгийн хангалттай боломжтой.
- Швейцарь—цөөнхийн эрх ашгийг хамгаалах талаар туршлагатай.
- Швейцарь—ардчилал, федерализмыг хэрэгжүүлэх талаар гойд ажилласан туршлага ба нэр хүндтэй гэхчлэн.

Дайн мөргөлдөөнөө зогсоох утгаар бус өөрийн иргэдийн эрх ашиг ба үндэснийхээ ашиг сонирхлыг Швейцарьт итгэж даатгана гэдэг утгаар 1961 оноос АНУ-ын эрх ашгийг Кубад Швейцарь төлөөлж иржээ. Тэгснээ 1991 оноос Кубын эрх ашгийг АНУ-д мөн төлөөлж байв. Энэчлэн Египетэд Ираныг, Иранд АНУ-ыг, тэр 2008 онд Гүржид Оросыг, Орост Гүржийг гэхчлэн төлөөлжээ.

Тэгвэл “Монгол Улс байнга төвийг сахих тухай хууль”-ийн төвийг сахих бодлогын үндсэн зарчмууд хэмээх хэсэгт: 8.1. Монгол Улс даян дэлхийн болон бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг сахин бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ; 8.3. Дайны үед энх тайван тогтоож, сөргөлдөгч талуудыг эвлэрүүлэх зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хэлэлцээ хийх бололцоог хангах эрхтэй; 8.4. Монгол Улс бүс нутгийн болон дэлхийн хэмжээний тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бүх нийтийн үйл хэрэгт хувь нэмэр оруулахыг чармайна гээд Швейцарийн зуучлалын туршлагыг Монголд хэрэглэх бодлогыг шууд заагаад өгчихсөн байна. Энэ нь бодлогын заалт, бас зөвтгөх үндэслэл.

Нэгэнт л төвийг сахиж байгаа бол төвийг сахисан, энхийг эрхэмлэгч Монголд мөргөлдөгч талууд хандахыг үгүйсгэж болохгүй. Солонгосын хоёр улстай хоёулантай нь найрсаг харилцаатайн хувьд энэ асуудал босч ирж болно. Өмнө нь БНАСАУ ба Японы хооронд зуучилж байсан туршлага бидэнд бас бий.

### **Арваннэг. “Дружественное молчание”**

Энэ орос үгийг махчлан буулгавал “Найрсгаар амаа үдүүлэх”, “найрсгаар хэлээ хазах”, эсвэл “найрсгаар гөлийх” гэдгийн алин нь ч болно. Учир нь оросын бөмбөгдөгч онгоцыг турк сөнөөгөөд Орос-Туркийн хооронд нэг үгээр “Хүйтэн дайн” дэгдээд, Оросын тал ОДКБ (Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага) буюу цэрэг-улс төрийн эвслийн холбоотон Казахстан, Белорусс, Армен, Киргиз, Тажикистанаас дэмжлэг авах гээд, гэтэл цаадуул нь “Найрсгаар амаа үдүүлчихээд” байгаа бололтой юм. “Харамсалтай байна”, “Орос өөрөө учраа олог”, “Орос-Туркийн хооронд хүлцэл тэвчил зааж, хэлэлцээний аргаар асуудлаа шийд” гэх ерөнхий үгээр оросын чин хүслийг холбоотнууд нь хариулж байгаа аж. Уг нь ОДКБ байгууллагын дүрмийн дагуу олон улсын терроризмтой тэмцэхэд бүх гишүүд хүч чармайлтаа зохицуулж, нэгтгэнэ гэж заасан боловч Оросоос бусад ОДКБ-ын бусад гишүүд нь Туркийг олон улсын терроризмын хань хамсаатан гэж Орос шиг үзэхгүй, оросын онгоцыг сөнөөснийг түрэмгийллийн хэлбэр хэмээн үзэхгүй гүрийж байна. ОДКБ-ын Парламентын ассамблейг Петербургэд хуралдуулаад ОХУ санасандаа хүрсэнгүй. ОДКБ дахь холбоотнуудынхаа шийдвэргүй хулчгар байдлыг оросууд гайхахын цаагуур гайхжээ.

Энд Орос-Туркийн харилцааны хямрал ба ОДКБ эвслийн тухай оруулж байгаа жишээ бол хэтдээ төвийг сахих Монголд ямар байдлаар тусах вэ гэдэгт эргэцүүлэл хийх, шийдэл хайх гэснийх юм. ОДКБ эвсэлд төвийг сахих статустай улс нэг ч байхгүй атал тэд “Дружественное молчание” гэдгээр төвийг сахих байдлаа илэрхийлсэн байна. Тэд Турктэй тогтоосон харилцаагаа сүйтгэхийг хүсэхгүй байна.

ТУХН, Евразийн эдийн засгийн холбоо, ОДКБ эвсэлд багтдаг Оросоос бусад бүх улсууд нь Орос-Украины хямралын үед төвийг сахисаар байгааг бас анхаарах хэрэгтэй.

Оростой харилцаагаа хурцатгах хэрнээ оросын нутаг дэвсгэрийг тойруулан ачаа бараа Европ руу зөөвөрлөх төслийг Турк хуучин СССР-ийн БНУ-уудтай хэрэгжүүлж байгааг бид харж байна. Ирэх онд Баку-Тбилиси-Карс гэх төмөр замын салаа ажиллаж, хэдэн мянган контейнер зөөвөрлөнө. “Транссибирь”-тэй өрсөлдөхүйц “Транскаспи” гэх маршрут Орос-Туркийн зөрчил дунд харин ч эрчээ авлаа. Явж явж “Торгоны зам”-д Кавказ татагдан орлоо. Оросын нутаг дэвсгэрийг тойруулан Хятадаас ачаа барааг Европ руу тээвэрлэх консорциум

байгуулах тухай баримт бичигт Стамбулд Хятад, Казахстан, Гүрж, Азербайжан, Туркийн ложистикийн томхон компаниуд Оросын онгоцыг Турк сөнөөгөөд бөөн хэрүүл дэгдэж байх энэ мөчид гарын үсэг зурлаа. Орост элдвээр хавчигдан гадуурхагдсан Гүрж энэ далимаар “Торгоны зам” гэх нүсэр том худалдааны замтай холбогдлоо.

Оросын холбоотон Хятад (ШХАБ, БРИКС дэх), Казахстан (ШХАБ, ОДКБ) нь Орос-Туркийн зөрчил дээр төвийг сахих бус, улс төрийн агуулгаар авч үзвэл Оросынхоо эсрэг энд ажилласан гэж үзэхэд буруу гэхгүй байх.

Найрсаг харилцаат өөр хоёр улсын хоорондын маргааны бас нэг жишээ. БНХАУ-ын дарга өнгөрөгч намар Вьетнамд айлчлахад айлчлалыг эсэргүүцэж, Ханойд БНХАУ-ын ЭСЯ болон Хошимин дахь БНХАУ-ын Ерөнхий консулын газрын өмнө жагсаал болж, жагсаалд оролцогчид “Хятадын айлчлалыг эсэргүүцэж байна”, “Парасел, Спратли арлууд-Вьетнамынх” гэх мэт лоозон барьж жагссаныг цагдаагийнхан хүч хэрэглэн тараасан. Өмнөд Хятадын тэнгис дэх маргаантай асуудлаар маргаантай талууд (Тайваниас бусад нь Монголтой найрсаг харилцаатай) харилцан буулт хийж, эв зүйгээр асуудлаа шийдвэрлэх нь тодорхойгүй байна. Ийм нөхцөлд Монгол Улс Хятад, Вьетнам хоёрын аль талд нь зогсох вэ? Тэд хоёулаа манай байр суурийг сонирхох нь лав.

Энэ мэт авч үзвэл Монгол Улс хуулиа батлаж төвийг сахисан байдлаа яаравчлан дэлхийд зарлахгүй бол Орос-Туркийн харилцааны хурцдал шиг өөр олон хямрал биднээс байр суурь шаардаж, “чи хэний талд вэ” гэдгээр шалгуур болгож манай улсыг эвгүй байдалд оруулж мэдэх юм.

Аль алинтай нь найрсаг харилцаатай, манай улсад алин нь ч хор хохирол учруулаагүй байгаа тохиолдолд тийм улсууд өвөр хоорондоо муудалцах, бүр дайтах хэмжээнд очихыг хувьсан өөрчлөгдөн буй дэлхий дахины үйл явц тулгаад гаргаад ирэхийг бид бодолцох учиртай болов уу. Харин тиймүүдийн хооронд зуучлах, эвээр зохицуулах, огтын харилцаагүй болбол аль нэгийг нь нөгөөд нь төлөөлөх зуучлалын дипломат бодлого Монголд хожоо авчрахаас хохирол болохгүй билээ.

## **Арванхоёр. Дүгнэе**

“Төвийг сахих Швейцарь загвар” гэж яг хуулбарлачихаар зүйл байхгүй байгаа нь Монгол энэ чиглэлд өөрийн бодлого, үйл ажиллагаагаа төлөвлөж, томъёолж, хэрэгжүүлэх өргөн бололцоогоор хангагдлаа гэдгийг шүүмжлэгч, болгоомжлогч нөхдөд хандан хэлэх байна.

Улс болгоны хувьд төвийг сахих статусаа баталгаажуулах болсон шалтгаан, нөхцөл нь өөр өөр байж ирсэн ба харин Швейцарь улсын хувьд

олон үндэстнүүд, олон шашинтнууд дотоодын эв нэгдлээ хангах, хямрал мөргөлдөөн, хагаралаас урьдчилан сэргийлэх зэрэг нөхцлөөр төвийг сахих статусаа баталгаажуулсан түүхтэй юм байна. Энэхүү бодлого нь цаашаа тус улсын гадаад бодлогын үндсийг тодорхойлох болжээ. Тус улсын төвийг сахих бодлого нь дээр хэлсэнчлэн олон үндэстнүүдийн дунд дотоодын эв нэгдлийг хангах анхны бөгөөд цорын ганц арга зам байсан, аажимдаа төвийг сахихын бусад давуу талуудыг илрүүлснээр Швейцарь нь өөрийн эрх ашигт энэ байр суурийг хэрхэн ашиглах аргад суралцсан хэмээн тэд өөрсдөө тайлбарлаж байна.

Швейцарийн төвийг сахих бодлого нь тус улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, мөн аюулгүй байдал, халдашгүй дархан байдлыг хангах болон улсын хөгжил дэвшилд таатай гадаад орчныг бүрдүүлэх улс төрийн арга хэрэгсэл мөн гэж ойлгогдлоо. Тэр утгаар төвийг сахих тухай бодлого сонгон авч буй Монголын хувьд бидний сонгосон зам, бодлого зөв зүйтэй юм байна гэдгийг Швейцарь улсаас чухам мэдэрлээ. Харин ч манай гадаад бодлого олон талтай, олон өнгөтэй, улам уян хатан, прагматик, нэмж зуучлах үүрэг бүхий болох болов уу гэж үзэж байна. Манай гадаад бодлого дахь олон талт дипломат бодлогын үлэмж хэсгийг зуучлах дипломат бодлого руу чиглүүлж таарах байх. Тэр утгаар гадаад харилцааны төрийн төв байгууллагыг бэхжүүлэхдээ “зуучлал” гэдэг утгаар хандаж, шинэ газар нэгж нэмж байгуулан дипломат ажилтнуудаа энэ чиглэлд давхар бэлтгэх шаардлагатай.

\* Профессор Д.Баярхүүгийн өгүүлэл дэх дүгнэлт санаанууд нь түүний ГХЯ-нд одоо эрхэлж буй албан тушаалтных нь байр суурийг тэр бүр тусгах албагүйг анхаарна уу. Тэрээр Улс Төрийн Боловсролын Академийн зочин-багшийн хувьд уг өгүүллийг туурвисан болно.

2015.12.05 Улаанбаатар хот





## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ШИНЭТГЭЛ, АСУУДАЛ ШИЙДЭЛ

*Ц.Бүжидмаа, доктор (Ph.D)*

Эхлэлийн оронд: Хүн төрөлхтөн хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал, ардчиллын нийтлэг үнэт зүйлүүдийг дээдэлсэн, нэн хурдацтай даяаршиж буй мэдээллийн эрин зуунд амьдарч байгаа өнөө үед улс орны хөгжлийг залуурдах, ардчиллыг бэхжүүлэх, эдийн засгийг хөгжүүлэх гол хөтөч нь төрийн захиргааны шинэтгэл болж байна. 1980-аад онд эхэлсэн Захиргааны шинэтгэлийн давалгаа Монгол, Энэтхэгээс Швед, Шинэ Зеланд, АНУ хүртэлх олон улс орнуудыг хамарсан өргөн далайц бүхий өөрчлөлтийн эрин үе байлаа. Эдгээр шинэтгэл, өөрчлөлтүүд нь амар хялбар зүйл биш бөгөөд маш их зөрчил, тэмцэл, эрсдэл дунд ихээхэн зориг, тэвчээрийг шалгасан хөтөлбөрүүд байсан юм. Зарим улс орнууд шинэтгэлийг зөв хэрэгжүүлж нийгэм эдийн засгаа хөгжүүлж, санхүүгийн амжилтанд хүрсэн сайн жишээ байхаас гадна бүтэлгүйтэж, хямралд хүргэсэн явдал ч цөөнгүй байна. Иймээс бидэнд улс орнуудад хийгдэж буй захиргааны шинэтгэлийн зорилго, агуулга, бодлого стратегийг сайтар ажиглан судалж, өөрийн оронд зөв гольдрилоор нь хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Өнөө үед Захиргааны шинэтгэлийн асуудлуудыг төрийн үйлчилгээний шинэтгэл, төрийн албаны шинэтгэл гэсэн 2 хүрээнд түлхүү ярих боллоо. Иймд энэхүү илтгэлдээ төрийн үйлчилгээ болон төрийн албаны хүрээнд 4 үндсэн тулгамдсан асуудлыг онцлов.

### **Асуудал 1. Төрийн үйлчилгээ иргэдийн хэрэгцээг хангахгүй байна.**

Монгол улсын хэмжээнд төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгох эхлэл тавигдаж, нилээдгүй арга хэмжээг авч хэрэгжүүлээд байгаа нь сайшаалтай. Тухайлбал Шинэчлэлийн Засгийн Газар барилга барих зөвшөөрөл авахад шаардагдаж байсан 140 гарын үсгийг 70 болгож, зарцуулах хоногийн тоог 90 байсныг 70 болгох зорилттой ажиллаж байна. Үйлчилгээг иргэнд ойртуулах, шат дамжлагыг багасгах, шуурхай болгох үүднээс “Нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлж, “ТҮЦ машин”-аас иргэд үйлчилгээг түргэн шуурхай авах, төрийн байгууллагуудад санал хүсэлт, өргөдөл гомдлоо илгээх боломж бүрдэв. Цахим үйлчилгээний хэлбэрүүдийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, иргэдэд

үйлчилгээний цагийн хуваарь, үйлчилгээний хэлбэр, нөхцөл, төлбөр, байгууллагын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтын талаар мэдээлэл өгөх, үйлчилгээний захиалга авах, бүртгэл хийх зэрэг ажлууд хийгдэж байна. Гэвч төрийн үйлчилгээг сайжруулах бодлого төлөвлөлтөд иргэд, анхан шатны ажилтны саналыг тусгах, эргэн тайлагнах, иргэдийн сэтгэл ханамжид тулгуурлан ажиллах тогтвортой механизм дутагдаж байна. Төрийн үйлчилгээ, бүтээгдэхүүний хүртээмж, чанарыг хянадаг, чанаргүй үйлчилгээний улмаас иргэнд учирсан хохирлыг барагдуулдаг үйлчлүүлэгчийг хамгаалах тогтолцоо бүрдээгүй байна. Үйлчилгээнд стандарт тогтоогоогүйгээс иргэнд үйлчилгээ урсгалаараа очиж байна. Үйлчилгээ иргэдийн хэрэгцээг хангасан эсэхийг үнэлэх боломжгүй байна.

**Асуудал 2. Иргэд төрийн үйлчилгээг үнэлэх, хариуцлага тооцох боломжгүй, төрийн хариуцлагын тогтолцоо иргэнд тодорхойгүй байна.**

Үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, үйлчлүүлэгчийн үнэлгээг төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд харгалзах тогтолцоо бий болж чадаагүй байна. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд олон нийтийн үнэлгээг харгалзах тухай журамтай ч хэрэгжилт хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл, хувь хүний болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд үйлчлүүлэгч, хэрэглэгчийн үнэлгээг харгалзах тогтолцоо /хууль эрх зүйн орчин, арга зүй, түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн болон бусад чадавхи/ бүрдээгүй байна. Иргэн эмчид үзүүлж, эмчилгээ, үйлчилгээ авлаа гэхэд тэр үйлчилгээ иргэний хэрэгцээг хангаж чадсан эсэхийг тухайн үйлчилгээг авсан хүн биш огт өөр хөндлөнгийн хүн үнэлж байгаа нь бодит байдал дээр ч туйлын “хошин шог” үзэгдэл юм. Иргэд Засгийн газар, төрийн байгууллагууд, төрийн албан тушаалтны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх боломжгүй төдийгүй, үнэлгээний шалгуур үзүүлэлт ч байхгүй байна. Энэ нь төрийн албан хаагчтай, Засгийн газартай, УИХ-ийн гишүүдтэй иргэд хариуцлага тооцох, амлалт нэхэх хариуцлагын тогтолцоо тодорхойгүй байгааг илэрхийлж байна.

**Асуудал 3. Мэргэшсэн тогтвортой төрийн албыг төлөвшүүлэх, мерит зарчмыг хамгаалан хөгжүүлэх тогтолцоо суларч, гажуудал үүслээ.**

Засгийн газар солигдох бүрд, бүр байгууллагын дарга нар солигдох бүрд төрийн албан хаагчдыг хомроглон халж байгаанульстөрөөс хараат бус мэргэшсэн тогтвортой төрийн албыг төлөвшүүлэхэд маш том сөрөг нөлөө үзүүлж байна. Өнөөдөр манай төрийн албанд Төрийн мэргэшсэн албан хаагчийн шалгалт өгөөгүй, аль нэг албан тушаалд түр томилогдсон, эсвэл үүрэг гүйцэтгэгчийн статустай байгаа албан тушаалтны тоог гаргавал бас сонирхолтой тоо гарах нь дамжиггүй.

Хууль зөрчиж хамаатан саднаа, танил талаа төрийн албанд томилдог, тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг чадвар хангалтгүй хичнээн хүнийг төрийн албаны ширээнд нааж, иргэдийг хохироож, төрийн үйлчилгээг цалгардуулж байгааг иргэдээс ирж буй өргөдөл гомдолд шинжилгээ хийсэн дүнгээс харж болно.

#### **Асуудал 4. Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлагын тогтолцоо бодит байдал дээр хэрэгжихгүй байна.**

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, бусад 70 орчим хуульд төрийн албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх, огцруулах үндэслэлийг заасан байдаг. Гэсэн ч хуульд заасан хариуцлагын тогтолцоо төрийн албаны бүх хүрээнд үйлчилдэггүй, албан тушаалтныг огцруулах, чөлөөлөх зохицуулалт нь бодит байдал дээр хэрэгждэггүй явдал байсаар байна. Төрийн улс төрийн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх үндэслэл тодорхойгүй байна. Тухайлбал огцруулах, эгүүлэн татах, тодорхой хугацаанд дахин нэр дэвших эрхийг хязгаарлах тухай заалт байхгүй байна. Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл огцруулах, эгүүлэн татах асуудлыг Үндсэн хуулийн цэц хуралдаанаараа шийдвэрлэж, дүгнэлт гаргахаар ерөнхий байдлаар зохицуулсан байгаа нь хариуцлагын асуудлыг туйлын бүрхэг болгож байна. Түүнчлэн төрийн албаны тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэлийг зааж өгсөн боловч зарим нийтлэг үндэслэл тусгагдаагүй байна. Энэхүү илтгэлээр толилуулан буй эдгээр асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж болох талаар дараах саналуудыг дэвшүүлж байна.

#### **Шийдэл 1. Иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээний стандартыг хөгжүүлж, “Үйлчлүүлэгчийг хамгаалах тогтолцоо”-г бүрдүүлбэ.**

Төрийн үйлчилгээг иргэнд ойртуулж, үйлчлүүлэгчийнхээ хэрэгцээнд суурилсан чанартай үйлчилгээг өртөг багатай, хүнд сурталгүй, олон шат дамжлагагүй, түргэн шуурхай хүргэх үүднээс юуны өмнө “үйлчлүүлэгчийг хамгаалах тогтолцоо”-г бүрдүүлэх нь төрийн үйлчилгээний шинэтгэлийг хэрэгжүүлэх суурь асуудал юм. Дэлхий нийтэд төрийн зүгээс иргэдийн эрхийг хөндсөн, тэдний эрхэнд халдсан үйлдлийн үр дагаврыг хэрхэн арилгах тухай онол, үзэл баримтлалыг төрийн хариуцлагын эрх зүйн судлагдахууны хүрээнд авч үздэг болсон бөгөөд нийтийн эрх зүйн салбар дахь хохирлыг нөхөн төлүүлэх, нөхөн олговор олгох явдал энд голлох байр суурийг эзэлдэг болжээ. Өөрөөр хэлбэл стандартад нийцээгүй, чанаргүй ажил үйлчилгээний төлбөрийг

иргэнд буцаан олгох, учирсан хохирлыг барагдуулах нөхөн төлбөр олгох, дараалал харгалзахгүй үйлчлэх, үйлчилгээг гэрт нь хүргэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх замаар үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалдаг тийм тогтолцооны тухай энд яригдаж байна. Үүний зэрэгцээ Нийтийн эрх ашгийг хохироосон асуудлаар санал гомдлыг хүлээн авч, иргэдийн өмнөөс нэхэмжлэх эрхийг иргэний нийгмийн байгууллагуудад олгож, хэрэгжүүлдэг сайн туршлагууд байна. Төрийн үйлчилгээний шинэтгэлийн хүрээнд бид төрийн үйлчилгээний стандарттай болох нь тулгамдсан асуудал болоод байна. Үйлчилгээнд стандарт тогтоож хэрэгжүүлснээр төрийн үйлчилгээний албан хаагчийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чадвар, соёлтой үйлчилгээ, шударга байдал нэмэгдэж, иргэд үйлчилгээний чанарыг үнэлэх, хариуцлага тооцох боломжтой болно. Үйлчилгээнд стандарт тогтоосноор тухайн үйлчилгээний үрдүнг хэмжих хэмжүүр, тоо, чанар, хугацаатай холбоотой заалтууд, үйлчлүүлэгч гомдол санал гаргах, түүнийг шийдвэрлэх механизм болон бусад мэдээлэл иргэнд тодорхой болох юм. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжаар үйлчилгээний чанарыг үнэлдэг тогтолцоог бий болгож, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, хүлээлтийг тогтмол хянан үзэж, тэдний үнэлгээг харгалзах, зөвлөлдөх, санал солилцох замаар стандартын түвшинг ахиулж, илүү сайн үйлчилгээ үзүүлэх тийм шинэ менежментийг хөгжүүлэх шаардлагатай байна.

**Шийдэл 2. Үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлаар үндэсний болон орон нутгийн хэмжээнд иргэдээр хэлэлцүүлэх, иргэдийн саналыг тусгаж үйлчилгээг төлөвлөх, иргэдийн сэтгэл ханамжаар үнэлэх, үр дүнг эргэн тайлагнах арга хэмжээг хэрэгжүүлэх цаг нь болжээ.**

Үүний тулд гүйцэтгэлийн үнэлгээтэй холбож, үр дүнг тооцох шаардлагатай. Түүнчлэн үйлчилгээний стандартын хэрэгжилт, чанаргүй үйлчилгээний талаар иргэд гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх, эргэж тайлагнах механизм бүрдүүлж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Иргэдийн санал, өргөдөл, гомдолд шинжилгээ хийж, тэдгээрт дурьдсан асуудлын учир шалтгааныг тогтоож, нийгмийн бүлгүүд, ялангуяа эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээг тодорхойлон, бодлого, шийдвэрт тусгаж, үйлчилгээ, төлөвлөлт, зохион байгуулалтаа сайжруулдаг олон улсын туршлагуудыг судлах шаардлагатай байна.

**Шийдэл 3. Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг нэмэгдүүлж, мерит зарчмыг жинхэнэ утгаар нь хамгаалан хөгжүүлбэ.**

Монгол улс төрийн албаны шинэчлэлийн хүрээнд төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангах мерит зарчмыг нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж ирсэн боловч нь энэ нь төдийлөн хангалтгүй байгааг олон тооны судалгааны үр дүн гэрчилдэг.

Аль ч орны Засгийн газрын үнэт капитал нь мэдлэг чадвартай, шударга төрийн албан хаагчид байдаг. Энэ утгаараа Монгол төрийн тогтвортой байдлыг хадгалах нэг нөхцөл нь Төрийн албыг улс төрөөс хараат бус мэргэшсэн тогтвортой байлгах, зөвхөн мэдлэг чадвараар нь сонгон шалгаруулдаг, албан тушаал ахиулдаг, шагнал урамшуулал олгодог мерит тогтолцоог жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх явдал байна. Иймээс бид Монгол улсын Төрийн захиргааны шинэтгэлийг үр дүнтэй үргэлжлүүлж, түүний бодлогыг тодорхойлсон баримт бичгийг яаралтай баталж, /Монгол улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны хөтөлбөр хэрэгжиж дуусаад одоо төрийн захиргааны шинэтгэлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр төлөвлөгөө гэх зүйл байхгүй урсгалаараа явж байна/ энэ хүрээнд төрийн албаны хүний нөөцийн хөгжлийн бодлогыг чиглүүлэх, мэргэшсэн чадварлаг төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулдаг, бэлтгэдэг, сургаж хөгжүүлдэг, тэдний гүйцэтгэлийг шударгаар үнэлдэг тогтолцоог бий болгох нь чухал байна.

#### **Шийдэл 4. “Төрийн хариуцлагын эрх зүй”-г хөгжүүлье.**

Өнөөгийн байдлаар манай улсад төрийн хариуцлагын асуудал хараахан нэгэн цогц эрх зүйн салбар болж хөгжөөгүй байгаа бөгөөд эрх зүйн энэ салбарыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгарч байгааг судлаачид тэмдэглэсээр байна. Монгол улсад Төрийн хариуцлагын тухай асуудал өөр хоорондоо ихээхэн ялгаа бүхий хууль тогтоомжид тусгалаа олсон байдаг бөгөөд эдгээр нь харилцан зөрчилтэй, уялдаагүй байгааг Б.Чимид багш судалгаандаа тусгаж байжээ. Тэрээр төрийн хариуцлагын асуудал Үндсэн хуулийн эрх зүйн асуудал болохыг дурдаад улс төрийн хариуцлагад ихээхэн анхаарал хандуулсан байдаг. Харин төрийн хариуцлагын эрх зүй хэмээх салбарыг хөгжүүлэх нь манай Үндсэн Хуулийн тулгуур үзэл баримтлалтай нягт холбоотой болохыг судлаач Б.Буянхишиг тодруулан судалсан байдаг. Мөн төрийн хариуцлагын асуудлыг шийдвэрлэх бие даасан салбар эрх зүй хөгжиж, нийтийн эрх зүйн тусгайлсан хууль тогтоомжийн кодификац бий болох хүртэл Иргэний Хуулийн суурь үзэл баримтлал, зохицуулалтыг энэ салбарт төсөөтэй хэрэглэж болох тухай өөрийн судалгааны үр дүнг тэрээр илтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэлдээ тусгасан байна.

Эндээс үзэхэд бидний эн тэргүүний зорилт бол “Төрийн хариуцлагын эрх зүй”-г хөгжүүлэх явдал байна. Эцэст нь төрийн хариуцлагын тогтолцоог төрийн албаны хүний нөөцийн бүхий л түвшинд авч үзэх цогц бодлого байх ёстой. Өөрөөр хэлбэл Төрийн албанд сонгон шалгаруулжавах, ажлын байрны шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийн үнэлгээ, сургалт хөгжлийн бодлого гээд өргөн цар хүрээнд авч үзэх ёстой асуудал болжээ. Олон улс оронд Төрийн албан хаагчид ялангуяа төрийн өндөр албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтоос гадна, албан тушаалтанд

тавигдах мэргэжлийн шаардлага, эзэмших ёстой ур чадварууд, хүлээх хариуцлагыг нэгд нэгэнгүй тодорхойлж, албан тушаал бүр дээр цогц баримт бичиг болгож баталсан байдаг нь санамсаргүй хэрэг биш ажээ. Ийнхүү төрийн үйлчилгээнд стандарт тогтоож, хэрэгжүүлэх, үйлчүүлэгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх замаар иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний шинэчлэлийг нэвтрүүлж, үйлчилгээг хүргэх төрийн албаны хүний нөөцийн оновчтой бодлоготой хослуулах замаар Төрийн захиргааны шинэтгэлийг бодит үр дүнд хүргэх боломж байна.

Ц.Бүжидмаа, доктор (Ph.D)

ШУТИС-ийн БуХС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга  
ОХУ-ын А.М.Горькийн нэрэмжит Уралын Улсын  
их сургууль, Төрийн удирдлагын Академи төгссөн  
Философич, Улс төр судлаач мэргэжилтэй, Боловсрол  
соел шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын  
хүрээлэнд ЭША, Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг  
даргын Тамгын газарт хэлтсийн дарга, Улс төрийн  
боловсролын академи, Либерти дээд сургуулийн багш,  
сургалтын албаны дарга, Их Засаг Их сургуулийн  
Эрдэм шинэжтлгээ эрхэлсэн Захирал, Эрдмийн  
сургуулийн захиралаар ажиллаж байсан.



## **ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, СУРГАМЖ**

*А.Болормаа*

*Ахлах багш, Нийгмийн ухааны салбар, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, ШУТИС, Монгол улс.  
E-майл хаяг: agvaan\_b@yahoo.com*

### Хураангуй:

Төрийн алба нь төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа бөгөөд энэхүү чиг үүргийг төрийн албан хаагчид хэрэгжүүлнэ. Төрийн албыг чадварлаг, мэдлэг боловсрол өндөр хүний нөөцөөр бүрдүүлэх талаар улс орон бүр өөр өөрийн туршлагатай. Хүний нөөцийн бүрдүүлэлтийн туршлага, сургамжийн талаар төрийн албаны нээлттэй загвартай улс орноос АНУ, Их Британи, Ази тивийн төлөөлөл болгож Япон, хаалттай загвартай улс орноос Герман, Франц улсыг сонгон судаллаа.

**Түлхүүр үг: төрийн алба, бүрдүүлэлт, шалгаруулалт, мэдлэг, тогтолцоо**

### Зорилго:

Хүний нөөцийг бүрдүүлэх гэдэг нь ажлын сул орон тоон дээр шаардлагад нийцсэн сонгож болохоор хүмүүсийг байгууллагад татах, нөгөө талаас хүмүүсийг тухайн байгууллагад ажиллах тэмүүллийг бий болгох үйл ажиллагаа юм. [1] Аливаа байгууллага чадварлаг хүний нөөцтэй байж өмнөө тавьсан зорилгоо амжилттай хэрэгжүүлнэ. Мэргэшсэн, туршлагатай, ажилдаа үнэнч, зүтгэлтэй хүний нөөцийг бодитой, ил тод, тэгш эрхийн үндсэн дээр сонгох, шилэх үйл явц нь төрийн албаны дотоод үр ашиг дээшлэх, нийгмийн зүгээс төрийн албанд итгэх итгэлийг бэхжүүлэх чухал суурь болж өгнө. Иймээс бусад орны төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх үйл явцыг судалж, өөрийн оронд хэрэгжүүлж болох сургамж, шинэ санаа авах зорилгоор судалсан болно.

### **I. Төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлтийн онолын үндэслэл:**

Төрийн албан хаагчдыг улс төрөөс ангид байлгах зорилгоор 1883 онд АНУ-д Пендлтоны хууль батлагдан гарсан. 1887 онд АНУ-ын ирээдүйн ерөнхийлөгч, Принстоны их сургуулийн захирал, доктор,

профессор Вудро Вильсон (Woodrow Wilson, 1887) “Захиргаа судлал” (The Study of Administration) бүтээлдээ төрийн захиргааны ухааныг онолын хувьд үндэслэх оролдлого хийжээ. Тэрээр төрийн захиргаа улс төрийн хүрээнээс ангид оршино. Өөрөөр хэлбэл төрийн захиргааны асуудал бол улс төрийн асуудал биш юм. Хэдийгээр улс төрийн бодлого нь захиргааны байгууллагуудын зорилтыг тодорхойлж байдаг боловч энэ нь захиргааны үйл явцад хутгалдана гэсэн үг хараахан биш хэмээн тодорхойлж байсан. Төрийн захиргааны байгууллагад дээд зэргийн мэргэшсэн байдлыг бий болгох нь туйлын чухал гэж үзэж байсан. Вильсоны дэвшүүлсэн үзэл санааг Америкийн улс төр судлаач Франк Ж. Гуднау (Goodnow, F., 1900) цаашид хөгжүүлсэн. Германы социологич М.Вебер (Weber, M., 1920) төрийн жинхэнэ мэргэшсэн албан хаагч хүн улс төрч байх ёсгүй, улс төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй гэж үзсэн.

1880-1970 он хүртэл уламжлалт бюрократ хэв загварын онолын урсгал давамгайлж байсан бол 1980-аад оноос Их Британи, АНУ, Австрали, Шинэ Зеланд зэрэг орнуудад улсын салбарт хувийн хэвшлийн менежментийн зарчмуудыг нэвтрүүлэхэд чиглэгдсэн шинэтгэл хийж, Төрийн шинэ менежмент (New Public management)-ийн онолын хандлага үүсчээ. Энэ хүрээнд төрийн албыг илүү уян хатан, үр ашигтай болгох, төрийн албанд өрсөлдөөний зарчим, гүйцэтгэлийн менежментийг нэвтрүүлэх, төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж, түүнд нь тохирсон цалин, урамшуулал олгох гэх мэт шинэтгэлийн хэлбэрүүдийг санал болгосон.

## **II. Зарим улс орны төрийн албан тушаалын ангилал:**

Улс орон бүрийн төрийн алба, түүний ангилал, төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын тогтолцоо зэрэг нь төрийн байгууламж, төрийн албаны тогтолцооноос хамаарна. Ихэнх нь улсуудад төрийн албан хаагчийн эрх байдлыг зохицуулсан хууль тогтоомж үйлчилдэг. Тухайлбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн болон Европын холбооны 34 орноос 31 нь төрийн албаны тусгай хуультай байна. Үүнээс 25 тохиолдолд төрийн албан хаагчийн эрх үүрэг, хариуцлагыг, 29 тохиолдолд төрийн албан тушаал эрхлэх болзол, хугацаа, баталгааг, 25 тохиолдолд зарчим, 28 тохиолдолд урамшуулал, цалин хөлсний талаар зохицуулжээ. Харин төрийн албан хаагчийн ангилалд ямар албан тушаал хашиж буй албан хаагчдыг хамруулсныг харуулбал:

- 14 улсад - эрүүл мэндийн салбар албан хаагчид;
- 16 улсад - боловсролын салбарын албан хаагчид /багш/;
- 22 улсад - цагдаагийн албан хаагч нар үндэсний хэмжээний төрийн албан хаагчийн ангилалд хамаардаг;
- 18 улсад - орон нутгийн төвшний төрийн /боловсрол, эрүүл мэнд, цагдаагийн албан хаагчид орохгүй/ албан хаагчид үндэсний хэмжээний төрийн албан хаагчидтай адилтгаж үздэг.
- Шүүгч нарын хөдөлмөрийн харилцааг ихэвчлэн тусгай хуулиар зохицуулдаг байна. [2]

Төрийн албан тушаалыг албанд тавигдах хугацаагаар нь хугацаатай /улс төрийн албан тушаал, өндөр албан тушаал/, хугацаагүй гэж ангилдаг. Эдгээрээс хамаараад төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх өөр өөр тогтолцоотой. Үүнийг хэд хэдэн улсын жишээн дээр авч үзье.

АНУ-ын төрийн албаны орчин үеийн эхлэл 1883 оны Пендлтоны хуулиар тавигдсан. Төрийн албыг өрсөлдүүлэн шалгаруулах алба, тусгай алба гэж ангилдаг. Төрийн албан тушаалыг 1-18 зэрэглэлд ангилж, эдгээр зэрэглэлийн албан тушаалд ажилд авахад уралдаант шалгаруулалт явуулж, мэргэжлийн ур чадвар, мэргэшсэн байдлыг үнэлэх мерит тогтолцоо үйлчилнэ. Мөн албан тушаал ахихад ч энэ зарчим үйлчилнэ.

**Хүснэгт 1.АНУ-ын төрийн албан тушаалын зэрэглэл**

Зэрэглэл	Албан тушаал	Чиг үүрэг
1-4-р зэрэглэл	Бага албан тушаал	Ердийн хэвшмэл ажлуудыг гүйцэтгэх ба заримдаа захиргааны шууд хяналтан дор хүнд хүчир ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
5-8-р зэрэглэл	Гүйцэтгэх албан тушаал	Ганцаарчилсан ажлын чадвар, тусгай мэдлэг, бэлтгэл шаардсан мэргэжлийн ажил гүйцэтгэнэ.

9 - 1 4 - р зэрэглэл	Удирдах албан тушаалтнууд	Захиргааны удирдлага, хяналтын дор үйл ажиллагаагаа явуулна. 11-р зэрэглэлийн албан хаагчид шийдвэр гаргах чадвартай, 13-р зэрэглэлийн албан хаагчид жижиг салбар, нэгжийн даргын туслах байж чадах, 14-р зэрэглэлийн албан хаагчид салбар, нэгж, товчооны дарга байж чадах ёстой.
15-18-р зэрэглэл	Төрийн байгууллагын дээд албан тушаалтнууд	Удирдах, төлөвлөх чиг үүрэгтэй.

Их Британид Төрийн алба нь улс төрөөс удирдлагыг салган үзэх зарчимд үндэслэгдсэн. Энэ зарчмын үндсэн дээр улс төрөөс хамааралтай солигдож байдаг албан тушаалтан, солигддоггүй албан тушаалтан гэж хуваагддаг. Эхнийхд нь Ерөнхий сайд, сайд нар, төрийн нарийн бичгийн дарга нар болон Засгийн газар солигдоход хамт өөрчлөгдөх хэд хэдэн албан тушаалууд хамаардаг. Яам, тусгай газрын ажилтнууд төрийн албан хаагчид хамаарна. Нийт албан тушаалыг ангилал, бүлэглэлд хуваан, дотор нь зэрэг дэв, зэрэглэлээр нь ангилна.

- Улс төрийн болон захиргааны ахлах дарга нарын дээд бүлэг - байнгын нарийн бичгийн дарга нар, тэдгээрийн орлогчид, орлогчийн туслахууд гэсэн зэрэгтэй албан тушаалтнууд бүрдүүлнэ. Энэ ангиллынхан иргэний албаны дээд албан тушаалтнууд юм. Тэд сайдын өмнө эрхэлсэн ажлынхаа төлөө шууд биечлэн хариуцлага хүлээнэ.
- Захиргааны – ахлах гүйцэтгэгч, захиргааны хэрэг эрхлэгчийг дагалдагч, нарийн бичгийн дарга, клерк болон тэдний туслахууд, бусад албан тушаалууд
- Мэргэжлийн шинжээчид - Эдийн засагчид, статистикчид, мэдээллийн албаны ажилтнууд болон бусад
- Техникийн туслах ажилтнууд – бичээч, хувийн нарийн бичгийн дарга, бичиг хэргийн эрхлэгч, үйлчлэгч болон бусад.

Герман улсад төрийн алба (civil service, государственная служба, staatsdienst) гэсэн ойлголт байхгүй, харин дэлхийн II дайнаас хойш

нийтийн алба гэсэн (public service, публичная служба, offentliges) нэр томъёо хэрэглэх болсон. Энэхүү ойлголтод түшмэд (beamte, чиновник), албан хаагч (angestellte, служащие), ажилчид (arbeiter, рабочие) гэсэн 3 ангиллын албан тушаал хамаарна. Түшмэл нь албан хаагч, ажилчдаас ялгаатай. Түшмэдийг насан туршид нь төрийн албанд томилдог, нийгмийн баталгааг төрөөс хангадаг, тэтгэврийн тусгай тогтолцоотой зэрэг онцлогтой бол албан хаагч, ажилчдыг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулна, гэрээг хугацаа дуусахад цуцалж болно, тэтгэврийн нийтлэг тогтолцоо үйлчилнэ гэх мэт ялгаатай. Тус улсад түшмэдийг доод (энгийн алба) , дунд (дунд алба), ахисан (хариуцлагатай алба), дээд (дээд алба) төвшний гэж 4 ангилна. Албан тушаалын ангилал нь 16 ранг (зэрэглэл)-тай.

- A1-A5 – доод ранг –туслах, техникийн ажилтнууд
- A6-A9 – дунд ранг – засгийн газрын нарийн бичгийн дарга нар
- A10-A13 – нэгдүгээр шатны дээд ранг – засгийн газрын инспекторууд
- A14-A16 – хоёрдугаар шатны дээд ранг – засгийн газрын ахлах зөвлөхүүд [3,19]

Франц улсын төв засгийн газар болон орон нутгийн салбарт ажиллаж байгаа албан хаагчид төрийн албан хаагчид хамаарна. Тус улсад төрийн албан тушаалыг 4 ангилалд хуваана. [4,22]

**Хүснэгт 2 . Франц улсын төрийн албан тушаалын ангилал**

Ангилал	Чиг үүрэг
“А” ангилал (20%)	Удирдлагын шийдвэр, дүрэм журам боловсруулах чиг үүрэгтэй.
“В” ангилал (40%)	Удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлнэ.
“С” ангилал (32%)	Мэргэжлийн үүднээс гүйцэтгэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.
“D” ангилал (8%)	Туслах ажилтнууд бөгөөд техникийн ажил гүйцэтгэнэ.

Төрийн албаны тухай хууль нь шүүгч, үйлдвэр, худалдааны салбарын ажилтан, цагдаагийн алба хаагч нарт үйлчлэхгүй, эдгээрийг тусгай хуулиар зохицуулдаг.

Япон улсад төрийн алба хаших хугацаанаас нь хамаарч сонгуулиар

сонгогдож хаших алба, нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгогдож ажиллах алба гэж хуваана. Мөн энгийн болон тусгай алба гэж ангилна. Тусгай албанд шүүгчид, батлан хамгаалах салбарын албан хаагчид, шинжлэх ухааны академийн гишүүн, Ерөнхий сайд, Ерөнхий нарийн бичгийн дарга болон тэдний мэргэжлийн албан хаагчид, бусад нь энгийн албан хаагчид хамаарна.

### **III. Төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлтийн үйл явц**

Улс орон бүрт төрийн албаны тогтолцооны онцлогоос хамааран төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх тогтолцоо үйлчилж байна. Зарим улсад (Англи, АНУ, Швед, Канад, Япон гэх мэт) төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт хариуцсан тусгай байгууллага байдаг бол зарим улсад тусгай бие даасан байгууллага байхгүй, тухайн байгууллага, эсвэл өөр субъект (Франц, Герман гэх мэт) хариуцдаг.

АНУ: Тус улсад уралдаант сонгон шалгаруулалтын үндсэн дээр тухайн албан тушаалын шаардлага хангасан иргэнийг төрийн албан тушаалд шалгаруулан авна. Төрийн албанд шинээр сонгон шалгаруулалтад орж байгаа хэн ч болов сонгон шалгаруулалтад шат дараалан тэнцэх ёстой бөгөөд шалгаруулалтад тэнцсэн хэн ч болов албан тушаалын шат дарааллыг үл харгалзан удирдах албанд очих боломжтой нь мерит тогтолцооны онцлог гэж үздэг. Төрийн албан хаагчдын 90 орчим хувь нь уралдаант шалгаруулалтаар төрийн албан тушаалд томилогддог. Харин онцгой албанд төрийн албаны тухай хууль үйлчлэхгүй, тусгай зохицуулалт, зарчимтай. АНУ-д захиргааны өндөр албан тушаалуудад улс төрийн оролцоо, идэвх зүтгэлийг үнэлэн томилдог улс төрийн томилгооны буюу “спойл” тогтолцоо, мэргэшсэн, ур чадварыг үнэлэх мерит тогтолцоо аль аль нь үйлчилдэг. Төрийн департамент, агентлагийн удирдлага, элчин сайд, консул, Ерөнхийлөгчийн зөвлөх, туслах, нарийн бичиг зэрэг албан тушаалууд дээр “улс төрийн томилгоо” буюу улс төрийн үйл хэрэгт оруулсан хувь нэмэр болон Цагаан ордонд өөрийн талын намыг төлөөлж хэр удаан ажилласан зэргээс хамаарч томилгоо хийгддэг ба энэ нь нийт албан хаагчдын 5 орчим хувийг л эзэлдэг байна. [4,13]

Тус улсад төрийн албаны хүний нөөцийн асуудал эрхэлсэн, бие даасан, хараат бус тусгай байгууллага ажилладаг. Төрийн албанд авах үйл явц 2 үе шаттай явагддаг. [5,117] Эхлээд комисс 3 нэр дэвшигчийг сонгоно. Сонгохдоо төрийн албан тушаалын хувьд сорилын шалгалт, эсвэл төрийн өндөр албан тушаалд шалгаруулахад боловсрол, мэргэшлийн төвшинг илтгэх баримт бичгийг үндэслэнэ.

Дараагийн сонголтыг тухайн албан тушаалд томилох эрх бүхий албан тушаалтан хийнэ. Хүний нөөцийг бүрдүүлэхэд уралдаант сонгон шалгаруулалтаас гадна Боловсон хүчний албаны газраас гаргасан сургалтын хөтөлбөрийг амжилттай дүүргэсэн байх шаардлага тавьж болно.

Их Британид төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх өөрийн онцлог шинжтэй. Төрийн албан хаагчдыг шилж сонгох тогтолцоог хараат бус, бие даасан Төрийн албаны комисс хариуцдаг. Төрийн албанд орохыг горилогчид бичгэн шалгалт, сорилын шалгалт, ярилцлага өгнө. Төрийн бус салбарт ажиллагчдаас хүний нөөц бүрдүүлэх нээлттэй тогтолцоотой. Бизнесийн байгууллагын удирдах ажилтнууд төрийн албан хаагчдын сэтгэлгээнд өөрчлөлт авчирна гэж үздэг. Шалгалт, ярилцлага нь ихэвчлэн тэргүүлэх их сургуулиуд болох Оксфорд, Кембрижийн их сургуулиудын хөтөлбөрийн үндсэн дээр явагдана. Практикт ч эдгээр сургуулийг төгсөгчид удирдах албан тушаалд нэр дэвшигчдийн олонхийг бүрдүүлдэг байна. Энэ нь төрийн албаны хэтэрхий явцуу шинжийг бий болгосон гэж үздэг. Захиргааны ангиллын албанд орохыг горилогчид их сургууль төгссөн, 20-28 насны иргэд байх ёстой. Харин техникийн туслах ажилтнуудад боловсролын хувьд өндөр шалгуур тавихгүй, тодорхой сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн боловсролтой байхыг шаардана. Шалгалтыг амжилттай давж чадсан нэр дэвшигчид комиссоос холбогдох албан тушаалыг хаших эрх олгосон үнэмлэх гардан авна. Ийнхүү тэд насан туршдаа (тэтгэврийн нас хүртлээ) албан хаагчаар ажиллана. Тэдний ажлын байр баталгаатай бөгөөд хугацаанаас нь өмнө халах, чөлөөлөх тохиолдол маш ховор. Албан тушаал дэвшүүлэх тогтолцоо их хатуу бөгөөд яамнаас яаманд, нэг ангиллаас нөгөө рүү шилжих боломж их хязгаарлагдмал байдаг. Тус улсын төрийн албаны өөрчлөн байгуулалт нь нэг талаас төрийн албан хаагчдын тоог цомхотгох, хөнгөлөлт, давуу байдлын хэмжээг хорогдуулах, захиргааны ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд түлхэц өгсөн ч нөгөө талаас төрийн албаны нэгдмэл тогтолцоог алдагдуулан, төрийн албанд татагдах сонирхлыг бууруулахад нөлөөлсөн байна. [6.9]

Франц улсад төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулах нарийн тогтолцоотой. Албанд анх элсэн ороход бүгд эрх тэгш эрхтэй бөгөөд эрх тэгш байх гэдэгт юуны өмнө арьс өнгө, үндэс угсаа, итгэл үнэмшил, хүйс хамаарахгүйгээр эрх тэгш байхыг ойлгодог. Албанд анх элсэн ороход зарим албан тушаалууд дээр насны, иргэний харъяаллын, мэдлэг чадварын тусгай хязгаарлалтууд үйлчилдэг. Олонхи албан тушаалд насны дээд хязгаар 40-45 байдаг. Орон тооны албан тушаалд

заавал Францын иргэний харъяалалтай байх ёстой бол орон тооны бус албан тушаалд гадаадын иргэдээс авч ажиллуулж болно. Ёс зүйн зөрчил гаргасан, цэргийн алба хаагаагүй тохиолдолд төрийн албанд авч ажиллуулахыг хориглоно. Зарим албан тушаал хашихад мэргэжлийн зохих төвшнийг илтгэсэн дипломтой байхыг шаарддаг. Тус улсад төрийн албан тушаалд ажиллахыг гориллогчид тусгай сургалтад хамрагдсан байх шаардлага тавьдаг.

Төрийн албан тушаалд нэр дэвшигчид нь тухайн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, чадвартай байх ёстой. Төрийн албан хаагч мэргэшсэн байх хандлага баримталдаг АНУ, Германаас ялгагдах онцлог нь Франц (мөн Их Британи) улсад захиргааны болон техникийн чиг үүргийг гүйцэтгэх өргөн хүрээний бэлтгэлтэй байхыг шаарддаг. Төрийн албан тушаалд нэр дэвшигчдээс аман болон бичгэн шалгалт авна. Сонгон шалгаруулалтад хууль зүйн мэдлэгийг голчлон анхаардаг. Удирдах албан тушаалд ажиллаж байгаа төрийн бүх албан хаагчдын 60 хувь нь хууль зүйн, 14 хувь нь эдийн засгийн боловсролтой, үүний дотор төрийн нарийн бичгийн дарга нарын 31 хувь нь хууль зүйн боловсрол эзэмшсэн байдаг байна. [4] Харин улс төрийн албан тушаалтнууд Засгийн газрын болон сайдын шийдвэрээр томилогддог.

Герман улс холбооны хэмжээндээ төрийн албаны шалгаруулалт хариуцсан нэгж байдаггүй, шалгаруулалтыг тухайн субъект өөрөө хариуцна. Дотоод яам нь төрийн албаны хууль эрх зүй, нийтийн албаны үйлчилгээний асуудлыг ерөнхийд нь л хариуцдаг. Сонгон шалгаруулалтын улсын тусгай комисс авч тэнцсэн албан хаагчдад батламж олгоно. Төрийн албан хаагчаар томилогдсон л бол тэтгэвэрт гартлаа хууль зөрчиж, ёс зүйн алдаа гаргахгүй бол энэ статусаа хадгална. Төрийн албан тушаалд орохыг гориллогчид албан тушаалын зэрэглэлээс хамаарсан насны хязгаар, боловсрол мэргэжлийн шаардлагыг хангасан байх ёстой. Өөрөөр хэлбэл, тус улсад төрийн албаны сонгон шалгаруулалтыг хатуучанга шалгуураар явуулдаг бөгөөд төрийн албан хаагчдыг тасралтгүй сургах тогтолцоотой. Германд анх төрийн албанд ороход нээлттэй уралдаант шалгаруулалтын систем үйлчилдэг бол албан хаагчид албан тушаал ахихад ахих карьерын тогтолцоо үйлчилнэ. Албан тушаалын зэрэглэлээс хамааран тавигдах шаардлага, анх төрийн албанд авч ажиллуулах насны хязгаар зэрэг нь ялгаатай байна. [7.51]

**Хүснэгт 3. Герман улсын түшмэдийн албан тушаалын  
зэрэглэл, тавигдах шаардлага**

Зэрэглэл	Албан тушаал	Тавигдах шаардлага	Албан тушаалд авч ажиллуулах насны хязгаар
A1-A5	Туслах-техникийн ажилтнууд	Ерөнхий боловсролын сургуулиа амжилттай төгссөн, албаны бэлтгэлд хамрагдсан байх	16-30
A6-A9	Засгийн газрын нарийн бичгийн дарга, обер-нарийн бичгийн дарга, амтс-хянан байцаагч	Ерөнхий боловсролын сургуулиа амжилттай төгссөн, мэргэжлийн тусгай бэлтгэлд жилийн хугацаатай орсон бөгөөд дунд төвшний албан тушаал эрхлэх тусгай шалгалтыг өгч тэнцсэн байх	16-35
A10-A13	Засгийн газрын хянан байцаагч нар, обер-хянан байцаагч нар, амтманн, амстрат, обер-амстрат	Дунд сургуулиа амжилттай төгссөн, 3 жилийн хугацаатай тусгай бэлтгэл хийсэн бөгөөд энэхүү төвшний шаардлагын дагуу шалгалт өгч тэнцсэн байх	16-32
A14-A16	Сайд нар, Засгийн газрын төв аппаратын дарга нар	Дээд боловсролтой, албаны 1-р шатны шалгалт өгч тэнцсэн, 2 жилийн хугацаатай албаны бэлтгэл хийсэн, энэ төвшний шалгалт өгсөн байх	18-30

Япон улсын онцлог бол бүх насаар нь хөлслөх системтэй, албан тушаал ахих замаар урт удаан хугацаанд нэг байгууллагад ажилладаг. Тус улсад төрийн албанд өрсөлдүүлэн шалгаруулах тогтолцоо үйлчилдэг. Төрийн албаны шалгалтын зорилго нь тухайн иргэн төрийн албан тушаалын чиг үүргийг гүйцэтгэх чадварыг нь шалгахад оршдог. Энэхүү сонгон шалгаруулалтын тогтолцоо 19 дүгээр зууны сүүл үеэс ямар нэгэн онцын өөрчлөлтгүйгээр өнөөг хүртэл мөрдөгдөж иржээ. Төрийн албанд орох иргэдээс бичгэн болон аман шалгалт авна. Шалгалт улсын хэмжээний, орон нутгийн гэсэн хоёр төвшинд явагдана. Шалгалтын агуулга, төрөл ялгаатай байна. Уралдаант шалгаруулалтад тэнцсэн иргэд төрийн албанд орох эрх олж авч байгаа бөгөөд сул орон тоо гарахад томилогдох шаардлага хангаж байна гэсэн үг. Шалгалтын хугацаа тодорхой заасан байдаг. Нэг албан тушаал дээр 100 хүртэл хүн өрсөлддөг.

Бусад орнуудын хувьд: Итали улсад шалгалт, ярилцлагын дүнгээс гадна удирдл жагын шийдвэрээр томилох тохиолдол байдаг. Хятадад орон нутгийн болон дээд шатны төрийн байгууллагад ажилд ороход анхан шатны нэгжид 2-оос доошгүй жил ажилласан байх шаардлага тавьдаг. Удирдах албан тушаалд ороход уралдаант шалгаруулалтад орохгүй, бусад төрийн албан тушаалд уралдаант шалгаруулалт явуулна. Энэтхэгт уралдаант шалгаруулалтаас гадна тус улсын захиргааны албаны зөвлөмж, дүгнэлт гаргуулах систем үйлчилдэг. Турк улсад хоёр үе шаттай уралдаант шалгаруулалт /дотоод, гадаад/ явагдана. Нэг дэх үе шатанд улс орон даяар нэгдсэн стандартчлагдсан шалгалт авах бөгөөд зарим тохиолдолд гадаад хэлний шалгалт авна. Хоёр дахь шатны сонгон шалгаруулалт – дотоод: тодорхой төрлөөр аман болон бичгэн шалгалт, ярилцлага авна. [8] Шведэд захиргааны байгууллагын албан хаагчид болон өндөр албан тушаалтнуудыг Засгийн газар, бусад албан хаагчдыг тухайн төрийн байгууллагын удирдлага томилно. Швейцарь улсад төрийн албанд шалгаруулж авахдаа мэргэжлийн мэдлэг чадвар, албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх бэлтгэл зэргийг харгалзана. Улс төрийн соёл, ертөнцийг үзэх үзэл зэргийг тусгайлан үнэлнэ. Хэт улс төржих явдал нь олон нийтийн ашиг сонирхолд сөрөг нөлөөлнө гэж үздэг. [9,183] ОХУ-д уралдаант сонгон шалгаруулалтаар төрийн албанд элсэнэ. Уралдаант шалгалт нь нэр дэвшигчдийн мэргэжлийн болон мэргэшлийн төвшинг үнэлнэ. Казахстан улсад төрийн албаны шинэтгэлийн үр дүнд төрийн албанд анх орох иргэнийг сонгон шалгаруулж авдаг тогтолцоог бий болгосон байна. Энэ үүргийг тус улсын Ерөнхийлөгчид харьяалагддаг Төрийн албаны агентлаг хариуцдаг байна. Казахстаны Төрийн албаны тухай хуульд төрийн албан тушаалын 90–ээс дээш хувь нь сонгон

шалгаруулалтын зарчмаар бүрдүүлэхээр хуульчлан заасан юм.

Дүгнэлт:

1. Төрийн албаны хүний нөөц бүрдүүлэхэд өөр өөрийн гэсэн үндэсний онцлог байна. Төрийн албанд анх ороход уралдаант шалгаруулалт явуулах тогтолцоо нийтлэг байна. Улмаар төрийн албанд орсны дараа дотооддоо сонгон шалгаруулалт явуулж албан тушаал дэвшүүлэх тогтолцоо Герман, Франц зэрэг улсуудад үйлчилж байна. Харин АНУ, Их Британи улсууд нээлттэй сонгон шалгаруулалт зарладаг. Зарим өндөр албан тушаалтнуудыг тухайн улсын улс төрийн удирдлагын хяналт дор (Франц, Швед, Финлянд, Дани, Герман, Итали гэх мэт) томилох ажил хэрэгждэг байна.
2. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн албан хаагчдын тоог бууруулах, хөнгөлөлт давуу талыг хорогдуулах арга хэмжээ авсан нь захиргааны зардлыг бууруулах сайн талтай ч /Их Британи/ нөгөө талаас чадварлаг хүний нөөц төрийн албанд бүрдүүлэхэд сөрөг нөлөөлсөн.
3. Төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэхэд анх орох иргэнд албан тушаалын зэрэглэлээс хамаарч насны хязгаарлалтыг хэд хэдэн улсад /Герман, Их Британи/ нэмэлт шаардлага болгон тавьж байна.
4. Улс орнуудад улс төрийн албан тушаалтан цөөхөн хувийг спойл тогтолцоогоор, бусад албан хаагчдыг уралдаант шалгаруулалтаар мерит зарчимд үндэслэн бүрдүүлж байна.

*А.Болормаа /Улс төрийн Боловсролын Академийн багш/*

**Ашигласан материалын жагсаалт:**

[1] Lloyd L.Byars, Leslie W.Rue, Human Resource Management, 2004, p136

[2] Василенко И. Административно-государственное управление в странах Запада: США, Великобритания, Франция, Германия М., 2001, стр 605-625

[3] [www.worldbank.org/publicsector/civilservice/machinery.htm](http://www.worldbank.org/publicsector/civilservice/machinery.htm)

[4] Төрийн албаны эрх зүйн зарим асуудлаарх бусад орны туршлага. (Харьцуулсан судалгаа). УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс. УБ., 2014. Хуу 19-23

[5] Оболонский А.В. Кризис бюрократического государства. Реформы государственной службы: международный опыт и российские реалии. М., Фонд “Либеральная миссия”, 2011. Стр 117-118

[6] Төрийн албаны тогтолцоо, шинэтгэлийн талаарх бусад орнуудын туршлага ба монгол улсын нөхцөл байдал. (Харьцуулсан судалгаа). УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс. УБ., 2014. 9-10

[7] Сүхбаатар Ж., Өрнөдийн орнуудын захиргааны эрх зүйн ерөнхий тойм. УБ., 2001.

[8] Стародубцев И.И О подготовке кандидатов в государственные служащие в Турции <http://www.iimes.ru/rus/stat/2012/06-07-12a.htm>

[9] Лазукова Е. Наем и карьера государственных служащих. Журнал: Власть 2013/05. Стр 181-183



## **“ТӨР БОЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА” ХЭМЭЭХ ДОМГИЙН ТУХАЙ**

*Философийн ухааны доктор Б.БАТЧУЛУУН*

Мөрри Ротбардын (1926-1995 он. АНУ-ын таван том либертари сэтгэгчийн нэг) Төрийн анатоми хэмээх бэсрэг бүтээл удахгүй монгол хэл дээр хэвлэгдэн гарах нь ээ. Ингээд, ХХ зуун дахь либертари үзлийн томоохон төлөөлөгчдийн бүтээл ямар нэг хэмжээгээр бүгд орчуулагдлаа. Ротбардынх үлдчихээд байсан юм. Энэ ажил либертари үзэл санааг Монголд дэлгэрүүлэх үйлсэд ихээхэн хүчин зүтгэл гаргаж явдаг хүн болох Д.Амартүвшингийн ачаар гүйцэлдлээ, залуу анддаа баярлалаа. Дашрамд хэлэхэд, Амартүвшин маань өмнө нь Мөрри Ротбардын Чөлөөт зах зээл хэмээх жижиг өгүүллийг тун дажгүй монгол орчуулгатайгаар өөрийн блог дээр тавьсан нь одоо нэгэнт нийтийн хүртээл болжээ.

Төрийн анатоми эссэнд ордны сэхээтнүүдийн тухай, төр өөрийн байх ёстой хэмжээ хязгаарыг хэрхэн давдаг, Үндсэн хууль төр хоёрын харьцаа, төр юунаас айдаг болох тухай гээд олон асуудлыг хөндсөн байдгаас энэ удаад Монголд хамгийн их тархсан “төр бол үйлчилгээний байгууллага” гэсэн домгийг илчилсэн хэсгээс өгүүлье.

“Төр бол үйлчилгээний байгууллага” гэсэн ойлголт АНУ-д 1950-иад оноос их газар авчээ. Гэтэл, үнэндээ төр тийм байа гэсэн ч чаддаггүй аж. Энэ бол стэйтистүүдээс (төрийг дээдлэгчдээс) олон түмнийг хуурч, өөрсдийгөө сайн сайхан харагдуулахын тулд зохиосон үг. Хатуу стэйтистүүдээс ялгаатай хүмүүс болохын тулд гаргасан аядуу стэйтистүүдийн хэллэг. Хамгийн ардчилсан бус улсууд өөрсдийгөө ардчилсан гэж нэрлэх дуртай байдаг шиг “нийгэмд огт үйлчилдэггүй байгууллага, нөхдүүд өөрсдийгөө нийгэмд үйлчилдэг” хэмээн ойлгуулах гэж буй хэрэг. Хойд Солонгосын коммунист удирдагчид өөрсдийгөө БНАСАУ (Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс), 1990 оноос өмнө коммунист орон байсан Зүүн Германыхан БНАГУ (Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс) гэж нэрлэж байсантай адил. Гэтэл жинхэнэ ардчилсан улс болох Өмнөд Солонгосынхон болон Баруун Германыхан өөрийнхөө улсыг зүгээр л БНСУ, ХБНГУ хэмээн нэрлэж байв. Манай Монгол улс ч гэсэн хамгийн ардчилсан бус шинжтэй байсан 1921-40 онд “хувьсгалын ардчилсан” шатыг туулаад өнгөрчихсөн гэж туудаг байлаа. Тэгэхээр хамгийн харгис, тоталитари дэглэмүүд өөрсдийн нүүр царайг нуухын тулд өөрсдөдөө байхгүй нэр томъёоны доор нуугдах гэж оролддог шиг олон түмэнд огт үйлчилдэггүй байгууллага болох төрийн түшмэд төрийг олон түмэнд үйлчилдэг байгууллага хэмээн нэрлэх дуртай байдаг аж.

Мерри Ротбард “Төр нь юу биш вэ гэвэл үйлчилгээний байгууллага биш” хэмээн бүтээлээ эхэлсэн байдаг. Ардчилал хөгжих хэрээр төрийг нийгэмтэй адилтгах явдал улам эрчимжиж, эрүүл саруул оюун ухааны бүх урсгалд харшилсан “бид бол төр” гэсэн ойлголт давамгайлах болов.

Коллективизмд ашигтай “бид” хэмээх нэр томъёо, улс төрийн бодит байдлыг халхавчилсан үзэл суртлын зэвсэг болж хувирлаа. Хэрэв “бид төр” юм бол төрийн хийж буй аливаа үйлдэл дарангуйлсан шинжгүй, харин ч хүмүүсийн хүсэл эрмэлзлийг харгалзсан байж таарна. Төр-засаг нийгмийн нэг хэсгийн төлөө нөгөө хэсгээс татварлахдаа “бид үүнийг өөрсдийнх нь төлөө хийсэн юм” гэсэн үгээр хаацайлах нь л дээ. Тэгээд ч, энд төр нэг хэсгээс авч, нөгөөд өгнө гэсэн нэрийн доор асар их [бүр асар их шүү] зүйлийг өөртөө авч үлддэг. Үүнийг нь хэлж, илчилсэн хүнд маш их дургүйцнэ. Албадлагаар цэргийн алба хаалгах, өөр үзэл бодолтойгийнх нь төлөө шоронд хийх явдал бас л өөрсдийнх нь төлөө хийсэн болно. Ер нь, төрийн хийсэн бүхэн бидний төлөө болж таардаг.

Жирийн иргэдийн ихэнхийн толгойд ийм санааг шүүмжлэх бодол орж ирдэггүй бөгөөд энэ хуурмаглалд их, бага хэмжээгээр автана. Тэгэхээр “бид” бол төр биш, төр бол “бид” биш гэсэн санааг онцолж, энэ гарцаагүй баримтыг “бид бүгд хоорондоо холбоотой” гэсэн сайхан үгээр халхавчлах гэсэн оролдлого бүрийг илчлэх ёстой.

Төр нь “бид” биш, бүх асуудлаа сайн дурын харилцан зөвшилцөл дээр тулгуурлан шийдвэрлэж байдаг “хүмүүний гэр бүл, клуб, уулзалт-цуглаан” биш юм бол юу болж таарах вэ? Товчхондоо, төр гэдэг бол тодорхой газар нутгийн хүрээн дотор албадлага-хүчирхийллийг дангаар ашиглахыг оролдож байдаг байгууллага; тэр тусмаа сайн дурын хандив дээр тогтодоггүй, ямар нэг үйл ажиллагаа явуулсныхаа төлөө татвар авдаг, албадлага дээр тулгуурласан байгууллага болно.

Хувь хүн болон бизнэсийн байгууллагууд өөрсдийн үйлдвэрлэсэн болон үзүүлсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ төлөө албадлагын бус, сайн дурын үндсэн дээр харилцан солилцох замаар орлоготой болдог бол төр нь албадлага дээр тулгуурлан орлоготой болдог. Өөрөөр хэлбэл, шорон, цагдаа, зэвсгийн хүчээр айлгаж байж орлоготой болдог. Иймээс шорон, цагдаа зайлшгүй, түүнийг санхүүжүүлэх нь чухал болох тухай үндэслэлээ юуны түрүүнд улиглана. Тэд ямагт харагдаж буй зүйлийн хүрээнд сэтгэж, тайлбар хийх бөгөөд эс харагдах зүйлийг санаатай, санамсаргүй ямар нэг байдлаар орхигдуулдаг.

Германы аугаа социологич Франц Оппэнхэймэр (1864-1943 он. Герман-жүүд социологич, эдийн засагч. Энэ хүний Төр хэмээх зохиол англи хэл дээр 1914, 1942, 1975 онд бүгд Нью-Йоркийн “Фри Лайф Эдишн” хэвлэлийн газарт

хэвлэгдсэн) баялагтай болох хоорондоо зөрчилтэй хоёр арга зам байдаг тухай өгүүлж байв: нэг нь, дээр дурдсан үйлдвэрлэх, харилцан солилцох буюу “эдийн засгийн арга хэрэгсэл” хэмээн өөрийнх нь нэрлэсэн арга зам; нөгөө нь, үйлдвэрлэн бүтээдэггүй, бусдын бүтээсэн бараа-таваар, үйлчилгээг шууд хүчирхийлэл, албадлагын замаар булаан авах явдал. Дээрэм гэсэн үг л дээ. Ф.Оппэнхэймэр үүнийг баялагт цуглуулах “улс төрийн арга хэрэгсэл” хэмээв. Үйлдвэрлэн бүтээх явцдаа хүн өөрийн оюун ухаан, хүч чадлаа албадлагагүй ашиглах нь “жам ёсны” үзэгдэл болох нь илэрхий. Энэ бол энэ дэлхий дээр амгалан тайван амьдарч, хөгжин цэцэглэх зүй тогтол мөн. Харин албадлага, хүчирхийлэл дээр тулгуурласан мөлжлөгийн арга зам нь “жам ёсны” хуульд харш гэдэг нь тодорхой. Баялаг цуглуулах улс төрийн хэрэгсэл нь үйлдвэрлэлээс хумслан хулгайлж, сорон мөлжинө. Улс төрийн арга хэрэгсэл нь баялгийг бүтээгч, үйлдвэрлэгчдээс сорон мөлжигч, сүйтгэгч субъектүүд рүү гулгуулж байдгаараа нийгмийн баялгийн хэмжээг багасгахаар үл барам, бүтээгч хүний урам зоригийг хугалж, сэдлийг бууруулдаг.

Либертари үзэлтнүүд төр болон татвар хэрхэн үүссэн сэдвийг хөндөх бүрдээ энэ сэтгэгчээс эшилдэг бөгөөд үүнийг нь Ротбардын энэхүү эссэ болон Дэвид Бэргландын Нэгэн хичээлд багтаасан либертари үзэл номоос ч харж болно. Энд, мөн төр нь хэзээ ч нийгмийн гэрээгээр бий болдоггүй, нийгмийн бүх гишүүд нийгмийн гэрээнд орох ч бололцоо байдаггүйг үзүүлжээ. Төр нь байлдан дагуулал эсвэл мөлжлөгийн үр дүнд гарч ирдэг байна. Ротбард арай өөр газар, төрийг тодорхойлохдоо “улс төрийн арга хэрэгсэл дээр тулгуурласан байгууллага”, тодорхой хил хязгаарын доторх мөлжлөгийн систем гэсэн.

Ингээд, та бүхнийг Төрийн анатоми хэмээх бүтээлтэй эхээр нь танилцвал илүү ойлголттой болох биз ээ.

### **“Мөнгөө алдсаны баяр”**

#### ***(Татварын тухай танилтайгаа хөөрөлдсөн нь)***

Манай улсад 5-р сарын хоёр дахь долоо хоногийг “Татвар төлөгчдийн 7 хоног” гэж үздэг аж. Тэгэхээр иргэд бид чинь “татвар төлөгчдийн 7 хоног” гэгчийг тэмдэглэж байгаа юм байна. Үүнээс үүдэн, нэг танилтайгаа татварын тухай яриа өрнүүлснээ сонордуулъя. Танилыг маань Х.Х гэдэг гээд бодчихоорой.

Х.Х: Татвар гэж ер нь юу юм бэ?

Б.Б: Либертари үзлийн үүднээс янз бүрээр тодорхойлсон байдаг юм. Германы социологич Франц Оппенхэймэр Төр хэмээх зохиолдоо “Хүчирхийлэгч нь хэсэг хүнийг эрхшээлдээ оруулж, улмаар тэднийг байгаа зүйлээрээ өргөл

барихыг шаарддаг, түүнийг нь ТАТВАР гэх бөгөөд тэр татвараас төр үүсдэг” гэжээ. Либертари үзэлтнүүд Оппенхэймэрийн энэ үгийг татвар болоод төрийн үүслийн талаарх хамгийн оновчтой тодорхойлолт гэж үздэг.

Х.Х: Яг л, солонгос кинон дээр гардаг гангстерүүд (дээрэмчид) шиг болох нь ээ. Тэр дээрэмчид зах дээр очоод, жижиг наймаачдыг эрхшээлдээ оруулан, тэднээс мөнгө авдаг. Үүнийхээ хариуд бусдын халдлагаас тэднийг хамгаална.

Б.Б: Наадах чинь маш тохирсон аналогичлол байна. Төр ч гэсэн авсан татварынхаа хариуд биднийг хамгаална гэдэг юм. Гэхдээ энэ амлалтаа биелүүлж чаддаггүйгээр үл барам өөрөө эргээд биднийгээ дарамталдаг.

Бас нэг тодорхойлолт хэлэхэд “Татвар гэдэг бол зөв зүйл хийсний төлөөх торгууль, торгууль гэдэг бол буруу зүйл хийсний төлөөх татвар” гэсэн үг ч байдаг. Татвар гэдэг бол торгуультай адил мөнгөн шийтгэл юм даа.

Х.Х: Гэхдээ “Хүн төрөх нь үнэн, татвар төлөх нь үнэн” гэдэг шүү дээ. Нийгэмд амьдарч байгаагийн хувьд төрд хэдэн төгрөг тушаах нь зүйн хэрэг биз дээ?

Б.Б: Бид ер нь “миний хөлс хүч, цаг нар, авьяас чадвараа заран байж хийсэн зүйлийг хэн нэгэн зүгээр л авчаж болох уу” гэсэн энгийнээс энгийн асуултыг өөртөө тавьж чадахаа больчихсон байна шүү дээ.

Х.Х: Тэгэхээр, төрийг бараг дээрэм хийчихлээ гэх гээд байна уу?

Б.Б: Том биетэй, хутга барьсан хэн нэгэн тан дээр ирээд, хөдөлмөрлөж олсон мөнгөний тань 1/10-ийг авчихлаа гэж бодъё. Тэр хүн биеэр том, түүнээс гадна зэвсэгтэй учраас та хүчин мөхөсдөхийн эрхэнд хөдөлмөрлөж олсон мөнгөнөөсөө өгч таарна. Энэ бол дээрэм. Тэгвэл тэр хүний оронд цаас барьсан, цагаан цамц, зангиатай хүн хүрч ирээд, дээрхтэй адил шаардлага тавибал та бас л мөнгөө өгөхөөс өөр аргагүй. Учир нь тэр цаасан дээр мөнгөө өгөхгүй бол “тэгж шийтгэнэ, ингэж торгоно” гэсэн үг бичээстэй байдаг. Тэгэхээр энэ хоёр хүний хооронд ёс суртахууны ялгаа байна гэж үү! Аль, алин нь хүний төрөлх эрхэд халдаад байгаа биз дээ.

Х.Х: Төр татвараар дамжуулан, хувь хүний өмчлөх эрхэд халдаж байгааг хэлж байна уу?

Б.Б: Тийм, Локк өмчлөх эрхийг амьд явах, эрх чөлөөтэй байх эрхүүдтэй эн тэнцүү төрөлх эрх гэж үзсэн. Хувь хүний зарцуулсан хөдөлмөр, цаг хугацаа, авьяас чадварын үр дүн болох өмчид хэн ч халдаж болохгүй. Татвар бол үүнд халдаж буй хэрэг. Өгч байгаа хүний хувьд хулгайд алдах, дээрэмдүүлэх,

татварлуулахын аль нь ч адилхан, хөдөлмөрлөж байж олсон эд хөрөнгө, мөнгөө алдаж байгаа хэрэг. Цагаан цамц, зангиатай хүн цагдаа дагуулж ирээд, авч байна уу, эсвэл түүнээс арай муухан хувцастай нэгэн ганцаараа байна уу гэдэг нь түүний хувьд огт ялгаагүй. Аль ч тохиолдолд мөнгөөрөө хохирч байна. Гэтэл бид хутга барьсан хүнд мөнгөө алдахдаа дээрэмдүүлчихлээ гэдэг атлаа цаас барьсан хүнд нь алдахыгаа тэгэх ёстой мэт бодоод заншчихаж.

Х.Х: Дээрэм, татвар хоёр тэгээд, адил юм уу?

Б.Б: Нэг нь хуулийн нэрний доор хийгддэг, нөгөө нь, хуулиас гадуур хийгддэгээрээ ялгаатай. Уг нь бусдын юмыг авахын тулд ямар ч сайхан хууль гаргасан тэр нь зөв байж эс чадна. “Хуулийн дагуух бүх юм зөв байдаггүй” гэж Р.У.Грант Талхны гайхамшигт машин номдоо бичсэн нь үүнийг л хэлээд байгаа юм шүү дээ. Улмаар дээрэмчин, татварлагч хоёрын хооронд өөр ч ялгаа бий.

Х.Х: Ямар ялгаа?

Б.Б: Хулгайч, луйварчин, дээрэмчдэд ичих сэтгэл байдаг. Тэд мөнгийг минь авчхаад, хурдхан шиг зугтаж, нуугдахаа боддог. Гэтэл төрийнхөн ичихгүйгээр үл барам биднийг баяр баясгалантай байхыг шаарддаг.

Х.Х: Баяр баясгалантай байхыг яаж шаарддаг гэж?

Б.Б: “Татвар төлөгчдийн 7 хоног” гэдэг нь нэгэн төрлийн баяр, өдөрлөг юм шүү дээ. Мөнгийг маань авчхаад “баярла, инээ” гээд байдаг стэйтистүүдийн увайгүй шинж оршдог.

Х.Х: Тэгж ярихдаа хүрэх юм бол бидний өмчлөх эрхэд төрийнхнөөс гадна худалдаа хийж буй зальтай худалдагч, автомашиныг маань засаж буй хулхи засварчин гээд олон хүн халддаг биз дээ?

Б.Б: Ер нь хүний өмчлөх эрхэд хулгайч, луйварчид (залилан хийгчид), дээрэмчид, төрийнхөн хамгийн их халддаг. Эдгээрээс хулгайч, луйварч, дээрэмчидтэй хийх тэмцэл арай хялбар, үр дүнгээ өгнө. Харин төрийнхөн бусдын хүч хөдөлмөрийг завшиж буй энэ үйлдлээ хуулиар хамгаалсан байдаг учраас тэдэнтэй хийх тэмцэл их хүнд.

Х.Х: Бүх хүн л татвар төлдгөөс хойш өгөхөөс өөр яах вэ дээ! Татварт очсон мөнгө эргээд нийгэмд зориулагддаг биз дээ?

Б.Б: Уг нь төрийнхөн биднээс мөнгө авахдаа амладаг зүйлээ биелүүлдэг бол болж л байна. Гэтэл биднээс авсан мөнгөнөөс тансаг хэрэгцээндээ зориулж, маш ихийг авч үлддэг. Иймээс татвар авахын тулд ажиллуулж байгаа утгаар нь биднийг боолчилж байна гэж үзэж болно.

Х.Х: Тансаг хэрэглээндээ зориулдаг талаар ганц хоёр жишээ хэлж болох уу?

Б.Б: Ганц хоёр байтугай болно. Барагдахгүй их юм болно. Юу ч хийдэггүй атлаа асар өндөр цалин, утас унааны мөнгө, маш үнэтэй үйлчилгээнүүд, хэрэглэж буй бүх зүйл нь асар өндөр үнэтэй, бүгдийг бидний татвард өгсөн мөнгөөр төлүүлнэ. 10-аад Яамтай болоод л байсан, одоо хэд ч болчихов. УИХ-ын гишүүний туслах гээд нэг хүн байдаг байсан одоо 4-5 гэж дуулдана лээ. Хамгийн балиар нь хууль санаачилж батлуулбал 10-20 саяыг авдаг гэж байгаа. Ажлаа хийлээ тэр шүү дээ. Ийм логикоор багш хичээл орвол цалингаасаа гадна баахан мөнгө авч, эмч хүн үзвэл мөн л цалингаасаа гадна мөнгө авахад болох нь байна шүү дээ.

Ер нь УИХ-ын гишүүн, жирийн нэг иргэн хоёр татварт өгсөн мөнгөнөөсөө эргүүлэн хэрэглэж буй хэмжээг харьцуулбал 100:1 болов уу. УИХ төсөв батлах бүрдээ өөрийнхөө (төрийнхөө гэсэн үг) зардлыг томсгодог. Одоо лав 5-6 триллион төгрөг болсон догоо. Гэтэл нэг триллион төгрөг гэдэг чинь 1 000 000 000 000 төгрөг шүү дээ.

Х.Х: Татвар төлснөөр нийгэм дэх бүх хүн хождог гэж төрийнхөн хэлдэг шүү дээ.

Б.Б: Худлаа. Бүх хүн биш, тэд өөрсдөө л их хождог. Жирийн иргэд бид татварт төлсөн мөнгөнөөсөө юу ч авч чаддаггүй шахуу. Харин төр таны өгсөн татварын мөнгөөр л амь зуудаг болохоор “Татвар оршихуй доор төр оршино” гэх нь үнэнд хамгийн ойр тусна даа.

Тэгвэл төр гэдэг чинь юу билээ гэж бодоод үз. Энэ бол хоосон хийсвэр зүйл биш, цагаан цамц өмсөж, зангиа зүүсэн, нүдний шилтэй, тарган цатгалан хүн. Тэгэхээр та дээрх үгийг “татвар оршихуй доор цагаан цамц өмсөж, зангиа зүүсэн тарган хүн тансаглана” хэмээн уншиж болох нь байна. Бид тэр тарган нөхөрт мөнгөө алдсанаа баяр гэж үзэн, тэмдэглэх ёстой юм л болоод байна!

Х.Х: Цаадуул чинь бас “татвар бол нийгэм оршихуйн үндэс” гэдэг юм билээ?

Б.Б: Бас л худлаа хэлж байгаа юм. Гоё, сүржин үгээр чамайг хуурч, бас сүрдүүлж байна. Нийгэм, тэртэй тэргүй өөрийгөө аваад явчихдаг хувь хүмүүсээс бүрддэг. “Татвар бол төр оршихуйн үндэс”.

Х.Х: Үнэндээ, цагаан цамц өмсөж, зангиа зүүсэн тэр нөхрийн тансаг амьдралын төлөө хөдөлмөрлөж байгаа юм бол бид чинь “боол” мөн. Өөрийнхөө төлөө биш, тэр цагаан цамцтаны төлөө албадлагын хөдөлмөр эрхэлж байгаа юм байна: 7 хоногт 40 цаг хөдөлмөрлөөд, авсан мөнгөнийхөө 10%-ийг татварт (тэр тарган эрд) өгдөг бол 40 цагийнхаа 1/10-д албадлагын хөдөлмөр эрхэлж байгаа нь үнэн болж таарах нь!

Б.Б: Либертари үзэл яг үүнийг чинь л хэлээд байдаг юм шүү дээ, тиймээс ч төрийнхөн энэ үзлийг их ад үздэг.

Х.Х: Нээрэн, төрийнхнийг тансаглуулахын тулд мөнгө төлдөг гэж бодохоор

үнэхээр зэвүү хүрч байна шүү?

Б.Б: Татвар яагаад их байдгийг мэдэх үү? Х.Х: Мэдэхгүй.

Т.Т: Төр том учраас татвар их байдаг юм. “Төр бага бол зардал бага, зардал бага бол татвар бага, татвар бага бол бидний орлого их, орлого ихэсвэл, амьдрал маань сайжирна”. Тэгэхээр татварыг бууруулах ганц арга зам бол төрийн эрх мэдэл, тансаглалыг багасгах явдал юм.

Х.Х: Төр биднээс нэлээд хэдэн төрлийн татвар авчигдаг байх шүү?

Б.Б: Тийм шүү, янз бүрийн шалтаг шалтгаан тоочиж байгаад, авах мөнгөө нэмээд л байдаг юм. Хүмүүст санаа өгөх үүднээс мэдэж байгаагаа тоочъё. Орлогын татвар, худалдааны татвар, нэмүү өртгийн татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар, тээврийн хэрэгслийн татвар, замын татвар, агаарын бохирдлын татвар, онцгой татвар, тансаг хэрэглээний татвар гээд мөн ч олон татвар бий. Эдгээрээс гадна “чимээгүй татвар” буюу “нуугдмал татварын” талаар хүмүүс бага мэдлэгтэй байдаг. Энэ бол үйлдвэрээс гарч буй талхны материалын (гурил, тос, давс, гурил исгэгч гэх мэт) үнэ, ажилчны цалин хөлс, цахилгаан, дулааны өртөг, машин техникийн элэгдэл хорогдлын зардал, энэ бүхэн дээр ашгаа нэмээд, нэг ширхэг талхыг 900 төгрөгөөр худалдахаар тооцоолчоод байтал нь татвар оноосноос болж, үйлдвэрлэгч маань татварт алдсан мөнгөө нөхөхийн тулд нөгөө талхаа 1000 төгрөгөөр зарна. Нэмэгдсэн 100 төгрөг үйлдвэрлэгч, худалдан авагч хоёрын хэнд ч ашиггүй, харин төрд л ашигтай. Ингээд жирийн иргэдийн хоол унд, хувцас, тээврийн хөлс, байр сууцанд очих ёстой байсан мөнгө төрд очдог. Энд үйлдвэрлэгч, худалдагч, хэрэглэгч гээд бүгд хохирч байхад, ганцхан төр л хождог. Тэгэхээр татвар бол бизнест халтай, зүгээр сууж байгаад ихээхэн мөнгө авдаг төрийнхөнд ашигтай зүйл.

Х.Х: Төр татвар цуглуулахаас өөр юу хийдэг юм бэ дээ? Энэ л тэдний хийдэг гол ажил нь уу?

Б.Б: Төрийн үндсэн бизнес бол “асар олон хүнээс (ард түмнээс ) бага, багаар цуглуулаад, маш цөөн хүнд (төрийнхөнд) асар ихээр тарааж өгөх явдал” гэж хэлж болно.

Х.Х: Татварын хор хөнөөлийг товч бөгөөд тодорхой хэлээдэхээч?

Б.Б: Нэгд, Илт харагддаг нэг зүйл бол татвар нь хүний орлогыг багасгадаг.

Хоёрт, Олсон мөнгөө бусдад алдаад байгаа хүний ажиллах идэвх, санаачилга суларна. Гуравт, Татварт дарамтлагдсан жижиг, дунд бизнесийнхэн зах зээлээс шахагддаг. Эсвэл “болох-болохгүй” зүйл хийж эхэлдэг. Буруу зүйл хийдэггүй юм гэхэд борлуулах гэж байгаа бараан дээрээ татварын мөнгийг нэмнэ, тэгснээр худалдан авагчид л хохирно (Худалдан авагч хохирч байгаа юм бол

дэлгүүрийн эзэн ч цаагуураа мөн л хохирч таарна). Дөрөвт, Татвар нь хөрөнгө оруулагчдыг хөрөнгөө эрэлт ихтэй, ашигтай салбар руу биш, татвар багатай, нийгэмд ашиггүй салбар руу оруулахад хүргэдэг. Эрэлтгүй салбарт хөрөнгө оруулсан бизнес шатна. Тавд, Татвар нь хүний цагийг үнэхээр “алдаг”. Та урьд өмнө өөрийн хөдөлмөрөөр бүтээсэн эд хөрөнгө, одоогийн хөдөлмөрөөс татварлуулснаар өнгөрсөн хийгээд одоогоо алдаж буй хэрэг.

Х.Х: Чи тэгэхээр одоо явагдаж буй “Татвар төлөгчдийн долоо хоногоор” баярлах нь бүү хэл, энэ арга хэмжээг үзэн ядаж байгаа хүн юмаа даа?

Б.Б: Ийм арга хэмжээний цаад утга учрыг би л лав олж харж байна. Тэгээд ч мөнгөө алдсаны баяр хийж байдаг хүн нь би биш гэж байгаа юм. Төрийнхөн л шүүх, цагдаатайгаа нийлж байгаад, надаас хэдэн төгрөг салгаж чадсандаа баяртай байдаг юм байгаа биз!

Х.Х: Манайд чинь Татварын алба гээд нэг мундаг том алба байдаг байх аа?

Б.Б: Тийм ээ, “чиний хийж бүтээсэн баялгийн 10% нь минийх” хэмээн шулуухан хэлж чаддаг ганц байгууллага.

Х.Х: Төр энэ албанд их ач холбогдол өгч, харж үздэг юм шиг байдаг?

Б.Б: Олон түмнээс улам сайн татварлаарай, тэгвэл та нарыг бүр том сайхан байшинд суулган, цалинг чинь нэмж, сайхан машин унуулаад, эрх ямбыг чинь дээшлүүлнэ шүү гэж тэгж байгаа юм. Төр ингэж л өөрийгөө томруулдаг байхгүй юу!

Х.Х: Ер нь бидний татварт өгсөн мөнгө хаачихдаг юм бэ? Төрийн түшээ гэх нэг нөхөр эмнэлэг, боловсрол, батлан хамгаалах, цагдаагийн хөлсөнд явдаг гэсэн ухааны юм яриад байна лээ.

Б.Б: Цаадуулын чинь яриад буй зүйлс бол харагдаж байгаа нь! Харагдахгүй байгаа зүйл нь татвар төлөгч хүмүүсийн амсаж буй хохирол. Тийм ээ, улсын төсвийг бидний татвар бүрдүүлдэг, тэр мөнгө үр хүүхдийг маань сургах, эмчлэх, биднийг хамгаалах цагдаа-хуулийнханд зарцуулагддаг, гэтэл авсан юмаа эргүүлж өгөөд байхад бидний бухимдаад байдаг буруу юм байна л даа! Яг ийм үг хэлэхийг төр хүлээж байгаа гэдгийг иргэн та ойлгох хэрэгтэй. Үнэндээ, нийгэмдээ өгсөн тэр мөнгөнөөс тань төр асар их хэмжээгээр завшдагт гол нь байгаа юм.

За яах вэ, бидний татварт өгсөн мөнгө шударга, зөв зарцуулагддаг байлаа гэж бодъё (үнэндээ, ийм зүйл байдаггүй), тэгвэл эндээс юу харагдах вэ? Боловсрол, эрүүлийг хамгаалахад зориулсан мөнгө хэзээ нэгэн цагт, ямар нэг байдлаар ач тусаа эргээд өгдөг бол төрд зориулсан мөнгө цэвэр алдагдал болдог. Гэтэл төр-засагт байгаа тэр хүмүүс өөрсдийгөө “бага хэрэглэж байгаа” гэж илт худал хэлдэгт л либертари үзэлтнүүд дургүйцээд байгаа юм.

Х.Х: Иргэдийнх нь ухамсар өндөр хөгжсөн орнуудад “Татвар төлөгчдийн өдрийг” тэмдэглэдэггүй юм уу?

Б.Б: Татвар Төлөгчдийн Өдрийг биш харин эсрэгээр нь Татвараас Чөлөөлөгдсөн Өдрийг (Tax Freedom Day) тэмдэглэдэг. Энэ өдрийг бодож, гаргадаг аргачлалыг Адам Смитийн Хүрээлэнгийнхэн гаргасан байдаг юм.

Гэтэл манайд “татвар төлөгчдийн 7 хоногийг” тэмдэглэж байдаг. Үнэхээр утгагүй. Утгагүй ч юу байх вэ, иргэдийн харанхуй байдал дээр тоглож, нэг ёсондоо даапаалж байгаа хэрэг л дээ.

Х.Х: Татварт эргэлзэж байсан хүмүүс та нараас өөр байдаг юм уу?

Б.Б: Бүх либертари үзэлтнүүд эсэргүүцнэ. Үүнээс гадна зүв зүгээр суугаад, мөлжиж байдаг хүмүүст мөнгө өгөх нь буруу гэсэн утгатай христийн шашны нэгэн домог байдаг. “Татвар төлөх ёстой юу?” гэсэн дагалдагчдынхаа асуултад Христ хариулахдаа “Цезарьт (төрд) өгсөн зүйл Цезарийнх болно, харин Бурханд өгсөн зүйл Бурхных болно” гэж. Эндээс л төрд татвар өгөх нь зөв үү, буруу юу гэсэн эргэлзээ эхэлсэн болов уу.

Х.Х: Либертари үзэлтнүүд ингээд л хачин, хачин зүйл ярьж, өөртөө дайсан хурааж байдаг юм гэсэн яриа сонстдог юм?

Б.Б: “Төр бол бусдын хүчээр амьдрагчдын гэр орон мөн”, “Татвар бол хуульчлагдсан дээрэм” гэх мэт илэрхийллүүдээрээ бид ганц л юмыг хүсдэг. Төр нь монголчуудын иргэний ухамсрыг сэргээх явдал юм. Төрийн нэр доор бүгсэн хэдэн хүнд “боолчлогдож” байдгаа болиосой, ядахад тийм байдлаа ойлгоосой, тэдэнд өгч буй мөнгөнийхөө хойноос санаа зовж байгаасай гэсэндээ энэ бүхнийг хэлээд байгаа хэрэг. Иргэд маань тогтчихсон гээд буй үзэгдлийн талаар жаахан гүнзгийрүүлж сэтгэдэг, юм боддог, нэг дэх үр дагавраас цаашид хоёр, гурав дахь үр дагаврыг олж хардаг болох хэрэгтэй байна.

Философийн ухааны доктор Б.БАТЧУЛУУН /Улс төрийн Боловсролын Академийн зөвлөлийн гишүүн/



## МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛ, ХАНДЛАГА, ШИЙДЭЛ


*Доктор Э.Гэрэлт-Од*

### Абстракт

Энэхүү өгүүлэл нь Монгол дахь улс төрийн намуудын гишүүнчлэлийн талаарх өнөөгийн төлөв байдлыг судлан, цаашид улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд шийдвэр гаргагчдад зориулж намын гишүүнчлэл ямар байх, гишүүнтэй холбоотой бүртгэл, хяналтын байгууллагын шаардлага, улс төрийн намын үйл ажиллагаанд гишүүнтэй холбоотой зөвшөөрсөн болон хориглосон заалтууд ямар байх зөвлөмж агуулж байгаа болно.

Түлхүүр үг: улс төрийн намын гишүүн, гишүүнчлэл

Монгол Улсад өнөөдрийн байдлаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн 22 нам байна. Эдгээр намууд Монгол Улсын Үндсэн хууль (1992) болон бусад хуульд нийцүүлэн үйл ажиллагаа явуулж иргэний эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, төлөөллийн байгууллагаараа дамжуулан төрийн эрх барих зэрэг ардчиллын үнэт зүйлсийг нийгэмд түгээн дэлгэрүүлэх үүрэг хүлээсэн. Гэвч өнгөрсөн 25 жилийн хугацаанд улс төрийн намууд хариуцлагатай, ардчилалтай болж төлөвшиж чадаагүйн улмаас иргэдийн улс төрийн намд итгэх итгэл жил ирэх тутам суларч байгааг сүүлийн үеийн судалгаа, нийгмийн хандлагаас харж болно. Тухайлбал, Азийн Барометр судалгаагаар 2000 онд улс төрийн намд итгэдэг сонгогчийн тоо 47.8 хувь, итгэдэггүй сонгогчийн тоо 40.6 хувь байсан бол 2014 оны байдлаар намд итгэдэг сонгогчийн тоо 32,8 хувь болтлоо хоёр дахин буурч, итгэдэггүй сонгогчийн тоо 67,3 хувь болж хоёр дахин нэмэгджээ /Зураг 1/. Энэ нь улс төрийн намууд хууль ёсны /легитим/ шинжээ алдсан, сонгогчдын улс төр, намд итгэх хандлага суларсаар байгааг илтгэж байна.



Зураг 1. Улс төрийн намд итгэх итгэл<sup>1</sup>

Ийнхүү иргэдийн намд итгэх итгэл суларч байгаа шалтгааныг нэгд, улс

төрийн намын эрх зүйн орчин, хоёрт намуудын үйл ажиллагаа, гишүүнчлэл, гуравт иргэдийн улс төрийн боловсролтой шууд холбоотой.

Монгол улс Үндсэн хууль болон бусад хуулиудаар улс төрийн намын ерөнхий эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Үүнд, Үндсэн хуулийн 2 бүлгийн 16 дугаар зүйлд “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ...Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно”<sup>2</sup> гэж заасан. Мөн Улс төрийн намын тухай хуулийн 3 дугаар зүйлд Монгол улсын иргэний эвлэлдэн нэгдэх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох, зөвхөн нэг намын харъяалалтай байх, улс төрийн намд элссэний төлөө ямар нэгэн дарамт, шахалт, ялгаварлан гадуурхахыг хориглох, мөн ямар нэгэн давуу байдал олж авах үндэслэл болохгүй, иргэний хувийн байдлыг тодорхойлсон аливаа албаны бичиг баримтад хуульд зааснаас бусад тохиолдолд тухайн иргэний зөвшөөрөлгүйгээр аль намын гишүүн болох талаар тодорхойлохгүй байх<sup>3</sup> зэргийг тус тус баталгаажуулсан. Өөрөөр хэлбэл, улс төрийн намууд гишүүнчлэлийн хувьд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж байх үүрэг хүлээсэн. Харин гишүүний бүртгэл, хяналт, мэдээллийг зохицуулаагүй орхисон нь 1990, 2005 оны хуулиудын сул тал юм. Үр дүнд нь намууд гишүүдийнхээ тоог нэмэгдүүлэх сонирхлыг өдөөж ирсэн болохоос бүртгэлийг үнэн зөв хөтлөх, жил бүр гишүүдийн статистик мэдээллийг бүртгэлийн байгууллагад уламжлах ажлыг хийж ирсэнгүй.

Улс төрийн намууд хуучин коммунист хатуу гишүүнчлэлийн хэв шинж, арга барилыг үйл ажиллагаандаа хадгалсаар байна. Тухайлбал, намууд улс төрийн зорилгоор төрийн болон хувийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг олноор элсүүлэх, төрийн албаны зарим ажил, албан тушаалыг өмчлөх, мөн гишүүдийнхээ

Хүснэгт 1. Улс төрийн намын гишүүдийн тоо<sup>1</sup>

№	Улс төрийн Нам	Гишүүдийн тоо
1	МАН	163100
2	Ардчилсан нам	150000
3	МНН	2100
4	ИЗНН	35000
5	МУНН	1503
6	МЛАН	863
7	Эх орон нам	160000
8	МЛН	1300
9	БНН	50000
10	МЭҮН	1069
11	МСДН	3000
12	Ард түмний нам	11859
13	МУАН	26000
14	ЭЧХН	1600
15	ИХН	815
16	ХХН	933
17	МАХөН	850
18	МАХН	35000
19	ХМХН	2000
20	ХөҮН	1024
21	ЭОНН	2150
22	МКН	959
		651025

үзэл санаа, байр суурийг хязгаарлах, шахалт үзүүлэх, гишүүнийг намаас хөөх зэрэг аргыг хэрэгслээр байна. Энэ нь нийгэмд хатуу гишүүнчлэлийн сөрөг тал болох нийгмийн талцал, социал ялгарал, лидерийг дахин шүтэх, олигархичлал үүсэхэд нөлөөлж байна.

2014 оны байдлаар Улсын дээд шүүхэд 651,025<sup>5</sup> гишүүн (Хүснэгт 1) улс төрийн намуудад бүртгэлтэй байна. Энэ нь нийт 1,836,548<sup>6</sup> (2012 оны УИХ-ын сонгуулийн дүн) сонгогчдын 35 хувь юм. Намын гишүүдийн энэ тоо нь анх бүртгэхэд мэдүүлсэн тоо, зарим намын гишүүдийн тоо сүүлийн арав гаруй жил огт өөрчлөгдөөгүй. Энэ тоо бодит байдалтай нийцэх үү гэдэг маргаантай. Сонгуулийн үеэр улс төрийн намуудын зарлаж буй гишүүдийн тоо бүртгэлийн тооноос давна. Гэтэл судалгаагаар сонгогчид улс төрийн намд итгэхгүй байхад яагаад намын гишүүдийн тоо нэмэгдсээр байна вэ? Энэ нь улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд намын гишүүнчлэл хатуу, сул гэхээс илүү гишүүн элсүүлэхэд тавигдах шаардлага, бүртгэл, мэдээллийн шинэ тогтолцоог шаардаж байна.

Түүхээс харахад улс төрийн нам гишүүн элсүүлэх, гишүүдээ бүртгэх, мэдээлэх үүрэг нь зохион байгуулалтын ямар хэв маягтай, ямар үзэл сурталтай байхаас шууд хамааралтай байсан. Онолын хувьд энэ нь массын буюу олон түмний намууд хатуу гишүүнчлэлтэй, харин элитийн, кадрын, кокус намууд сул гишүүнчлэлтэй буюу дэмжигчдэд тулгуурласан бодлого баримталдаг байсантай холбоотой.

XX зууны дунд үе хүртэл намуудын онцлог шинж нь гишүүнчлэл, гишүүдийн тоо байсан. Энэ нь улс төрийн нам массын болж сонгогчдын татах арга нь олон түмний нам болж зохион байгуулагдаж, олон гишүүнтэй нам олон түмэнд илүү нөлөөлөх боломжтой гэж үзэж байсан юм. Хатуу эсвэл сул гишүүнчлэлийн тухай асуудал /Хүснэгт 2/ нь ардчилсан эсвэл коммунист улс төрийн тогтолцоо, кадрын эсвэл олон түмний нам байхаас хамааралтай бодлогын ялгаа юм. Харин өнөөдөр дэлхий даяар глобалчлал, хүний эрх, эрх чөлөө, олон ургальч үзлийн талаарх ойлголтууд өргөжин тэлсэн, улс орнуудын дэглэмийн туйлшрал намжсан, үзэл суртлын ялгарал буурсан зэргээс хамаарч хатуу гишүүнчлэлээс татгалзах хандлага ажиглагдаж байна.

Хүснэгт 2. Намын гишүүнчлэлийн хэлбэр<sup>7</sup>

Шалгуур	Хатуу гишүүнчлэл	Сул гишүүнчлэл
Гишүүн элсүүлэх шалгуур	Үндсэн хууль ба бусад хууль, намын дүрэмд заасан зохих шалгуурыг баримтална.	Үндсэн хуулинд заасан хүний эрхийг суурь зарчим болгоно.

Гишүүний татвар	Дүрмээр заасан татварыг зайлшгүй төлөх үүрэгтэй.	Намын жирийн гишүүн хүн сайн дураараа төлөх эрхтэй.
Гишүүний хариуцлага	Дүрмийн хүрээнд гишүүдэд хатуу хариуцлага ноогдуулна. Шаардлагатай гэж үзвэл намаас хөөнө.	Дүрмийн хүрээнд гишүүнд хариуцлага тооцох боломжгүй.
Шийдвэр гаргах үйл явцад гишүүний оролцоо	Намын бүх шатны байгууллагын удирдлагууд дангаар шийдвэр гаргана. Гишүүд дуулгавартай байх үүрэгтэй.	Шийдвэр гаргах үйл явцад гишүүдийн оролцоо нээлттэй.

Хатуу гишүүнчлэлтэй намууд төрийн байгууллагын дотоод нэгж болж гишүүдийг ажил мэргэжил, албан тушаалаар нь эслүүлж, намын бодлого, үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, намдаа үнэнч байх, сонгуулийн үеэр үнэгүй хөдөлмөр эрхлүүлэх, намдаа санал өгөх арга хэрэгсэл болгодог. Намын гишүүн сахилга алдах, намын даалгаварыг хэрэгжүүлэхгүй байх, намын дүрэм зөрчихөд намаас хөөх хүртэл шийтэл авдаг, энэ нь тухайн нийгэмд эзлэх байр суур, статусыг тодорхойлдог байжээ. Харин орчин үед иргэний өөрийн улс төрийн үнэт зүйл, чиг баримжаанд тулгуурлан намд элсэх, намын үйл ажиллагаанд оролцох, эс оролцох, намаас гарах эрх нь зөвхөн өөрт хадгалагдаж байна. Дэлхий даяар улс төрийн намууд хатуу гишүүнчлэлээс татгалзах хандлага илэрч байна. Судлаач Р.Катз, С.Скарроу, П.Мейр, Ван Бейзин нар “намын гишүүнчлэл, намын гишүүдийн улс төрийн намын дотоод үйл ажиллагаанд оролцох оролцоо нь хүн ам зүйн, нийгэм-эдийн засгийн, мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэсэн хүчин зүйлүүдээс шалтгаалж өөрчлөгдөж байна”<sup>8</sup> гэж тайлбарлаж байна. Эдгээр шалтгааныг гадаад, дотоод гэж ангилж болж байна. Үүнд:

- Гадаад хүчин зүйл. Нийгмийн хандлага өөрчлөгдсөн, хүний эрх, эрх чөлөөний ойлголт хүрээгээ тэлсэн, харилцааны олон сувгууд бий болсон, нийгмийн дундаж давхаргын төлөөлөл нэмэгдсэн.
- Дотоод хүчин зүйл. Намын гишүүдийн насны бүтцэд олонх нь ахимаг насныхан эзэлдэг, дунджаар 20-30 жилийн циклээр намын социаль бүтэц бүрэн өөрчлөгддөг, намын элит, лидерүүд гишүүдийн итгэлийг алдсан, улс төрийн үзэл баримтлал, үнэт зүйлээ тодорхойлох арга замууд нэмэгдсэнтэй холбож тайлбарлаж байна.

Шведын Ардчилал Сонгуульд туслах Олон улсын хүрээлэн (International IDEA) 2012 онд Монголын улс төрийн намуудад гишүүнчлэлийн асуудалд зөвлөмж өгсөн. Үүнд гишүүнчлэл бол улс төрийн намын хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ асуудалд өнгөц хандаж болохгүйг сануулсан. Учир нь улс төрийн нам гишүүнтэй байх нь дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Гишүүд дэмжигчид нь намд хэрэгцээтэй төрөл бүрийн нөөцийг бий болгодог.
2. Сонгуулийн кампанит ажлын үед илүү амжилт олох магадлал нэмэгдэнэ.
3. Шинэ гишүүн, дэмжигчдийг олж авахад туслана.
4. Гишүүнчлэлийн татвараас орлогын нэг эх үүсвэр бүрдэнэ.
5. Боловсролтой, чадварлаг боловсон хүчин, нэр дэвшигчдийг бүрдүүлнэ.
6. Намын үзэл суртал, мөрийн хөтөлбөрт дэмжлэг авна.
7. Нийгмийн бүлэг, сонгогчидтой холбогдох гүүр болно.
8. Нам дахь сайн дурын хөдөлмөр эрхлэлт буюу идэвхитэй гишүүд дэмжигчдийн оролцоог ашиглан сонгууль, улс төрийн ажил хийх зэрэг давуу байдлыг олж авахад дэмжлэг болно<sup>9</sup>.

Иймээс нам гишүүнгүй байх ямар ч боломжгүй бөгөөд харин гишүүд дэмжигчид, сонгогчдын итгэлийг олж авахын тулд илүү хариуцлагатай улс төрийн хүчин болж төлөвших шаардлага тулгарсаар байна. Намын гишүүд аливаа улс төрийн ажилд адил тэгш байдлаар оролцох боломжгүй. Иймээс гишүүд дэмжигчдийг доод тал нь 5 төрөлд хуваах хэрэгтэй<sup>10</sup>.

1. Намын кадр: сонгогдсон албан тушаалтан буюу намд алба хашдаг гишүүд;
2. Идэвхитэй гишүүд: бодлого боловсруулах хуралд оролцож, олон нийтэд хүрэх, тэднийг дагуулах, улс төрийн намыг өргөжүүлэн тэлэх ажилд оролцдог гишүүд;
3. Оролцоо бүхий гишүүд: голцуу намын зөвлөлдөх хурал зэрэг чухал хурлуудад оролцдог гишүүд;
4. Дэмжигч гишүүд: гишүүнчлэлийн төлбөр төлдөг ч бусад байдлаар намын үйл ажиллагаанд төдийлөн оролцдоггүй гишүүд;

5. Албан бус дэмжигчид: намд албан ёсны гишүүнчлэлгүй ч тухайн намын төлөө саналаа өгч, мөнгө хандивлах болон сонгуулийн компанит ажилд тухайн намыг дэмжиж ажилладаг.

Намын гишүүнчлэл ямар байхаас үл хамааран гишүүнээр элсэх, бүртгэл, хяналтын байгууллага хэрхэн ажиллах нь тухайн орны улс төрийн соёл болж байна. Их Британ, АНУ болон Австралийн туршлагаас харахад намын бүртгэл, хяналтын байгууллага нам байгуулахад тавигдах гишүүний босго тоо хэд байх, гишүүнээр элсэхдээ иргэний улс төрийн хүсэл зоригыг илэрхийлсэн өргөдлийн маягттай (мэдэгдэл) байх, гишүүдийн статистик мэдээг жил бүр хүлээн авч олон нийтэд мэдээлэх үүрэг хүлээдэг. Намууд ч гишүүдээ бүртгэх, мэдээллээ үнэн зөв илгээх нь намуудын нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага дотоод болон олон нийтэд чиглэсэн аливаа ажлыг зохион байгуулах, нөөц боломжоо бодитой тооцох боломжийг олгож байна. Иймээс Монголын улс төрийн намын гишүүнчлэлтэй холбоотой дараах саналыг дэвшүүлж байна.

1. Сул гишүүнчлэлийн бодлогыг хадгалах

Улс төрийн намын хуулийн шинэчлэлийн хүрээнд өнөөдрийг болтол шийдлээ олж чадахгүй байгаа олон асуудлын нэг нь намын гишүүнчлэл. Зарим улс төрчид, шийдвэр гаргагчид сонгогчдын 80 гаруй хувь нь улс төрийн намд итгэхгүй байна, гишүүдийн ихэнх нь угаасаа татвар төлдөггүй юм чинь “гишүүнгүй нам”-тай болвол зүгээр гэдэг санааг илэрхийлэх болсон. Энэ нь төлөөллийн ардчиллын институцийг устгах, нам дотоод ардчилалгүй болох, олон түмний биш цөөн тооны улс төрчдийн байгууллага болох үр дагавартай.

Тэгвэл нам гишүүнтэй байснаар дараах давуу талыг олдог. Үүнд

1. Гишүүдээс намын дэмжлэг авах;
2. Иргэдийн бодлого боловсруулах мэдлэгийг болон түүнд оролцох оролцоог нэмэгдүүлэх;
3. Намыг ирээдүйд манлайлан удирдагчдыг сонгох;
4. Төр, нийгмийн талаар бодлого боловсруулах;
5. Намын ирээдүйн удирдлага, манлайллын талаар мэдлэг хуримтлуулах; хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн төлөө сонгогдсоныхоо дараа иргэдийг төлөөлөх;
6. Гишүүнчлэлийн төлбөр авах ач холбогдолтой.

Судалгаанаас дүгнэхэд манай улс төрийн намууд хуулиар сул гишүүнчлэлийн бодлого баримтлах үүрэгтэй. Иймээс намын гишүүнчлэл ямар байх нь чухал биш, харин улс төрийн нам байгуулахад тавигдах гишүүний доод

хэмжээ, намд гишүүнээр элсэхэд өргөдлийн маягт эсвэл мэдэгдэл бөглөх, гишүүний татвартай холбоотой санхүүгийн мэдээллийг олон нийтэд ил болгох, бүртгэлийн байгууллагын намын гишүүнтэй холбоотой бүртгэх, хянах, мэдээлэх зохицуулалтын шинэ тогтолцоог бий болгох хэрэгтэй.

## 2. Бүртгэлд тавигдах гишүүдийн тоог бууруулах

Улс төрийн намын тухай хуулийн 9.3.7-д нам 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг/-тэй байхыг хуулиар шаардаж байна. Гишүүний тоонд тавигдаж байгаа энэ босгыг судлаач, сонирхогчид олон талаас ярьж хэлэлцдэг. Зарим судлаачид 801 гишүүнтэй байх бүртгэлийн шаардлага нь өндөр тоо, энэ нь улс төрийн намыг улам том болох, олон гишүүнтэй байхыг шаардаж байна. Иймээс энэ тоог бууруулах ёстой гэж үздэг. Харин сонирхогчид болон улс төрчид хуулийн энэ заалтыг нэмэгдүүлэх ёстой гэсэн байр суурийг илэрхийлдэг. Учир нь өнөөдөр 22 улс төрийн намтай байгаа нь цөөхөн хүн амыг хэт улс төржүүлж байна, хэний ч мэдэхгүй намууд олноор байна. Иймээс улс төрийн намуудыг цөөрүүлэх арга нь бүртгэлд тавигдаж байгаа гишүүний минимум тоог нэмэгдүүлэх ёстой гэж үздэг.

Гадаад орнуудын туршлагаас харахад улс төрийн нам бүртгүүлэхэд тавигдах шаардлагад гишүүний минимум тоо эсвэл дэмжигчдийн гарын үсэг<sup>11</sup> хоёрын аль нэгийг шаарддаг. Жишээ нь

- Мексикт улс төрийн нам байгуулагдахад тавигдах шаардлага нь холбооны 32 мужаас хамгийн багадаа 10 мужид 3000-аас доошгүй гишүүнтэй байх эсвэл нэг мандаттай 300 тойргын хамгийн багадаа 100-д нь 300 гишүүнтэй байх шаарддаг.
- Канадад улс төрийн нам байгуулагдахад хамгийн багадаа 250 гишүүний элсэхийг зөвшөөрсөн гарын үсэгтэй мэдэглэл, овог нэр, оршин суугаа хаягаа тодорхой бичсэн байхыг шаарддаг.
- Австралид улс төрийн нам нь хамгийн багадаа 500 гишүүнтэй байх эсвэл парламентын доод танхимд нэг суудалтай байхыг шаарддаг.
- Норвегид улс төрийн нам бүртгүүлэхдээ 5000 дэмжигчийн гарын үсэг цуглуулсан байхыг шаарддаг.
- Италид намын жагсаалтаар нэр дэвшихэд 1500-4000 дэмжигчийн гарын үсэг, нэг мандаттай тойрогт нэр дэвшвэл тойрог бүрт 500 дэмжигчийн гарын үсэг цуглуулахыг шаарддаг.
- Австри, Бельги улсуудад сонгуулийн тойрог бүрт 200-500 дэмжигчийн гарын үсэг цуглуулахыг шаарддаг.

Манай улс дэмжигчдээс гарын үсэг цуглуулах аргыг Улсын Их хурлын

сонгуулийн тухай хуулийн 6.2-т зааснаар хорин таван нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхтэй, 7.2-т зааснаар иргэн сонгуулийн нэг тойргийн 801-ээс доошгүй сонгогчийн дэмжлэг авсан нөхцөлд тухайн сонгуулийн тойрогт Улсын Их Хурлын гишүүнд нэрээ бие даан дэвшүүлэх эрхтэй<sup>12</sup> гэж хуульчилсан.

Цаашид хуулийн шинэчлэлтэй холбогдуулан

1. Улс төрийн нам байгуулахад тавигдах 801-ээс доошгүй гишүүнтэй байх шаардлагыг бууруулах,
2. Улсын Их хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчдэд тавигдах 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсэг цуглуулах шаардлагыг бууруулах хэрэгтэй.
3. Гишүүнээр элсэхдээ өргөдөл (мэдэгдэл) бөглөдөг болох

Монгол улсад улс төрийн намд гишүүнээр элсэхэд хуулиар ямар нэг шаардлага тавиагүй. Намд элсэх, намаас гарах нь зөвхөн иргэний улс төрийн эрх. Хүсвэл өөрийн иргэний зарим мэдээллээ дэлгэрэнгүй бөглөхөд шууд гишүүнээр элсэх боломжтой. Гэтэл энэ нь улс төрийн намуудыг Үндсэн хууль зөрчих, тухайлбал кампаничлах замаар олноор гишүүн элсүүлэх, улс төрийн албадлага, шахалтаар намд элсэх, эсвэл намаас хөөдөг болж байна. Иймээс бүртгэл, хяналтын байгууллагаас улс төрийн намуудад гишүүн элсүүлэхдээ баримтлах, дагаж мөрдөх, өргөдлийн маягт эсвэл мэдэгдэл бөглөдөг байхыг хуулиар шаардах хэрэгтэй. Англи, АНУ, Австрали улсууд улс төрийн намд гишүүнээр элсэхэд мэдэгдэл /declaration/ эвсэл өргөдлийн хуудас /application form/ бөглөдөг. Энэ нь хэд хэдэн ач холбогдолтой. Үүнд:

1. Намд элсэх нь зөвхөн иргэний санаачлага болохыг илтгэнэ.
2. Иргэд улс төрийн чиг баримжаа, үзэл суртал, элсэж буй намынхаа философиог таниж мэдсэн байхыг нотолдог.
3. Намын дүрмийн уншсан болохыг илтгэнэ.
4. Намаас гарах эрх нь зөвхөн өөрт нь хадгалагдаж байгааг мэднэ.

#### **4. Гишүүний татвар болон санхүүгийн тайланг мэдээлэх**

Улс төрийн нам гишүүдээс татвар авах, улмаар үйл ажиллагаандаа татан оруулах нь олон түмний намын нэг чухал шинж байсан. Харин өнөөдөр гишүүдийн татвар нь намын санхүүжилтэд эзлэх хувиараа буурсаар байна. Энэ нь намын гишүүн цөөрч, улс төрийн үйл ажиллагааны зардалд өсөж байгаатай шууд холбоотой. Сөрөг тал нь намууд бизнесмэнүүдээс илүү хамааралтай болсоор байгаа нь ажиглагдсан учир намуудыг төрөөс санхүүжүүлэх болсон.

Гэхдээ ямар ч тохиолдолд нам бол олон нийтийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан байгууллага тул гишүүд, дэмжигчдийн татвар нь санхүүжилтийн нэг эх үүсвэр байсаар байх болно. Учир нь нам иргэдийн улс төрийн оролцоо, төлөөллийг хэрэгжүүлэх суваг болдог тул гишүүдээс татвар авах замаар үйл ажиллагаандаа татан оролцуулдаг байх, орлого зардлаа тайлагнадаг, гишүүд дэмжигчид сонгуулиар хариуцлага тооцдог байх, сонгох, сонгогдох эрхийг хадгалах улс төрийн ардчилал юм.

Зарим орнуудын туршлагыг харахад гишүүд нь татвараа тогтмол төлдөг, улмаар намаар дамжуулж нийгэм, улс төрийн эрх ашгаа хамгаалдаг бол намууд нь гишүүдийн статистик мэдээлэл, гишүүдийн татвараас бүрдсэн орлогыг үнэн зөв бүртгэл, хяналтын байгууллагадаа мэдээлдэг. Тухайлбал, Их Британы Сонгуулийн хороо нь жил бүр намуудын санхүүжилтын мэдээллийг олон нийтэд зарладаг бөгөөд 2012 оны байдлаар Консерватив нам 3,1%, Хөдөлмөрийн нам 16,7%, Либераль Ардчилсан нам 14,8% Шотландын Үндэсний нам 24,1%, Их Британы Тусгаар тогтнолын нам (UKIP) – 35,7%, Английн Ногоон нам 28%, Британы үндэсний нам (BNP) 22,7%<sup>13</sup>-ийг тус тус гишүүдийн татвараас бүрдүүлсэн байна. Харин 2011 онд ХБНГУ-ын Парламентанд суудалтай улс төрийн намууд, тухайлбал Социаль Демократ нам 47,5%, Христосын Ардчилсан холбоо нам 40,1, Христосын Нийгмийн холбоо нам 10,2%, Зүүний нам 9,7%, Ногоон нам 8%, Чөлөөт Ардчилсан нам 7,4%<sup>14</sup> тус тус гишүүдийн татвараас бүрдсэн байгааг тайлагнасан байна.

Улс төрийн намын тухай хууль<sup>15</sup>-ийн 18.1-д “гишүүн намын дүрмээр зохицуулсан хэмжээгээр намд татвар өгч болно” гэж заасан. Энэ дагуу намын гишүүд ялгаатай татварыг төлж байгаа. Мөн нам дотор гишүүдийн оролцоо, гүйцэтгэж буй үүргээрээ ялгаатай татварыг гишүүдээс авдаг. Тухайлбал намын сонгуульт гишүүн АН-д 60000-1000000 төгрөг, МАН-д улиралд 800000 төгрөг төлж байхыг журмаар зохицуулсан. Харин жирийн гишүүд дунджаар сар бүр 100 төгрөгийн татвар төлөхийг дүрмээр заасан боловч хэдэн онд хэдэн гишүүдээс хэдэн төгрөгний татвар хураасан, энэ нь нийт санхүүжилтийн хэдэн хувь болох тайлан мэдээ олдохгүй байна. Мөн хуулийн 20.1-д “Намын санхүүгийн үйл ажиллагаанд тухайн намын хяналтын байгууллага хяналт тавина” гэж заасан нь санхүүгийн үйл ажиллагаа шударга бус байх, олон нийтэд тайлагнах эсэхийг өөрсдөө шийдэхээр заасан байдаг. Уул нь энэ хуулийн 20.3-т “нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ” гэсэн боловч энэ хэрэгжихгүй байгаа, улмаар гишүүдийн татварын юунд зарцуулсан нь нууц үлдэж байна. Улс төрийн намын тухай хуульд энэ заалт бий ч амьдралд дээр хэрэгжихгүй байгаа нь хуулийн зохицуулалт сул байгаа, намууд хуулиа дагаж мөрдөхгүй байгаатай холбоотой. Иймээс улс төрийн намын хуулиа дагаж мөрдөг байх хуулийн бодит зохицуулалт дутагдаж байна.

5. Бүртгэл хяналтын тогтолцоо бий болгох

Өнөөдөр Монгол улсад улс төрийн намыг бүртгэх, хянах тогтолцоог бий болгох шаардлага тулгараад байна. Учир нь хүчин төгөлдөр үйлчилж буй улс төрийн намын тухай хуулиар нам өөрөө өөрийгөө хянана, УДШ зөвхөн намын дүрэм, хөтөлбөрт оруулсан нэмэлт өөрчлөлт нь Үндсэн хууль, энэ хуультай нийцэж байгаа эсэхэд хяналт тавина. Өөр зохицуулалт байхгүй байна.

Иймээс энэхүү судалгааны өгүүлэлтэй холбоотойгоор Улс төрийн намын бүртгэлийн байгууллагыг бий болгох хэрэгтэй. Боломжит хувилбар нь Сонгуулийн ерөнхий хороог дахин институтчилах замаар намын гишүүнтэй холбоотой бүртгэх, хянах, мэдээлэх зохицуулалтын шинэ тогтолцоог бий болгох нь оновчтой.

1. Намууд гишүүдийн бүртгэлийг тогтмол үнэн бодитой хөтөлж, мэдээллийг бүртгэл хяналтын байгууллагад илгээдэг байхыг үүрэгжүүлэх. Энэ нь улс төрийн намууд үйл ажиллагаа, төсөв санхүүгээ бодитой төлөвлөж, улмаар нийгмийн хариуцлагатай институци болж төлөвшихөд нөлөөлөх юм.
2. Монголын улс төрийн намууд шинэ хуулийн үзэл санаанд нийцүүлэн гишүүдээ дахин бүртгэх. Бүртгэлд гишүүнээр элсэх өргөдөл /эсвэл мэдэгдэл/-ийг ашиглах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл шинэ хуулинд намуудын бүртгэлийг шинэчлэх замаар дахин бүртгэл зохион байгуулах, тавигдах нэг шалгуур нь гишүүнчлэлийн бүртгэл, мэдээлэл байна.
3. Бүртгэлийн байгууллага жил бүр улс төрийн намуудаас бодит мэдээлэл авах, олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээнэ.
4. Бүртгэлийн байгууллага нь улс төрийн намын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй байх ба Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хуульч зөрчиж гишүүн элсүүлсэн нь нотлогдвол улс төрийн намын санхүүжилт, цаашлаад нам байх эрх зүйн статусыг цуцлах хүртэл арга хэмжээ авах эрхтэйгээр хяналт тавигдах нь зүйтэй.

Эцэст нь дүгнэхэд дээрх шийдлүүд нь улс төрийн намын хатуу эсвэл сул гишүүнчлэлийг сонгохоос үл хамааран зайлшгүй хэрэгжүүлэх тулгамдсан асуудал бөгөөд улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлтэй холбоотой санал нь асуудлыг цогцоор шийдсэн хуулийг баталж, сайтар дагаж мөрддөг байхаар зохицуулах нь чухал байна. Мөн намын гишүүнчлэлтэй холбоотой эдгээр санал нь улс төрийн намын дотоод менежмент, нөөц боломжоо зөв дайчлахад туслах юм.

**Ашигласан материал**

Азийн барометр судалгаа. УТБА. 2002, 2006, 2010, 2014 он.

Монгол улсын Үндсэн хуулиас. <http://www.legalinfo.mn/law/details/367?lawid=367>

Улс төрийн намын тухай хуулиас. <http://www.legalinfo.mn/law/details/508?lawid=508>

Монгол улсын Дээд шүүхийн бүртгэл. <http://www.supremecourt.mn/>

2012 оны УИХ-ын сонгуулийн тайлан. СЕХ. [http://gec.gov.mn/parliamentary\\_election/310/41](http://gec.gov.mn/parliamentary_election/310/41)

Susan.Scarrow. 2005. Parties and Their Members. Oxford Press. p144

Karina Pederson. Internal Party Membership Linkage: The Danish Case. The paper presented at XIII congress in Nordic Political Science Association. NOPSA, Alborg, August 15th-17th 2002.

International IDEA. Membership of the Political parties. 2012.

Pippa Norris. 2005. Building political parties: Reforming legal regulations and internal rules. International IDEA.

Монгол улсын Их хурлын сонгуулийн тухай хууль /шинэчилсэн найруулга/  
<http://www.legalinfo.mn/law/details/351?lawid=351>

Ж.Жаргал. Улс төрийн намын гишүүнчлэлийн зарим асуудал. “Улс төрийн нам: асуудал, эрэл, шийдэл” эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ.,2014 х181

Party finance in Germany [https://en.wikipedia.org/wiki/Party\\_finance\\_in\\_Germany](https://en.wikipedia.org/wiki/Party_finance_in_Germany)

Улс төрийн намуудын тухай хууль. (2005 оны 1 дүгээр сарын 28)<http://www.legalinfo.mn/>

(Endnotes)

МУБИС-ын Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, Доктор Э.Гэрэлт-Од  
/Улс төрийн Боловсролын Академийн багш/



## УДИРДЛАГЫН ЁС ЗҮЙ

*Ч.Лхагважав-Доктор (Sc.D) профессор*

Удирдлагын ёс зүй, удирдах ажилтны ёс суртахууны асуудал бол нийгмийн түүхэн хөгжлийн бүхий л явцад хувь хүний ёс зүй, ёс суртахуунаас илүү чухал тавигдаж ирсэн нь тун ойлгомжтой. Хувь хүний ёс зүйн шалгуурыг тухайн нийгмийн соёлын үнэт зүйлс тодорхой хувь хүнд бүрэлдэн төлөвшсөн байдал гэсэн ерөнхий утгаар нь тодорхойлж болох боловч энэ байдал нь тодорхой нэг хувь хүнийг нөгөөтэй нь ёс зүйн хувьд нь зэрэгцүүлэн үнэлэх, нэгжлэн хэмжихэд хэцүүхэн үзүүлэлт юм. Хорших, хамтрах, нийгэмших үйл явцын турш хүмүүн хоорондын харилцааны үед хүний мөс чанар танигдах тухай ойлголт нь нэг ёсондоо “нийгмийн” ёс зүйн асуудлыг хөндөж байгаа хэрэг ээ. Ёс зүйн шалгуурын тухайд «Нөхрийн сайныг ханилан байж таньдаг» маягаар л үнэлэхээс өөрөөр тодорхойлж хэлэхэд хэцүү, үргэлж баяжин шинэчлэгдэж байдаг агуулгатай ухагдахуун. Өөрөөр хэлбэл, «Зовох цагт нөхрийн чанар танигдана» гэдэг шиг ёс зүйн хэмжүүрээр тэр бүр амархан үнэлчихээргүй, боловсролын арга замаар л дамжиж төлөвшдөг хүний мөн чанарын тухай ойлголт оо. Тэгээд ч энэ нь нөхцөл байдлын хүчин зүйлээс маш их хамааралтай, бас тэгээд тодорхой нэг бие хүний хувьд «тэрээр бусдадаа хамгийн сайн ёс суртахуунтай мэт харагдах гэж байна уу, эсвэл нийгмийн соёлын үнэт зүйлсийг боловсролоороо оюун ухаандаа шингээсэн дээд зэргийн ёс суртахуунтай хүн үү» гэдгийг шууд мэдэхэд амар хялбар биш. Тэр тусмаа бидний хувьд шинэ тулгар байгаа иргэний ардчилсан нийгмийн үнэт зүйлсийн тухай, мөн энэ нийгэм дэх удирдлагын ёс зүйн тухай асуудлыг хөндөж ярилцах нь нэлээд ярвигтай байж мэднэ. Тэгээд ч ёс зүй нь нийгмийн хөгжлийн төвшинтэй хамт хөгжиж боловсронгуй болж байдаг хүний мөн чанарын тухай ухагдахуун юм. Иргэн бүр чанартай боловсролтой, өөрөөр хэлбэл, бидний өнөөгийн ойлголтоор бол хүн бүр «жолоодогчоос жолооч хүртэл, маршалаас малчин хүртэл» бүгдээрээ дээд боловсролтой байх боломж нөхцөл бүрдсэн, чанартай боловсрол нь хүний мөн чанарыг аяндаа төлөвшүүлэхээр хөгжсөн тийм боловсролжсон, иргэний ардчилсан нийгэмд ёс зүйн асуудалд яаж хандах ёстой вэ?

Хэмжихэд хэцүү хэдий ч ёс зүй нь удирдагч хүний үйл ажиллагааны барилд, өөрөөр хэлбэл, хамт олныхоо зохион байгуулалтын бүтэц, арга, хэлбэр, зорилгыг тодорхойлох болон шийдвэр гаргах сэтгэлгээний хэв маяг, арга барил болон хүн хүч, нөөц хуваарилах байршуулах зарчим хандлага зэрэгт нь шууд нөлөөлж байдаг.

Энд ямар нэгэн тодорхой жишээ авч ярилцвал илүү ойлгомжтой гэж бодож байна. Монгол улсын иргэний харъяатын асуудлаар бид саналаа илэрхийлэх хэрэгтэй байна гэж бодъё л доо.

Энэ асуудлыг шийдэхдээ:

- Ураг төрлийн уламжлалаар нь;
- Нутаг дэвсгэрийн зарчмаар;
- Зөвшөөрлөөр

гэсэн 3 хувилбарын зөвхөн нэгийг сонгохоор шийдвэр гаргах болбол Та аль хувилбараар шийдэх вэ? Нэг хувилбарыг сонгосныхоо дараа шударга ёс, эрх чөлөө, ардчилал зэрэг ерөнхий зарчмыг үндэс болгосон үнэт зүйлсээ эргэн санаад шийдээ тунгаан бод, шийдвэр гаргахад хялбар байв уу? Мөн шийдээ зөв гэдэгт эргэлзэж байна уу, үгүй юү? Ингэж эргэцүүлэхдээ эрхэмлэдэг үнэт зүйлст маань зөрчил гарсан уу, шийдвэр гаргахад хялбар байв уу гэж эргэж бодох юм бол энэхүү шийдвэрт тань лавтайяа Таны эрхэмлэдэг үнэт зүйлс нөлөөлж байгааг Та амархан мэдэрч ойлгох болно.

Өөр жишээ татъя. Монгол улсад цагаачлалаар ирэх иргэдийн асуудлыг зохицуулах шийдвэр гаргах хэрэгтэй байна гээ. Монголчууд бид ядарсан зүдэрсэн хүнд туслах, өрөвдөх сайхан заншилтай. Бидэнд ах дүүгийн ёс, хүнлэг энэрэнгүй үзэл, хүний тэгш эрх хэмээх манай нийгмийн үнэт зүйлс байдгийн дотор бас ядарсанаа өмөөрөх, зочломтгой зан заншлаараа монголчууд бид бүгдээрээ бахархдаг билээ. Түүнээс гадна монголын иргэд амар тайван, чинээлэг сайхан амьдрах, ажил эрхлэлтийн өндөр төвшин, аюулгүй нөхцөл байдал зэрэг соёлын үнэт зүйлсийг бид бас эрхэмлэдэг. Тэгээд энэ асуудлыг шийдсэн хувилбараа эргээд боддоо. Удирдагч хүнд шийдвэр гаргах бүрд үнэт зүйлс хоорондоо зөрчидөхөөр нөхцөл байдал тааралдана.

Байгууллагаа хамгийн үр ашигтай үйл ажиллагаатай болгоё гэсэн ерөнхий зорилго хэрэгжүүлэх шаардлагатай байна гээ. Нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж, шинэ үнэт зүйлс эрхэмлэх болсон үед байгууллагын тогтолцооны хийгээд бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай болох нь мэдээж. Шинэ тогтолцоонд хуучин арга үр дүнгүй. Энэ өөрчлөлтөөр бас байгууллагын орон тооны цомхотгол зайлшгүй болж магадгүй. Тэгвэл ийм нөхцөлд хэний ч эрх ашиг хохирохгүй, байгууллагын эрх ашиг хохирохгүй, үндэсний эрх ашигт нийцсэн, тийм нэг нь ч хохирохгүй байхаар оновчтой шийдэл хай. Сайн бодож боловсруулбал олдоно.

Яг энэ агшинд удирдагч Танд шинжлэх ухаанч ёс зүй, хүмүүнлэг ёс суртахуун шаардлагатайг мэдрэх болно. Ямар ч болсон «Хүмүүн» бол түүний ямар итгэл үнэмшил, шашин шүтлэгтэй, ямар үндэстэн ястан, эсвэл ядуу баян эсэхээс үл шалтгаалан, ямар хүйс, нас сүүдэр, үзэл бодолтойгоос үл хамааран дээдийн дээд «үнэт зүйл» хэмээн түүнд хүмүүнлэг ёс суртахуунаар хандах нь дэлхийн нийтэд түгээмэл ёс зүй болсон, мөн энэ үнэт зүйл нь мөн чанараараа та бидэнд боловсролоор дамжин шингэсэн учраас нийгмийн тогтолцооны эрс өөрчлөлтийн улмаас хэн ч хохирох ёсгүй гэдгийг зөнгөөрөө мэдрэх нь

ойлгомжтой асуудал. Тэгвэл энэ хүн, түүний удам угсаа ирээдүйд мөн сайхан таатай хөгжлийн орчинд амьдрах ёстой гэдэгтэй ч хүн бүр санал нийлнэ, энэ талаар огтхон ч маргахгүй ээ. Гэтэл түргэн хурдацтай хөгжил нь Монгол улсын үндэсний дээд эрх ашиг. Эндээс удирдагч хүмүүст тухайн нийгмийнхээ хөгжиж буй соёлын үнэт зүйлсээр баримжаалан шийдвэр гаргахдаа нухацтай бодож боловсруулах шаардлага гарна. Ийм л нөхцөл байдал та бидэнд тулгарлаа гэж төсөөлье. Чухамхүү энэ агшинд та бид өнөөдрийн хүмүүсийн ирээдүйн хөгжилд баримжаалсан шинжлэх ухаанч ёс зүйн мөн чанарын тухай эргэцүүлэн бодвоос байгууллагын удирдагч хүнд аливаа шийдвэр гаргахад нийгмийн соёлын үнэт зүйлс ямар их нөлөөтэй болох, удирдлагын ёс зүй ямар чухал ач холбогдолтойг ойлгож эхэлнэ гэж бодож байна.

Дээрх зүйлсийг өгүүлэх явцад шинжлэх ухаанч ёс зүй, хүмүүнлэг ёс суртахуун, соёлын үнэт зүйлс, боловсролжсон нийгэм, иргэний мөн чанар, зөнгөөрөө мэдрэх гэх мэт бид тэр болгон түгээмэл хэрэглэдэггүй нэр томъёо энд гарсаныг Та анзаарсан байх. Тэгвэл, удирдлагын ёс зүйн асуудлыг хөндөхийн өмнө ёс зүйтэй холбоотой зарим нэр томъёо, тэдгээрийн уялдаа холбооны талаар хамтдаа эрэгцүүлэн бодоцгооё.

Хүмүүнлэг ёс суртахуун, ёс зүй хувь хүнд соёлоор, боловсролоор дамжин төлөвшсөөр иргэний мөн чанар болон хувирах учиртай. Тэгвэл соёл гэж юу вэ гэсэн ухагдахууныг эргэн санаж, орчин үеийн нийгмийн хөгжлийн явцад баяжсан агуулгаар нь ойлгохыг хичээцгээе.

Орчин цагийн зарим нэр томъёоны тайлбар тольд бичихдээ:

Соёл<sup>1</sup> –

1. Хүн төрөлхтний үйлдвэр, нийгэмлэг, оюун ухааны талаар гаргасан ололтын цогц.

Соёл<sup>2</sup> –

1. Түүхэн тодорхой үед бүлэг хүмүүс (ард түмэн) – ийн хувьд амьдралын арга ухааныг нь тодорхойлж, бүрэлдүүлж байдаг ёс заншил, итгэл үнэмшил болон урлаг, нийгэм-эдийн засгийн ухаан;
2. Чанартай сайн боловсролын үр дүн болж буй урлаг уран сайхны мэдрэмж ойлгоц, тодорхой мэдлэг, мөн сайхан таашаал болон зан үйлийн цогц;
3. Ямар нэгэн зүйлийг сайжруулах, боловсронгуй болгон хөгжүүлэх явдал.

Соёл<sup>3</sup> –

1. Урлаг, утга зохиол, зан үйл, эрдэм мэдлэг гэх мэт зүйлст дээд зэргийн чанартай танин мэдэх, танилцах арга замаар тухайн хувь хүн, эсвэл нийгэмд төлөвшин бий болох мөн чанар;
2. Тухайн үндэстэн ард түмэн буюу түүхэн үеийн соёл иргэншлийн хэлбэр, эсвэл үе шат;
3. Нийгмийн тухайд нэг хэсэг хүмүүсийн аж амьдралын хэвшмэл чанарын нийлбэр бөгөөд түүний үе залгамжлан уламжлуулсан төлөв байдал.

Соёл<sup>4</sup> –

1. Хүмүүс хоорондоо болон өөрөө өөртэйгөө, мөн байгальтай харьцах харилцаанд нь, оюун санааны үнэт зүйлст нь, нийгмийн хэм хэмжээний болон байгууламжуудын тогтолцоонд нь, эд өлгийн хийгээд оюун санааны хөдөлмөрийн бүтээлд нь илрэн илэрхийлэгдэж байгаа, хүний амьдралын үйл ажиллагааны хөгжлийн, бас зохион байгуулалтын арга зам

гэх мэт өргөн утгаар нь тодорхойлсон байдаг. Соёлын тухай ухагдахууныг ойлгоход тухайн бүтээлийн зохиогч болгоны итгэл үнэмшил талаас харах нь сонирхолтой байх болов уу гэж энд ийнхүү олон номноос ишлэл авч хэд хэдэн тодорхойлолтыг сонголоо. Эдгээр тодорхойлолтыг тус бүрээр нь дахин дахин эргэцүүлж, сайн “ухаж” ойлговол нийгмийн “соёл” ба түүний “үнэт зүйлс” хоорондын шүтэлцээг анзаарах болно.

Энэхүү харилцан хамаарал, шүтэлцээг шууд тодорхойлон илэрхийлэхэд хүндрэлтэй боловч “Усыг нь уувал ёсыг нь дагана” гэдэг маань тэр шүтэлцээг л илэрхийлж байгаа сургаал ч гэвэл гэмээр, егөөдөл ч гэвэл гэмээр энгийн хэрнээ гүнзгий агуулгыг илэрхийлж байна.

Одоо соёл, түүний үнэт зүйлс хоорондох ийм нарийн шүтэлцээ, хамаарлын тухай нэгэн жишээгээр тодруулан тайлбарлахыг оролдоцгооё. Аливаа улс үндэстний үе үеийнхний уламжлалт соёлын хөгжлийн бодит үр дүн болох урлагийн бүтээлээр жишээ авъя. Бурханы хөрөг. Ази, Европийн улс түмний урлагийн энэхүү гайхамшигт сайхан бүтээлийг хооронд нь харьцуулахад аль аль нь бишрэх сэтгэгдэл төрүүлэх боловч цаад агуулгаараа ариун шүтээн гэсэн ерөнхий нэг санааг илтгэх мөртлөө гадаад илэрхийллээрээ хоорондоо яагаад эрс өөр байна вэ гэсэн сэтгэгдэл та бидэнд өөрийн эрхгүй төрнө.




1 дүгээр зураг. Цагийн хүрдийн Дүйнхэр болон хүмүүст аз жаргал авчрагч Ангел бурхад.

Ийм сэтгэгдэл төрж болохыг 1 дүгээр зурагт Дүйнхэр<sup>5</sup> болон Ангел<sup>6</sup> бурхдын дүрслэлээр үзүүлэв. Урлагийн бүтээл бол соёлын нэгэн төрөл зүйлд хамаарах биежсэн тодорхой нэг хэсэг нь. Тэгвэл агуулгаараа ижил санааг илэрхийлсэн соёлын тодорхой төрөл – бүтээлийн гадаад дүр төрх өөр байгаагийн учир нь юу гэвэл үнэт зүйлсээ эрхэмлэх эрэмбэнд байна гэж хэлмээр байна. Өөрөөр хэлбэл, Азийн үндэстнүүд, тэр дотор монголчууд, эд өлгийн чанар чансаанд ач холбогдол өгөхөөсөө илүү оюун ухааны хүчин чадалд бишрэх үнэт зүйлсийг эрхэмлэдэг (“Эдээр биеэ чимэхээр, Эрдмээр оюунаа чим” гэдэг) учраас бүтээсэн бурханы хөрөг нь илүү хээ гуа, цэцэгсээр дүүрэн, хийсвэрлэл нь гайхагдахаар, шүтэгдэхээр, айдас төрөн сөгдөхөөр, магадгүй, Европийн орны хүүхдүүд манай бурханы дүрийг үзээд айж мэдэхээр тийм зураглал бууна. Мөн Азийн улс орнуудын төрийн тогтолцоо нь босоо шатлалын дагуу зэрэг зиндааны хатуу жаягтай, төрөө дээдлэх үнэт зүйлсийн үнэмлэмж давамгайлж байдаг, бөхчүүдийн адил цолоор, насаар эрэмбэлэх дэг журам – ёс заншлаа эрхэмлэх зэрэг өөр бусад олон үнэт зүйлсийн цогц нь бурханы хөргийг яг иймээр, өөрөөр биш, чухамхүү тийм хийсвэрлэлд шүтэхээр болгожээ гэх сэтгэгдэл танд төрж байгаа болов уу. Тэгвэл нийгмийн соёл, түүний үнэт зүйлсийн хоорондох шүтэлцээ ийм нарийн нийлмэл байх ажээ.

Эндээс үнэт зүйлс буюу дээдлэн эрхэмлэх үнэлэмж нь аливаа ард түмний соёлын суурь үндэс нь болдог байна гэх үндэслэл гарч байна.

СОЁЛ хэмээх ухагдахууныг 2 дугаар зурагт үзүүлснээр далай доторх мөсөн уултай зүйрлэж, соёлын тухай ухагдахууныг ойлгох хялбаршуулсан тулгуур дохио болгож дэлхий нийтээр ярилцдаг жишээг энд ишлэл болгож байна.



(Хувь зураг)

алт тэрэгний, эсвэл нисэх болон усан онгоцны буудал дээр анх ирээд ажихдаа хүмүүс зөвхөн барилга байгууламжийн гадаад хийц, үзэмж, ард иргэдийн харилцаа, зан үйл, үйлчилгээний ёс жаяг болон ерөнхий байдал, өмссөн хувцасны хийц маяг зэрэг тухайн ард түмний зөвхөн нүүр царай болох соёлын 10%-ийг л олж үзэж болно. Үлдсэн

90%-ийг нэлээд гүн гүнзгий ул үндэстэй ажиглалт, зарим үед судалгаагаар илрүүлэх бөгөөд үүнийг “соёлын үнэт зүйлс” – “values” – “ценность” – гэж шинжлэх ухааны хэллэгээр хэрэглэж даджээ.

Ер нь хүн төрөлхтөн нийгэмших хөгжлийн явцдаа нийтлэг үнэт зүйлс эрхэмлэдэг нь илэрхий байдаг хэдий ч улс үндэстэн бүрийн иргэд амьдрал ахуйдаа, ажил үйл бүтээхдээ, ялангуяа, тодорхой шийдвэр гаргах, үйлийн арга ухаан сонгох үедээ эдгээр үнэт зүйлсээ эрэмбэлдэг. Үүний жишээ болгож америкийн болон европийн нийгмийн соёлын үнэт зүйлсийг харьцуулсан 1 дүгээр хүснэгтийг энд үзүүлэв.

Амьдрал ахуйн хэвшил, сэтгэлгээний хэв маяг, тэр ч байтугай барилга байгууламжийн хийц, урлаг – утга зохиолын агуулгын илэрхийлэл, хүнтэй мэндлэх ёс жаяг зэрэг нийгмийн соёлын өнгө аяс, мөн чанарын суурь болсон зарим үнэт зүйлсийн харьцуулалт хийсэн судалгааны нэгэн дүн болох 1 дүгээр хүснэгтийг илүү анхааралтай ажвал энэ нь та бидэнд олон зүйл эргэцүүлэх боломж олгож байна.

1 дүгээр хүснэгт

“Соёлын” үнэт зүйлсийн харьцуулалт

(“values” – “ценность” – “соёлын үнэт зүйлс” –ийн зарим жишээ)


Америкийн нийгмийн соёлын үнэт зүйлс		Европийн нийгмийн соёлын үнэт зүйлс (Азийнх төсөөтэй)	
1	Time Цаг хугацаа	1	Humens Interaction Хүний харилцаа

2	Personal Control over Environment Орчиндоо хувь хүн хяналт тавих	2	Fate / destiny Хувь тавилан / Заяа төөрөг
3	Self-Help Өөртөө итгэж өөрийгөө хөгжүүлэх	3	Birthright Inheritance Эрх залгамжлах, өв залгамжлах
4	Change Өөрчлөлт	4	Tradition / Stability Уламжлал / Тогтворт чанар
5	Future Orientation Ирээдүйд баримжаалсан	5	Past Orientation Өнгөрсөнд баримжаалсан
6	Individualism Хувь хүний хөгжлийг чухалчлах	6	Group Welfare Бүлгийн чинээлэг аж байдлыг чухалчлах
7	Competition Өрсөлдөөн	7	Cooperation Хорших хамтын ажиллагаа
8	Equality Тэгш ёс	8	Hierarchy Нас, алба эрэмбэлэх
9	Informality Албархаг бус зан байдал	9	Formality Албархах зан байдал
10	Practicality Амьдралд тулгуурлахыг урьдал болгох	10	Idealism Үзэл санаанд тулгуурлахыг урьдал болгох
11	Action / Work Үйлдэл / Ажилд баримжаалах	11	"Being" Orientation Хэн болоход нь баримжаалах
12	Materialism Материаллаг байдалд чухал байр суурь өгөх, түүнийг чухалчлах	12	Spiritualism Оюун ухаанлаг байдлыг чухалчлах, эрхэмлэх

Жишээлбэл, хүн төрөлхтөн цаг хугацаа, хүний харилцааг үнэт зүйлсээр эрхэмлэдэг хэдий ч асуудал шийдэх, арга зам сонгох үедээ америкийн нийгэмд цаг хугацааг хүний харилцааны удаад буюу харилцаанаас илүү эрхэмд цаг хугацааг үзэж байхад европид эсрэгээр шийдэж байгаа нь эдгээр нийгмийн соёлын төсөөтэй болон ялгаатай шинж чанарыг илтгэж байх жишээтэй юм.

Гудамжинд олон жил уулзалдаагүй, нэг ангийн хоёр найз гэнэт тааралдаад мэнд усаа мэдэж, сайхан тааламжтай яриа ид өрнөх үед нөгөө найз маань цагаа харснаа баяртай гэхээс өөр нэг их ярилгүй яваад өгвөл Танд ямар сэтгэгдэл төрөх вэ?

Америкийн нийгэмд энэ нь болзсон, тохирсон цагтаа яарлаа, аргагүй дээ, цаг байсан бол ч гээд өөрөө төлөвлөсөн болзсон цагтаа бас л яарсаар явна. Тэгвэл европийн нийгмийн соёлоор ёс зүй нь төлөвшсөн хүнд энэ бол ойлгомжгүй, магадгүй гайхашрал төрүүлж болох. Энэ хүснэгтээс үзэхэд Европи үндэстэн хүн салахдаа яарч байгаа тухайгаа заавал тайлбар хэлээд, дараа уулзах хаяг усаа (нэрийн хуудсаа) солилцоод явбал ийм зан үйл илүү ойлгомжтой, илүү тааламжтай байх нь мэдээж байна. Тэгэхдээ аль ч нийгэмд иргэншсэн, боловсролжсон хүмүүст цаг хугацаа, хүний харилцаа аль аль нь маш чухал үнэт зүйлс. Хүн алхам тутамдаа зорилгоо тодорхойлж, үйлдлийн шийдэл гаргаж байдгийг төвөггүй анзаарч болно. Энэ үед соёлын үнэт зүйлсийг эрэмбэлэхэд нь ёс зүй, ёс суртахуун маш чухал байдгийг тэр бүр анзаардаггүй байж болох юм. Энэ нь эргээд үйлдлийн үр дүнд бас нөлөөлдөг байна.



(Зураг гэр бүл)

Хувь хүнд шингэсэн, тухайн тэр хүний зөвхөн түүнд л илрэхүйц өвөрмөц мөн чанар болсон, тэр хүний хувьд «соёлын үнэт зүйлс» нь бол нийгэм-сэтгэл зүйн давтагдашгүй дотоод ертөнц юм.

Хүн гүн гүнзгий итгэл үнэмшил болсон үнэт зүйлс, хандлагын баримжааллаа бүр багадаа эцэг, эх ойрын

хүрээллийн орчноосоо олж авч төлөвшүүлсэн байдаг боловч боловсролжихын хэрээр бас өөрчлөгдөн “чанаржина”. Үүнийг менежментийн шинжлэх ухаанд 3 дугаар зураг<sup>7</sup> дүрсэлснээр тулгуур дохио болгож харуулсан байдаг шүү дээ.

Тухайн нийгмийн соёлын үнэт зүйлс нь тодорхой хувь хүний зан үйлд төлөвшин тогтох хэр хэмжээ өөр өөр байдаг тэр зүй тогтлын дагуу хүн бүрийн дотоод ертөнцийн давтагдашгүй чанар тодорхойлогддог. (Тэгээд ч эрхэмлэх үнэт зүйлс нь хувь хүний ажил үйлс гүйцэтгэх арга барил, сэтгэлгээний хэв шинж, шийдвэр гаргах үндэслэл, баримтлах ёс зүйн агуулгыг илэрхийлж байдаг). Амьд амьтан бүрд үр төлөө үлдээх, тэжээх, өсгөх гэсэн ёс зүйн анхдагч бүрдэл

хэсэг нь байгаагаар кодлогдсон байдаг бөгөөд энэ нь өнөөдрийн амьд явах, оршин тогтнох гэсэн ашиг сонирхлоос илүү үнэ цэнэтэй зүйлс байдгийг бид мэднэ. Нийгэмших явцад энэ нь “Бусдын хэрэг бүтвэл өөрийн хэрэг бүтнэ” гэсэн санаагаар илэрч байна. Харин нийгэмшин хамтарч амьдрах нь маргаашийн, ирээдүйн хувийн ашиг сонирхол учраас нэлээд боловсролжсон сэтгэлгээ бүхий хүнд л шингэсэн байх зөн бөгөөд ёс зүйн “хил” зөрчигдөх нөхцөлд энэ зөн нь өнөөдрийн хувийн ашиг сонирхол, ирээдүйн хувийн ашиг сонирхлоо аль алийг нь хохироохгүйгээр шийдэх чадвар болдог байна.

Энд өгүүлж байгаа зүйлийн агуулгаас болон 3 дугаар зургаас үзэхэд хувь хүний ёс зүйн төлөвшилд анхдагч нөлөөлөл үзүүлэгч хүчин зүйл бол гэр бүл, орчин, тэгээд бусад хүрээллээс янз бүрийн ул мөр - хэв үлдээхүйцээр нөлөөлдөг нь ойлгомжтой байна. Эдгээр хүчин зүйл нөлөөлөхдөө тэр цаг үеийнхээ нийгмийн соёлын орчинд боловсролоор дамжин тухайн хувь хүний мөн чанарт шингэх учраас иргэн хүний дотоод ертөнц давтагдашгүй байхаас аргагүй. Тийм ч учраас монголчууд бид ардын зүйр цэцэн үгэндээ: «Хүний биеийг төрүүлэхээс сэтгэлийг төрүүлдэггүй» гэдэг билээ. Нийт хүн төрөлхтний хувьд ёс суртахууны сургаал, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн явцад хувь хүний дотоод мөн чанарын давтагдашгүйн тухай мөн л адил манай монгол ардын цэцэн үгийн утга санааг илэрхийлсэн сургаал үг үлдээсэн нь одоо ч утга санаагаа алдаагүй хэвээр байгааг тэмдэглэмээр. Жишээлбэл, манай эриний өмнөх 5 дугаар зуунд эртний Грекийн эрдэмтэн Протагор: «Хүн бол бүх юмсийн хэмжүүр . . . »<sup>8</sup> гэж ёс суртахууны хувьд зөвхөн сайн зүйл хийхийг уриалж байхад Горгий амьдралын утга учир, аз жаргал, сайн үйлийн мөн чанарыг илэрхийлэх ёс суртахууны тухайд<sup>6</sup>:

1. Юу ч оршин тогтнож байгаа биш;
2. Хэрэв ямар нэгэн зүйл оршин тогтнож байгаа бол, тэрээр танин мэдэгдэшгүй;
3. Хэрэв тэрээр танин мэдэгдэж байгаа бол тийм танин мэдэхүй нь илэрхийлэгдэшгүй

гэсэн сургаал үгсийн цаад утга санаа нь хүн бүр өөр өөрийн гэсэн төсөөлөлтэй, түүнийг нэгтгэн томъёолох боломжгүй, гагцхүү хүн өөрөө л сайн сайхан зүйл хийж байх хэрэгтэй гэж уриалж байгааг ойлгохоор байна. Энэ нь дээр ишлэл хийсэн монгол ардын цэцэн үгийн утгатай агаар нэгийг шууд анзаарч болно.

Өөрөөр хэлбэл, ёс суртахууны хувьд хүн мөн чанараараа давтагдашгүй, тэрээр тухайн нийгмийнхээ соёлын орчинд боловсролын аргаар мэдлэг, дадлага, хандлагаа байнга тасралтгүй өөрчилдөг бөгөөд энэ өөрчлөлт нь чанарын хувьд хүн хүнийх харилцан адилгүй байх зүй тогтолтойн улмаас

нийгмийн соёлын үнэт зүйлсийг шингээж төлөвшиж буй ёс суртахууны “зөн билгийн боловсролжих” хэмжээ бас харилцан адилгүй байна гэх үндэс бий. Тэгвэл хүн өөрийгөө танин мэдэх, иргэнших, нийгэмших явцдаа байгалиас удамшсан ёс суртахууны зөн билгийнхээ боловсролжихийн хэрээр шинжлэх ухаанч ёс зүйтэйгээр хүрээлэн байгаа орчинтойгоо харьцдаг юм байна гэсэн бодол төрөх болно.

Энэ “боловсролжсон зөн” гэж юу вэ? Хувь хүмүүст өнөөдрийн хувийн ашиг сонирхол, ирээдүйн хувийн ашиг сонирхол гэж байдаг гэж үзье. Ирээдүйн хувийн эрх ашгийг бид нийгмийн хэрэгцээ, нийгмийн эрх ашиг гэж нэрлэж дадсан. Одоо яг аминд тулсан нөхцөл байдалд яах хэрэгтэйг гол төлөв байгалиас кодлосон удамшлын төрмөл зөнгөөрөө амьд амьтан, түүний дотор хүн мэдэрч эгшин зуурын шийдлээр үйлдэл хийнэ. Ирээдүйн хувийн эрх ашгийн үүднээс юу хэрэгтэй, яах ёстойг хүмүүс нийгмийн соёлоор төлөвшиж байдаг боловсролжсон зөнгөөрөө мэдрээд, улмаар ирээдүйд хандсан тодорхой зорилго бүхий асуудал шийдвэрлэх үедээ эргэцүүлэн бодож боловсруулаад сонголт хийж гүйцэтгэдэг гэвэл та ямар нэг хэмжээгээр санал нийлэх болов уу. Өнөөдрийн хувийн сонирхол бол ямар ч болсон одоодоо амьд байх хэрэгтэй. Гэтэл хүний амьдрал зөвхөн өөрийнх нь амьд явах хугацаагаар хэмжигдэх бус, ер нь хүний амьдрал бол үр удам дамжсан нийгмийн үзэгдэл гэдгийг хялбархан ухаарна. Тэгвэл “Би” амьд байж, нийгмийн амьдрал үргэлжлэхийн тулд бас “Чи” амьд байх хэрэгтэй. Ингээд л амьтны хувьд сүрэлгэх, хүний хувьд нийгэмших үзэгдэл эрэмбэ эрэмбээр чанаржиж, үе дамжин хөгжих болно. Эндээс нийт хүн төрөлхтний соёлын үнэт зүйлсийн тухай ойлголт бүрэлдэх болно. Эндээс “миний эрх чөлөө”, “бусдын эрх чөлөө”, “тэгш ёс”, “шударга ёс”, “эв нэгдэл” гэх зэрэг үнэт зүйлсийг хүмүүс эрхэмлэх жишээтэй. Тэгээд цааш нь жаахан гүнзгий бодвол эдгээр ухагдахуун нь зөвхөн нэг төрөл омгийн хүрээнд төдийгүй, нэг улс үндэстний хүрээнд, бүр лавшруулан бодвол дэлхий даяар нийтдээ хамт эрхэмлэн эрмэлзэх үнэт зүйлс болохоос аргагүй, үүнийг хүлээн зөвшөөрөхөөс ч өөр аргагүй болох юм.

Нийгэмшин амьдрах, хамтран ажиллах үйл ажиллагааны үр дүнгийн чанар чансаа нь, өөрөөр хэлбэл, улс орны хөгжлийн хурдац нь нийтлэгээр дагах ахуйн хэвшил, үйлийн арга барилын хөгжлийг ерөнхийд нь тодорхойлогч улс төрийн тогтолцооноос дам хийгээд шууд хамааралтайг бид ухаарах болно. Эндээс “ардчилал”, “хуульт ёс”, “эрх зүйт төр”, “олон ургальч үзэл”, “хүний жам ёсны эрх”, “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, “бусдын итгэл үнэмшлийг хүндэтгэх ёс”, “хүлээцтэй чанар”, “хүмүүнлэг нийгэм”, “иргэний нийгэм”, “ардчилсан нийгэм”, “боловсролжсон нийгэм” гэх мэт үнэт зүйлсийг эрхэмлэн хэрэгжүүлэх шаардлага урган гарах жишээтэй.

Нийгмийн соёлын, тухайлбал, дээр нэрлэсэн үнэт зүйлсийн агуулгын

үүднээс «Хүний эрхэм чанар тийм л байх ёстой» гэсэн ухаарлын төвшинд л «боловсролжсон зөн» илэрнэ. Тэгэхлээр байгалиас кодлосон төрмөл зөн, соёлоор төлөвшиж байдаг ухаарлын боловсролжсон зөн хамтдаа хувь хүний ёс зүйн дотоод чанарыг тодорхойлох бөгөөд энэ ёс зүй нь одоогийн болон ирээдүйн хувийн эрх ашгийнхаа өмнө хүлээх хариуцлага болж, гаргах шийдвэрийн сонголтыг тодорхойлно.

Гэхдээ «төрмөл зөн» ерөөсөө муу, «боловсролжсон зөн» заавал сайн гэж зөвхөн «цагаан», «хар»-ын дэнсээр, эсвэл ганцхан өөрийнхөө итгэл, үнэмшлийн хэмжүүрээр “зөв”, “буруу” гэж асуудалд өрөөсгөл хандаж болохгүй нь ойлгомжтой. Аль зөн нь асуудал шийдэх үед илүү нөлөөлөх вэ гэдэг бол ёс зүй илрэх агшины үе дэх орчин байдлаас ихээхэн хамааралтай.

Ирээдүйн төлөө тэрхүү ёс зүй буюу хариуцлагын шийдвэрээ тухайн агшинд хэрэгжүүлэх эсэх нь олон л хүчин зүйлээс шалтгаалах нь мэдээж. Ямар ч болсон чанартай боловсрол зан үйлд нь хандлага, хүмүүжил болж шингэсэн хүний хувьд бусдад “муу” зүйл хийнэ гэсэн ойлголт сэтгэлд нь тэр бүр орж ирдэггүй юм болов уу гэсэн бодол бидэнд суут ухаалаг хүмүүсийн амьдралын түүх, намтрыг уншиж байх үед төрдөг шүү дээ. Хүн ерөөс нийгмийн соёлын үнэт зүйлс шингэсэн тийм сайхан эрхэм чанартай байх учраас бусад хүмүүс яаж “муу” үйл хийчихнэ гэж бодох вэ, ёстой тэгэж бодох нь ч “нүгэл” болно. Боловсрол, авьяас чадвараар бусдаас дутмаг, гэхдээ боловсролтой, ухаантай, чадалтай хүмүүсээс шударга бус ч хамаагүй аргаар дээр байх, сайхан байхыг эрхэмлэгч хүмүүст л төрмөл зөн нь давамгайлах үед “хорон санаа” төрөхөөс биш, чанартай боловсролоор нийгмийн соёлын үнэт зүйлсийг мөн чанартаа шингээсэн, иргэншин төлөвшсөн, шударга зарчимч ёс зүй бүхий хүмүүст бол төрөхгүй, тэдэнд зөвхөн “сайн санаа” л төрдөг байх гэж бодогдохоор түүхийн олон баримтыг та бид мэддэг. Тэгэхлээр өндөр ёс суртахуунтай суут хүмүүсийн хүний мөстэй сайхан чанарыг ойлгох тусам бахархмаар байдаг.

Энд дэлхийн бүхий л үеийн суут уран бүтээлчид, зураач, хөгжмийн зохиолч, эрдэмтэн судлаач («энд санаанд орсон цөөхөн хүмүүсээс нэрлэж ойрын жишээ болгоход Н.Паганини, А.Эйнштейн, Н.Коперник, Дж.Бруно, Дж.Верди, Микеланджело Боунарроти гэх мэтчилэн дэлхийн бүхий л нэрт сод авьяастай хүмүүсийн амьдрал») олон суут хүмүүсийн намтар түүхээс, тэдний бүтээл, утга зохиолоос эргэн санахад, дахин уншихад улам илэрхий болно. Ялангуяа, бидний үеийн хүмүүсийн хувьд 1920 – 1940-өөд оны үед Орост, мөн Монголд ажиллаж байсан нийгэм, төрийн зүтгэлтнүүдийн амьдрал, тэднийг хилс хэрэгт шүүн байцааж байсан баримт бичигтэй танилцсан, уншсан бол гайхшралын хамт ухаарлын ийм бодол өөрийн эрхгүй төрнө.

Ихэнхдээ хүмүүсийн хандлагад ёс зүйн төлөвшил тогтохдоо итгэл, үнэмшилд суурилдаг нь ойлгомжтой. Ийм учраас хувь хүний ёс суртахууны төлөвшилд

аливаа шашин шүтлэг, сүсэг бишрэлийн нөлөө асар их ач холбогдолтой байсан, миний хувийн итгэл үнэмшлээр бол, чанартай боловсролжсон нийгэм дэлхий даяар төлөвштөл тэрээр асар их үүрэг гүйцэтгэнэ. Энэ үед, боловсролжсон нийгмийн нөхцөлд, шинжлэх ухаанч хандлага хувь хүний ёс зүйн төлөвшилд нөлөөлнө. Гэвч энэ бол ёс зүйн төлөвшлийн төвшин эхээс дөнгөж төрсөн хүүхэд, зуун настны хооронд ялгаагүй байх үе ирнэ гэж зөгнөж байгаа хэрэг огтхонч биш юм. Энэ бол аливаа асуудалд зөвхөн шинжлэх ухаанчаар хандахыг хичээх ёстой л гэсэн үүднээс илэрхийлсэн үзэл санаа болно.

Карл Попперын <sup>□</sup> {“Түүхчлэх үзлийн гуйланчлал”, “Нээлттэй нийгэм ба түүний дайснууд”, “Шинжлэх ухааны нээлтийн логик”, “Сонгодог физикийн болон Квант физикийн шалтгаалцлыг үгүйсгэх үзэл” (энэ өгүүллийн “Хорин жилийн тэртээ” нэмэлтийн “Шалтгаалцлыг үгүйсгэх үзэл” гэдэг бүлгийг үзнэ үү) зэрэг бүтээлээрээ алдаршсан} томъёолсноор аливаа онол, үзэл санаа, арга барил, сэтгэлгээ, хандлагын “шинжлэх ухаанч чанар”-тай байх шалгуур бол:

1. Тогтолцооны хувьд дотоод зөрчилгүй байх;
2. Амьдрал, практик, туршилтаар нотлогдож байх;
3. Эргэлзэж эргэцүүлэх боломжийг зөвшөөрсөн байх

зарчимд тулгуурласан байх явдал ажээ. Сэтгэлгээний ийм арга барилыг шинжлэх ухаанчаар хандах хандлага гэж нэрлэж байгаа бөгөөд ийм хандлагад суурилж төлөвшсөн ёс зүйг “шинжлэх ухаанч”, ийм хандлага давамгайлсан зөнг “боловсролжсон” гэж ойлгож энд ийм нэр томъёо хэрэглэлээ.

Аливаа нийгэм, нийгэмлэг, байгууллага, хамтлагт үлгэр жишээ болох, манлайлж чадах, чиг зүгийг оновчтой тодорхойлогч хүн болох “жолоодогчоо” сонгох, хүлээн зөвшөөрөхдөө “тэдний өнөөдрийн болон ирээдүйн эрх ашгийн төлөө хариуцлагатай шийдвэр гаргаж чадах” – тийм ёс зүйтэй удирдлагын арга барилыг шалгуур болгон хэн энэ шалгуурыг хангаж байгааг чухалчилдаг. Хувь хүн бүрийн, тухайлбал, удирдагч хүний гаргаж буй шийдвэр болгонд ёс зүйн зарчмын агуулга заавал шингэсэн байдаг. Удирдлагын шийдвэр нь хамт олны өнөөдрийн хийгээд ирээдүйн хамтын эрх ашгийн төлөө хариуцлага байдаг учир удирдагчийг сонгох, томилохдоо түүний ёс зүйг үндсэн шалгуур болгодог нь ойлгомжтой.

Ийм учраас сүүлийн үед төрийн захиргааны удирдлага, менежментийн онолд:

1. Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх бүрэн эрхийг хаана байлгах, хэнд шилжүүлэх вэ, энэ тохиолдолд менежментийн нарийн мэргэжлийн шалгуурыг аль эрэмбийн эрх ашгийн үүднээс ямар зорилгоор хэрэглэх вэ?

2. Хүний нөөц, технологийн арга хэрэгслийг байршуулахдаа зохион байгуулалт, үйл ажиллагаанд нь ямар горим тогтоож боловсронгуй болгох вэ? Ингэж боловсронгуй болгохдоо байгууллагын эрхэм зорилгыг амжилттай хэрэгжүүлэхээс өөр, “сайн” боллоо гэдгийг нь хэмжихчхээр ямар шалгуур байж болох вэ?

гэсэн асуудалд онцгой анхаарах болж байна. Энэ хоёр асуудлын шийдлийн аль аль нь соёлын үнэт зүйлстэй холбоотой, удирдлагын ёс зүйд хамаарах асуудал юм. Шийдвэр гаргах явцад үнэт зүйлсийн эрэмбэлэх үйлдэл нь сэтгэлгээ, арга барилд биежин, илрэлээ олох бөгөөд энэ нь эцэстээ сайн, муу, эсвэл зохимжтой, үл зохимжтой, өөрөөр хэлбэл, чухал, чухал бишийн тухай асуудалтай тулгарч байна гэсэн үг юм.

Төрийн захиргааны удирдлагад маш чухал цөм асуудал бол тухайн хүний соёлын үнэт зүйлээр илэрхийлэгддэг зорилго тодорхойлолт, хэрэгжүүлэлт болон үнэлгээ, хяналтын үйл ажиллагаа, бас аргын сонголт, аргаа боловсронгуй болгох сэтгэлгээ юм.

Нийгмийн соёлын шинэ үнэт зүйлс рүү, хүний мөсийн эрхэм чанар луу боловсролжсон зөнгөөрөө тэмүүлэхийн хамт төрмөл зөнгөөрөө хардах, сэрдэх үзэгдэл хамтдаа оршин тогтдогийн учир их гүн гүнзгий эх сурвалж бүхий шалтгаантай, бүхий л үед байнга хувьсан өөрчлөгдөх хүрээлэн буй орчноос шалтгаалах бөгөөд урьдчилан таамаглаж тодорхойлолт өгөх боломж багатай, судалгааны тусгай сэдэв бололтой.

Төрмөл зөн хэдийд давамгайлах тухай асуудал бас л хялбархан хэлчих, тодорхойлчих зүйл огтхон ч биш. Гол нь тухайн хүний төрж өссөн орчин, боловсролжсон байдал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалах биз ээ. Ийм ч учраас удирдлагын аливаа шийдвэрийн цаана, шийдвэр гаргаж байгаа арга барилын цаана хүний мөн чанар, хүний зан үйлийн тухай өөрийн гэсэн үзэл зайлшгүй байдаг тул “Үнэт зүйлс ба захиргааны удирдлага” сэдвээр ярилцахад менежментийн “Х” онол, “У” онолын тухай тэмдэглэдэг билээ.

Энэ 2 дугаар хүснэгтээр хүний мөн чанарын тухай хоёр өөр хандлага удирдлагын арга барил дээр хэрхэн илэрч байгааг үзүүлжээ.

Өөрөөр хэлбэл,

2 дугаар хүснэгт<sup>10</sup>


“Х” онолын үнэт зүйлс баримжааллын тогтолцоонд:	“У” онолын үнэт зүйлс баримжааллын тогтолцоонд:
--	--

<p>1. Хүн бол ажлаас аль болохоор зайлсхийхийг оролддог бөгөөд хүн бол ажилд дургүй гэсэн байр сууринаас ханддаг (ерөнхийдөө хүмүүст үл итгэсэн байр суурь).</p>	<p>1. Хүний сайн сайхан эрмэлзэл, сайн үйлсэд гүнзгий итгэсэн байр сууринаас хандаж нөхцөл нь бүрдвэл хүмүүс идэвхтэй ажиллах, хариуцлага хүлээх хүсэлтэй.</p>
<p>2. Ажлын чанарыг сайжруулахын тулд шууд болон шууд бусаар албадлага хэрэглэх, хянах, шийтгэх аргыг менежерийн бодлогод хэрэглэхийг зөвтгөнө.</p>	<p>2. Хүн эрх чөлөөтэй болсон нөхцөлд өөрөө өөрийгөө илэрхийлэх, бүтээлч үйл бүтээх гэсэн эрмэлзэлтэй бөгөөд түүнийгээ хэрэгжүүлж чадвал ур чадварын өндөр төвшинд хүрдэг.</p>
<p>3. Хүнийг байнга хянаж байх ёстой. Учир нь хүмүүс аливаа хариуцлагыг өөртөө хүлээхээс зайлсхийдэг.</p>	<p>3. Бие хүний хэрэгцээ шаардлага болон зо-рилго байгууллагынхтай зайлшгүй сөргөлдөх албагүй бөгөөд зохих нөхцөл бий болсон цагт хүн өөрөө өөрийнхөө өмнө тавьсан зорилтыг хэрэгжүүлэх замаар байгууллагын зорилтыг биелүүлэхэд хувь нэмэрээ оруулна.</p>

Ардчилсан нийгэм төлөвших явцад:

1. Хуульт ёс дээдлэх, хууль хүндэтгэх, ягштал биелүүлэх;
2. Үндсэн хуулиар тунхагласан соёлын үнэт зүйлсдээ иргэн бүр хүндэтгэн тэмүүлэх, төрийн бодлого нь ард түмэндээ нээлттэй, ард түмнээсээ эхтэй, ил тодын зарчмаар, тухайлбал, чөлөөт хэвлэлээр, тайлангаар хянагдаж байх, төрийн захиргаа иргэддээ хүнд сурталгүй чанартай үйлчилдэг байх, нийтийн (төрийн) захиргааны үйл ажиллагааны тухай үнэнийг нуухгүй байх, мэдээллийн үл хязгаарлалттай байх;
3. Эрх баригчдын хэрэгжүүлэх бодлогын зорилго хүндэтгэл хүлээхүйц байхаар тодорхойлогдсон байх, амласнаа ягштал биелүүлэх, тунхагласан бодлогоосоо нууцаар хазайж гуйвахыг үл тэвчих;
4. Зорилгодоо хүрэхдээ ёс зүйн зарчмуудыг зөрчсөн арга хэрэгслээс татгалзах, олон түмэн тааламжгүй хүлээж авах мэдээллийг нуух гэж оролдохгүй байх

зэрэг соёлын шинэ үнэт зүйлсийг өөртөө агуулдаг дээрх зарчмуудыг баримталсан удирдлагын шинэ ёс зүй төлөвшдөг байна.



Байгууллагын удирдлагын ажил үйл, бодлого хэрэгжүүлэх урлаг бол хүмүүсийн зан үйлдлийн ерөнхий хэв маягт нөлөөлдөг, үйл ажиллагааны үр дүнгийн чанар чансааг тодорхойлох хүчин зүйл болдог учраас орчин үеийн менежментийн онолд удирдлагын ёс зүйд улам их анхаарч байна. Ийм учраас ёс зүйн хэм хэмжээ бол байгууллагын ажилтан бүрийн хариуцлага

болж хэрэгжих бөгөөд тэдний боловсролын чанарт онцгой анхаарах, энэ чиглэлд дорвитой өөрчлөлт, шинэчлэл хийх үйл явц эрчимжиж байгаа юм байна. Ингэвэл нийгмийн өмнө хүлээх хариуцлага буюу ирээдүйн хувийн эрх ашгийнхаа өмнө хүлээх үүргийн хэрэгжилтэнд ахиц гарна гэж үздэг бөгөөд энэ нь ч тодорхой хэмжээнд практикаар нотлогдож байгааг өндөр хөгжилтэй хэмээх улс орны иргэдийн чинээлэг аж байдал, улс орны эдийн засгийн хөгжлийн хурдац харуулж байгаа аж.

Менежментийн буюу удирдлагын ёс зүй нь зөвхөн байгууллагын дотоод асуудал биш, бүх хүрээлэл, гадаад орчинтойгоо харилцах үйл ажиллагаанд нь ч бас хамааралтай. Үүнийг 4 дүгээр зураг<sup>5</sup> үзүүлээ. Ийм харилцан хамаарлын нөхцөлд нийгэмд үйлчилдэг, ашгийн төлөө бус байгууллага болон нийтийн захиргааны байгууллагад төдийгүй, ашгийн төлөө шууд ажилладаг бизнесийн байгууллагад ч ёс зүй, ёс суртахуун чухал гэсэн үг. Тэгэхлээр менежментийн ёс зүйг зөвхөн нэг байгууллага ганцаараа бүрдүүлдэггүй бөгөөд шинжлэх ухаанч ёс зүйн төлөвшилд нийгмийн бүтэц, хүрээллийн бүх бүрэлдэхүүн хэсгүүд оролцдог нарийн төвөгтэй үйл явц болох нь ойлгомжтой юм. Гэвч нэг байгууллагын нэг удирдагчийн ёс зүй байгууллага доторх бүхий л үйл ажиллагааны орчил, хүмүүс хоорондын харилцааны ёс зүйд маш чухал үүрэгтэйг “мартаж” хэрхэвч болохгүй. Мартаж болохгүй гэж уриалах нэг хэрэг, хэрэгжүүлэх өөр хэрэг гэдгийг ч бид ойлгоно. Гэхдээ л энэ нь ирээдүйн Та бидний хувийн эрх ашиг юм даа.

Нийгмийн (заримдаа сонирхлын бүлгүүдийн) хууль ёсны эрх ашгийг Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт ил тусгах, хэрэгжүүлэх боломж олгож байгаа, хариуцлагаа тайлагнаж иргэддээ үйлчилж байгаа тийм төрийн

захиргааны болон байгууллагын удирдлагын чухам энэ ил тодын хэлбэрийг ардчилсан нийгэм дэмждэг, чухам энэ нь ардчиллын нэгэн үнэт зүйл болон төлөвших учиртай юм байна.

Энэ үнэт зүйлийг хэрэгжүүлэх нэг арга бол сонирхлын бүлгүүдийн төлөөлөл бүхий зөвлөх хороо, эсвэл зөвлөл байгуулж ажиллуулах явдал гэж үздэг<sup>8</sup>. Ийм байгууллагыг хуулийн шийдвэр гаргаад ч зохион байгуулж, хэрэгжүүлж болно, зарим тохиолдолд ердөө л байгууллагын удирдлага л шийддэг байна.

(Нийгмийн хариуцлага зураг)

Ингэхлээр удирдлагын ёс зүй бол үндсэндээ түүнээс нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага гэж шууд ойлгох ёстой. Энэ асуудлыг шийдэх арга нь хүн төрөлхтний хөгжлийн бүхий л түүхийн явцад маш боловсронгуй болж амьдрал, практикаар шийдэгдэж байгаа хэдий ч улс орон бүрт өөр өөр төвшинд хөгжиж байна. Ардчиллын нэг чухал үнэт зүйлс бол удирдлагын ёс зүйд шууд болон шууд бусаар хяналт тавих иргэний эрх юм.

Гэсэн ч энэ нь амьдрал дээр хэрэгжүүлэхэд амар хялбар асуудал биш. Орчин үед аль ч улс оронд хуулиар зохицуулах механизм бүрдүүлж байгаа ч ардчилсан нийгэмд ихэнхдээ эрүүл сэтгэлгээ, эрүүл ухаанд, өөрөөр хэлбэл, боловсролжсон зөнд найдвар тавьдаг, иргэдийн боловсролын төвшин, чанараас гол төлөв хамаарч байдаг байна.

Удирдлагын ёс зүйн асуудал хөндөхөд анхаарал татдаг нэг зүйл бол байгууллагын дотоод дүрэм, нийгмийн соёлын үнэт зүйлст суурилсан хувь хүний ёс зүй хоорондоо зөрчилдөх тохиолдол байдаг. Ардчилсан нийгмийн соёлын нэг чухал үнэт зүйл бол “Ёс зүйн хувьд зөв зүйтэй зорилгод хүрэхийн тулд ёс зүйн хувьд эргэлзээтэй арга хэрэглэж хэрхэвч болохгүй” гэсэн зарчим юм. Энэ нь нийт хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлс: “Хүмүүнлэг ёс”, “Шударга ёс”, “Тэгш эрх”, “Эв нэгдэл” гэх мэт үнэт зүйлсийн агуулгаас урган гарах зарчим юм. Тэгэхлээр удирдагч хүн ёс зүйн хувьд бие даасан байх явдал маш чухал гэдгийг ёс зүйн онолын олон судлаач эрдэмтэд тэмдэглэн хэлсэн байдаг. Байгууллагын ариун зорилгыг хэрэгжүүлэхийн тулд удирдагч хүн ёс зүйн бохир аргаас татгалзах хэрэгтэй, шаардлагатай бол албан тушаалаас огцрох зоригтой байх тухай яриа юм. Эдвард Весбанд, Томас Франк<sup>9</sup> нар “Албан тушаалаасаа огцрох явдал эсэргүүцлийн хэлбэр мөн” номондоо: «Ёс зүйн хувьд бие даасан байна гэдэг бол байгууллагын дүрэм, горимыг зөрчиж байгаа нөхцөлд ч ёс зүйн үндсэн зарчмуудыг хамгаалахыг хэлнэ» гэжээ. Тэд цааш нь: «Өндөр албан тушаалын хүмүүс ийм зарчим баримталж чадсансан бол Америкийн түүхэнд Вьетнамын дайн, Уотергейтийн хэрэг зэрэг эмгэнэлт үйл явдлууд гарахгүй байсан билээ» гэж бичжээ. Энэ бол төрийн байгууллагууд албан ёсны бодлогод нийцэж буй үнэт зүйлсийг дэмждэг байх ёстой учраас хувь хүний, эсвэл удирдагч хүний ёс зүйн хувьд бие даасан байдал, байгууллагын

ёс зүйг баримталж байгаа байр суурь хоёр хоорондоо зөрчилд орж болохын жишээ юм. Төрийн бодлого нь ёс зүйн ерөнхий зарчимд аль болох нийцэх ёстой, тэгэх тусмаа Үндсэн хуулиар тунхагласан нийгмийн соёлын үнэт зүйлсээр тодорхойлогдож байгаа ёс зүйн хариуцлагыг зөрчсөн байж болохгүй, эдгээр үнэт зүйлийн агуулгыг зөвхөн өөрсдийн итгэл үнэмшилдээ тохируулах үүднээс гуйвуулж болохгүй гэдэг бол бас ойлгомжтой.

Төрийн бодлого төгс төгөлдөр байна гэвэл бодит байдалд нийцэхгүй ч өндөр ёс зүй баримталсан бодлого зайлшгүй үр ашигтай бодлого болдог байна<sup>8</sup>. Тэгвэл удирдагчийн ёс зүй нь нийгэмших үйл явцад бүхэлдээ асар их нөлөөтэй, ёс зүйгээрээ тэрээр хүний эрхэм дээд чанар шингээсэн үлгэр дууриаллын загвар байх шаардлага байгаа нь дээр өгүүлснээс шууд ойлгомжтой байна. Эндээс сургуулийн удирдлагын ёс зүй, багшийн ёс зүй нийгэмд үе үеийн залгамж халаандаа дээд загвар болж байдаг, монголчуудын зан үйлд «Эрдмээ дээдэлж багшаа хүндэлдэг» ёсон өнө эртнээс улбаатай, одоо бүр ч өргөн утгаар ойлгон эрхэмлэдэг сайхан заншил болсон байгааг ухаарахад хялбар байна. Багш нь суралцагчдад мэдлэг, дадлага, хандлагын зэрэг өөрчлөлт оруулах дэмжлэгийн эх сурвалжийнхаа хувьд түүний ёс зүй нь суралцагчдынхаа хандлагад (хүмүүжилд) хүний эрхэм чанарыг шингээж байдаг байх нь ээ. Үүнийг манай багш нар боловсролжсон зөнгөөрөө мэдэрч цаг ямагт үлгэр үзүүлж явдгийг бодохоор хүндэтгэх сэтгэл төрнө. «Сурсан болгон эрдэм» боловч «Шавийн эрдэм багшаас» байдгийг бид дандаа санаж, багштайгаа уулзах бүрдээ өөрийн эрхгүй тэргүүн мэхийн хүндэтгэдэг, сэтгэлийн ертөнцдөө багшаараа байнга бахархаж байдаг, бодож хайрлаж явдаг. Багш хүн нийгмийн ёс зүйн загвар учраас багшийн ёс зүй ийм байх ёстой гэж хэлэх бичихэд хэцүү. Гэвч орчин үед багш хүн сургалт, хичээлийн менежерийнхээ хувьд ёс зүйн шинэ үүрэг хариуцлага хүлээх болж байгаа юм.

Тэгвэл сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч, багш нарт, мөн удирдах зөвлөлийн гишүүдэд бол удирдагч хүний хувьд хэнд нь ч гэсэн ёс зүйн шаардлага, шалгуурыг нийгмийн зүгээс тавих хэрэгтэй болдог. Яагаад гэвэл олны дотроос тэднийг сонгох, шалгаруулах, томилох аргаар тодруулснаар тэд байгууллагын, сургалтын, мөн хичээлийн зорилго хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хамт олноо хөгжүүлэх, тэднийг манлайлах, хянах ерөнхий чиг үүргээрээ ёс зүйн давхар хариуцлага ирээдүйн өмнө хүлээнэ гэсэн үг.

Дээр өгүүлснээс үзэхэд удирдлагын хүмүүс ёс зүйн хувьд алдаа гаргах магадлал их байх тохиол нь шийдвэр томъёолох үе байдаг, өөрөөр хэлбэл, байгууллагын, ерөөс бүхий л үйл ажиллагааныхаа зорилго, зорилт тодорхойлох, тэгээд зорилго, зорилтоо биелүүлэхэд чиглэсэн стратегийн болон өдөр тутмын хэрэгжүүлэх арга, хэрэгсэл сонгох үйл явцдаа менежерийн ерөнхий

аль ч чиг үүргийнхээ дагуу шийдвэр гаргах үйлдэл юм байна. Тэгэхлээр аль болох рациональ (оновчтой) шийдвэр сонгохын тулд олон талын мэдээлэлд дүн шинжилгээ хийж шийдвэрийн олон хувилбар гаргаад тэдгээрээс сонгох хэрэгтэй болдог. Энд удирдагчийн мэдлэг, туршлага, ёс зүйн шалгуур хэмжүүр илэрч гарна.

Шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлс<sup>8</sup>:

- Гадны дарамт (сонгуулиар гарч ирсэн албан тушаалтан гадны дарамтыг үл тоох хандлагатай ч эрх баригч бүлэглэлээс дарамт үзүүлбэл бүх талаас нь бодож боловсруулсан шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэр гаргаж чадахгүйд хүрдэг);
- Үргүй зардал (амьдрал, практик дээр өртөг их бол хүмүүс төлөвлөсөн зорилтоосоо татгалздаг. Гэтэл хүнд сурталд хэвшсэн байгууллага яг эсрэгээр нь ажилладаг байна);
- Хувь хүний шинж чанар (ертөнцийг үзэх үзэл, олон жил ажилласан албан хаагчийн консерватив байр суурь гэх мэт);
- Байгууллагын гаднах сонирхлын бүлгүүдийн нөлөөлөл;
- Бусад хүчин зүйл (өмнө эзэмшсэн боловсрол, туршлага, хандлага гэх мэт).

Шийдвэр гаргахад тохиолддог нэлээд ерөнхий нийтлэг алдаа<sup>8</sup>:

- Танин мэдэхүйн хувьд харалган байх (Ойрын хэрэгцээ, шаардлагыг урьдал болгож хэтийн, холын зорилгоос зайлсхийдэг; Шийдвэрийн алсын үр дагаврыг тооцдоггүй; Асуудлын зөвхөн ганц талыг хараад, бусдыг орхигдуулах явдал зэрэг танин мэдэхүйн харалган байдал);
- Ирээдүй өнгөрснийг давтана гэж үзэх (Ирээдүйн нөхцөл байдлыг тооцдоггүй, түүхийн харьцангуй тогтвортой нөхцөлд аливаа үйлдэл болон үйл ажиллагаа өнгөрснийхтэй адил төсөөтэй байх хэдий ч нөхцөл байдлын өөрчлөлтийн үед, ялангуяа, хүмүүсийн үнэт зүйлсийн баримжаалал, нийгмийн хуучин харилцаа ихээхэн хувьсах, өөрчлөгдөх магадлалтай орчин үед одоогийнх ирээдүйнхтэй харьцуулахад тийм төсөөтэй байх албагүй гэдгийг мэдэхгүй явдал гэх зэрэг);
- Хэт хялбарчлах байдал (Асуудлын шалтгааныг авч үзэхээсээ илүү хэлбэр голлодог хандлагын улмаас хялбархнаар өнөөдөртөө болж байгаагаар шийдчих гэсэн арга барил, өөрөөр хэлбэл, олонхид тааламжтай, хүлээж авахад амар байлаа ч гэсэн төвөгтэй нөхцөл

байдалд хялбар шийдэл тохирдоггүй);

- Өөрийнхөө туршлагад хэт итгэх (Туршлагатай хүн тухайн асуудал дээрээ туршлагагүй хүнээс хавьгүй оновчтой шийдвэр гаргах магадлалтай хэдий ч түүний шийдвэр хамгийн зөв нь байх албагүй; Туршлага багатай ч гэсэн асуудал шийдвэрлэх тэс өөр арга зам тодорхойлж, тэр нь хамгийн шилдэг оносон байх явдал элбэг тохиолддог ажээ. Албан тушаалтан хамт ажиллагчидтайгаа зөвлөлдөж тэдний туршлагаас, мэдлэгээс суралцаж байж шийдвэр гаргах нь илүү сайн учраас орчин үед асуудал шинээр шийдвэрлэх, шинэ арга зам хайхдаа семинар, туршлага солилцох сургалтын хэлбэрийг их ашигладаг болж байна);
- Урьдчилан бодсон баримтлалаасаа салж чадахгүй байх, хэвшмэл ойлголттой байх (Шинэ үйл явдал, шинэ баримт, шинэ зүйлийн тухай ярьж байгаа боловч шийдвэрт хэвшмэл хуучин үзэл ойлголтоо тусгах явдал элбэг ажээ. Шийдвэрийг ийм маягаар гаргах нь зүйд нийцэхгүй, тэгэх тусмаа албан тушаалтан өөрийн шийдвэрээ зөвтгөх зорилгоор шинэ баримт мэдээг гуйвуулж болохгүй, өөрийн шийдвэрээ зөвхөн зөвтгөх үүднээс баримт нотолгоо гаргах хэрэггүй. Тэд зөвхөн тийм баримт хайх, олж харах дуртай байдаг. Бас олон нийтийн дунд байдаг хэвшмэл ойлголтыг ашиглан шийдвэрээ зөвтгөх дуртай. Мөн логик бүтэцтэй дүгнэлтүүдийг шохоорхож өөрсдийн байр сууриа зөвтгөхөд бас ашигладаг);
- Туршилт хийхэд бэлэн биш байх (Шинэ санал, арга хэмжээ зөв эсэхийн шалгуур бол хязгаарлагдмал хэмжээнд туршиж үзэх явдал юм. Ихэнхдээ, онолын зүйлийг бага багаар турших арга хандлагаа мэддэггүй. Иймээс шинэ зүйлийг сайтар бодож боловсруулаагүй гэж хардаж эсэргүүцэн буцаадаг. Нөгөөтэйгүүр, захиргааны ажилтан хүнд бол ерөнхийдөө шинэчлэл хийх сэтгэлгээ, зориг их дутмаг байдаг, туршилт бол мөрийтэй тоглоомтэй ижил гэж үзэх явдал элбэг тааралддаг. Гэтэл онгоц, пуужин туршихыг хүлээн зөвшөөрөөд хөрөнгө баталдаг жишээтэй. Харин нийгмийн хөтөлбөр турших нь ихээхэн ирээдүйн ач холбогдолтой боловч тийм хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс ихэнхдээ болгоомжилдог тал бий);
- Шийдвэр гаргах дургүй байх (Олон нийтийн шүүмжлэлээс, бас хариуцлагаас айгаад захиргааны удирдлага шинэ үзэл санаатай шийдвэр гаргахаас зайлсхийдэг. Тийм газарт олон жил ажилласан албан хаагчид хариуцлагаас айж, хөшүүн хойрог байдлаараа хүнд сурталд идэгдэж, хээл хахууль цэцэглэх хөрс бүрдүүлэх нь олонтаа. Тэд хариуцлагаас мултрах талаар мэргэшиж байгууллагын

элдэв албан тушаалтнаас зөвшөөрөл авах, дээрээс шийд харах, бусад руу түлхэх, хуулийн “цоорхой хайх” зэрэг арга барилаар цаг өнгөрөөж татвар төлөгчдийн мөнгийг үр ашиггүй зарцуулахад хүрдэг. Хариуцлагаас мултрах уур амьсгал давамгайлсан нөхцөлд албан хаагчид дээрээс шийдвэр гаргах ёстой гэж үзээд юу ч хийхгүй суух нь амар байдаг. Тэр ч байтугай өөрсдийн эрх мэдлийн хэмжээнд ч гэсэн шийдвэр гаргахаас зайлсхийх жишээтэй.)

- гэх мэт

Удирдлагын, менежерийн хариуцлагыг хөсөрдүүлэх явдал доорх нийтлэг хэлбэрээр илэрдэг жишээ татъя. Үүнд<sup>8</sup>:

1. Асуудалд шударга биш байр сууринаас хандах, хөрөнгө мөнгө идэж ашиглах, санхүүгийн баримт засварлах, сангийн хөрөнгөөс үрэн таран хийх, гэрээ байгуулагч, харилцагч нараас хууль бусаар мөнгө шаардах, шан харамж харах, зардлын тооцоо засах гэх мэт олон хэлбэр;
2. Асуудал шийдэх, шийдвэрлүүлэх үедээ хээл хахууль авахгүй боловч танил тал, найз нөхдийнхөө, намынхаа, эсвэл хувийн эрх ашгийн үүднээс хандах;
3. Дотоод мэдээллийг, эсвэл хуулийн зохицуулалтгүй хэсгийг шударга бусаар ашиглах;
4. Хууль үл тоомсорлох хандлага гаргах, хуулийн заалтыг хэрэгжүүлэх боломжгүй гэж хуурамч шалтаг тоочих, эсвэл биелүүлнэ гэж амлаад хэрэг дээрээ юу ч хийхгүй байх, мөн буруу үйлдлээ зөвтгөхийг хичээх;
5. Шийдвэр гаргах, эсвэл гаргуулахдаа нийтийн эрх ашгийг хувийнхаас, эсвэл сонирхлын бүлгийнхээс доогуур тавих;
6. Санал бодлоо шударга, ил, зоригтой гаргасан хүмүүстэй шударга бус харилцах, тэднийг ил далд үйлдлээр хавчих, ажлаас халах;
7. Ажилтан албан хаагчид, багш ажилчдынхаа эрх ашгийг хохироосон шийдвэр гаргах, гаргахад оролцох, гаргуулах;
8. Үр ашиггүй байдалтай эвлэрэнгүй байх, ур чадвар багатай хүмүүс хаана ч тохиолдох боловч тэд шударга байлаа ч гэсэн тэдэнд ажлын шаардлага тавихгүй хавтгайрах, мэдээгүй дүр үзүүлэн хамт ажиллах;
9. Алдаагаа нуун дарагдуулахыг хичээх, худлаа хэлэх, хамт олноосоо

уучлал гуйж алдаагаа засахыг оролдохгүй байх;

10. Хууль, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд санаачилга гаргахгүй, шүүмжлэлээс айгаад бүтээлч биш ажиллах;
11. Бусад орлогоо нууж татвараас зайлсхийх;
12. Иргэний нийгэмд ардчилсан төр иргэддээ үйлчлэх утга учиртайг үл ойшоож, дээд удирдлагын хүмүүс, албан тушаалтанд тал засан харьцах, доор албан үүрэгтэн, ажилчдаа, мөн үйлчлүүлэгч иргэддээ шударга бус дээрэлхүү хандах, тэгш ёсоо умартах

гэх зэрэг хэлбэр, тохиолдлоор илэрдэг ажээ.

Эцэст тэмдэглэхэд, удирдлагын хүмүүсийг шилж сонгох шалгуурт:

1. Шинэ мэдлэг байнга эзэмших арга ухаан;
2. Түргэн хувьсамтгай нөхцөлд хурдан дадлагаших арга барил, түүнийгээ тасралтгүй хөгжүүлэх арга зүй;
3. Ёс зүй (шинжлэх ухаанч бол бүр сайн)

зэрэг чиглэлийн үзүүлэлтийг харгалзах нь чухал юм.

Харин хэмжихэд хамгийн хэцүү бөгөөд хэрэглэх зайлшгүй шалгуур үзүүлэлт гэвэл ёс зүй болох нь мэдээж байна.

(Endnotes)

- 1 Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 912 х.
- 2 Beginning Dictionary Scribner, William D. Hasley, Editorial Director, Scribner Educational Publishers, New York, 1986,756р.
- 3 Webster's Encyclopedic Unabridged Dictionary of the English Language, Gramercy Books, New York / Avenel, New Jersey, 1989, 1854р.
- 4 Энциклопедический социологический словарь, ИСПИ РАН, Москва, 1995, с.343.
- 5 Н.Цүлтэм, Монгол зураг, Улаанбаатар,1986, 19 дүгээр зураг.
- 6 WWW//Buddha
- 7 Я.Шуурав, Менежмент, ТЗУХИ, Улаанбаатар, 1997, х.185.
- 8 И.Л.Зеленкова, Е.В.Беляева, Этника, Минск, ТетраСистемс, 2000, стр.14.
- 9 К.Р.Рорпер, The Poverty of Historicism, London, 1957 (Карл Поппер, Түүхчлэх үзлийн гуйланчлал, Улаанбаатар, 1996).
- 10 Орчин үеийн төрийн удирдлага, Монгол менежмент төв, Улаанбаатар, 1998, х.45.


Ч.Лхагважав /Улс төрийн Боловсролын Академийн зөвлөлийн гишүүн/



## МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ БҮТЦИЙН ГАЖУУДАЛ БА ХӨГЖИЛД ГАРСАН УХРАЛ

Х.Батсуурь-Эдийн засагч

Улс орнуудын хөгжлийн түвшинг янз бүрийн аргуудаар хэмждэг. Хэмжүүр, аргачлалууд нь цаг үе, нийгмийн хөгжлөө дагаад өөрчлөгдсөөр ирсэн. Аливаа улсын эдийн засгийн хөгжил гэдэг тухайн улсын хөгжлийн түвшинг бүхэлд нь тодорхойлох хамгийн гол үзүүлэлт болдог. Тэр ч байтугай эдийн засгийн бүтэц, эдийн засгийн үйлдвэрлэлийнх нь тогтолцоон дээр тулгуурлан улс орны хөгжлийг тодорхойлдог түгээмэл аргачлал ч бий. Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн ийм нэгэн аргачлал нь “Ростоу-ын Хөгжлийн Загварчлал” модель юм. Товчхондоо энэ Ростоу-ын хэмжүүр нь улс орон чухам юу үйлдвэрлэж байна вэ, эдийн засаг нь ямар бүтэцтэй байна вэ гэдэг дээр үндэслэн тухайн улсын хөгжлийн түвшинг тодорхойлдог. Мэдээж сүүлийн үед нэрд гараад байгаа, түгээмэл хэрэглэгдэх болсон хүний хөгжлийн индекс ээр (Human Development Index) хэмжих аргачлалтай харьцуулбал учир



дутагдалтай мэт. Гэвч Ростоу-ын модель нь зөвхөн хөгжлийн хэмжүүр төдий бус мөн хоцронгуй хөгжилтэй орнуудын магадгүй тодорхой хугацаанд туулж өнгөрөх шаардлагатай үе шатуудыг тодорхойлж өгч байдгаараа онцлогтой юм.


Тэгвэл Ростоу-ын аргачлалаар хэмжсэнээр Монгол улс маань хаана явна вэ? Ростоу-ын Хөгжлийн Загварчлал нь уламжлалт нийгэм, шилжилтийн

үе, хурдацтай хөгжил, тогтвортой хөгжил, чинээлэг хэрэглэгч гэсэн таван үе шатнаас бүрдэх бөгөөд эдгээр үе шатууд нь эдийн засаг нь чухам юу үйлдвэрлэдэг вэ гэдгээр тодорхойлогддог юм (Ростоу-хөгжлийн загварчлал графикийг үзнэ үү). Графикт зааснаар манай улс өнөөдөр 1-р шат буюу уламжлалт нийгэм мөн 2-р шат буюу дэд бүтэц, аж үйлдвэржилтийг хөгжүүлж эхэлж буй нийгэм гэх хоёр шатны хооронд байршилтай байгааг та бүхэн харж болно. Энэ нь үнэндээ манай улс Замби, Афганистан мэтийн улсаас арай дээгүүр, Вьетнам, Индонез, Азербайжан улсуудаас арай доогуур эрэмблэгдэж байна гэсэн үг. Яагаад бараг хамгийн доод шатанд гэж, бид арчилсан улс, зах зээлийн эдийн засагтай хөгжиж байгаа улс гэж асуух хүмүүс гарна. Хариулт нь тун энгийн. Ямар ч ардчилал, ямар ч зах зээлийн систем улс орны хөгжлийн түвшинг тодорхойлохгүй. Зүгээр л манай хөгжлийн түвшин, бидний юмыг үйлдвэрлэх, бүтээх чадвар л тэр юм. 1990 онд зах зээлийн системд шилжихээс өмнө манай улс ДНБ-ийхээ 37 хувийг аж үйлдвэрлэлээр бүтээдэг, аж үйлдвэржсэн орон байсан төдийгүй дэд бүтэцийн бүтээн байгуулалтандаа орсон байсан нь манай улс хөгжлөөрөө Ростоу-ын загварчлалын 2-р шат буюу Шилжилтийн үед байсныг. Харин яагаад бид өнөөдөр ухраад 1-р шат, 2-р шатны хооронд байна гэж гэсэн асуулт зүй ёсоороо гарч ирнэ. Үүний хариултыг та одоо энэ доод талын мөрнүүдээс мэдэж авна.

Манай улсад өнөөдөр аж үйлдвэрлэл бараг устаж зөвхөн уул уурхайн түүх эдийн олборлолтоос хараат эдийн засагтай байгаа нь хөгжлийн түвшин хаа байгааг, хаа байж болохыг хэлээд өгч буй хэрэг. Бидэнд харьцангуй танил улсууд болох Солонгос, Эстон, Чех гээд тогтвортой хөгжлийн шатандаа яваа улсуудтай харцуулахгүй гэхэд хөрш зэргэлдээх харьцангуй ижил нөхцлөөс, нэгэн зэрэг гараанаас эхэлсэн “хурдацтай хөгжлийн үе”-дээ орж аж үйлдвэржсэн, технологийн хөгжлийн шатандаа яваа Казахстан, Хятад зэрэг улсуудтай харьцуулхад манай улсын хөгжлийн түвшин үнэндээ харамсалтай доогуур байгаа юм (графикийг харна уу).


“ДНБ-ий бүтэц 1990; 2014” графикийг харвал манай эдийн засгийн бүтэц 1990 онд хөдөө аж ахуй 13%, аж үйлдвэр 37%, үйлчилгээ 50% байсан бол 2014 онд хөдөө аж ахуй 14%, аж үйлдвэр 30%, үйлчилгээ 56% болж аж үйлдвэрлэл 7% буурснаас өөрөөр бүтэцэд төдийлөн их өөрчлөлт ороогүй байгааг харж болно. Энэ нь өнгөц хархад л ингэж харагдаж байгаа бөгөөд уул уурхайг аж үйлдвэрийн салбарт оруулан тооцдог аргачлалаас үүдэлтэй. Мэдээж аж үйлдвэрлэл ДНБ-ий 37 хувийг эзэлнэ гэдэг өндөр тоо бөгөөд энэ нь тухайн улсыг аж үйлдвэржсэн орон гэж үзэх үндэслэл болох нь гарцаагүй. Тийм, 1990 он гэхэд манай улс жинхэнэ утгаараа аж үйлдвэржсэн улс болсон байсан. Учир нь уул уурхай манай аж үйлдвэрлэлийн багахан хувийг эзэлж боловсруулах үйлдвэрлэл зонхилж байсан. Харин 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсний дараа нэгээс хоёр жилийн дотор Монгол улс аж

**ДНБ-ий бүтэц: 1990; 2014**



Эх сурвалж: Х.Батсүр 2015. Дата: ҮСХ Архив.

**ДНБ-ий бүтэц: 1990; 2014**




Эх сурвалж: Х.Батсүр 2015. Дата: ҮСХ Архив.

үйлдвэрийн (боловсруулах) бүтээмжийн 90 хувийн чадамжаа алдаж эдийн засгийн уналтанд орсон төдийгүй, эдийн засгийн хөгжлийн суурь бүтэцээ гажуудуулан нураасан юм.

Боловсруулах үйлдвэрлэлийн чадамжаа алдсанаар манай эдийн засгийн

бүтцэд ямаршуухан өөрчлөлт гарсныг “ДНБ-ий бүтэцийн өөрчлөлт: 1990-2014” графикаас харж болно. 1990-ээс 2014 онд ХАА болоод үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хэмжээ 1% болон 6%-иар нэмэгдсэн нь онц анхаарал татах өөрчлөлт биш юм. Харин аж үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь 37%-аас 30% болон буурч аж үйлдвэрлэлийн бүтцэд томоохон өөрчлөлт орсон нь анхаарал татахгүй байхын аргагүй. Аж үйлдвэрийн салбар дахь боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь 68% байсан бол 40% болон буурч харин олборлох салбарын эзлэх хувь хэмжээ эрчтэйгээр нэмэгдэж 32%-иас 60% болж өссөн нь манай улс өдгөө ашигт малтмалын олборлолтоос хамааралтай “аж үйлдвэржсэн” орон болж хувирсныг харуулж буй хэрэг. Уул уурхайг оролцуулахгүйгээр тооцвол өнөөдөр манай аж үйлдвэрлэл ДНБ-ий 12%-ийг бүрдүүлж байгаа бөгөөд энэ тоо 1990 онд 25% байсан юм.

Уул уурхай ба аж үйлдвэрлэлийн (уул уурхайн бус боловсруулах салбар) эдийн засаг дахь нөлөөлөл нь гадаад худалдаан дээр илүү тод харагддаг. 1990 онд манай улсын нийт экспортын 28% уул уурхайн бүтээгдэхүүн, 30% аж



үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн байсан бол 2014 он гэхэд уул уурхайн бүтээгдэхүүн манай нийт экспортын 89%-ийг эзэлж аж үйлдвэрийн бүтээгдэхүүн дөнгөж 4%-ийг эзлэх болсон байна (экспортын бүтэц 1989; экспортын бүтэц 2014 графикийг харна уу).

Ростоу-ын хөгжлийн загварчлалаар “аж үйлдвэрлэлийн хөгжил” гэсэн ухагдахуунд боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хэлдэг бөгөөд харин уул уурхайн олборлолт нь “primitive” буюу уламжлалт (хоцрогдсон, мэдлэг шингээгүй ажиллагаа) аж ахуйд ордог юм. Дэд бүтэцийн хөгжил муутай, “primitive” буюу хоцронгуй “үйлдвэрлэл- уул уурхай” зонхилсон Монгол улсын хувьд хөгжлийнхөө түвшинг чухам хаа байгааг үүнээс мэдэж болно.

Манай улсын хувьд ДНБ-д эзлэх үйлчилгээний салбар 50-иас дээш хувьтай байгаа нь хөгжлийн нэг үзүүлэлт мэт боловч энэ нь өндөр хөгжилтэй улсуудад түгээмэл байдаг өндөр технолог, оюуны салбарын үйлчилгээ гэхээсээ илүүтэй

түүхий эдийн худалдаа, олборлолтын салбарыг дагасан тээвэрлэлт зэрэг үйлчилгээ зонхилж байгаа гэдгийг санах хэрэгтэй.

Бид 1990 оны нийгэм, эдийн засгийн шилжилтээс хойшхи 25 жилийн хөгжлийн түүхийг магтан дуулсаар ирсэн, Ингэхдээ бид ардчилсан засаглал, чөлөөт зах зээлийн систем түүний үр дүн болсон Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) өсөлт гэх мэт тоон үзүүлэлтүүдийг ишлэл болгон дурдах дуртай. Мэдээж энэ 25 жилд хүрсэн амжилт, авсан ололт бий тухайлбал шилжилтийн өмнөх жил буюу 1989 онд манай ДНБ \$3.6 тэрбум доллар байсан бол өдгөө \$12 тэрбум долларт хүрч даруй 3.3 дахин томорсон байна. Гэвч эдийн засаг тоон үзүүлэлтээр томорсон харагдаж буй нь хөгжиж байгаа үг гэж үү, гэх асуултыг асуух хүн ч гардаг. Буруутгах аргагүй. Улсынхаа хөгжлийн түвшинг тодорхойлох, харьцуулалт хийхэд олон улсын түвшинд түгээмэл хэрэглэгддэг хүний хөгжлийн индекс (human development index), баялгийн хуваарилалт зэрэг бусад аргачлалуудаар тооцвол бас сонирхолтой дүн гардаг.

Гэвч энэ удаа би эдийн засгийн бүтэцээр нь хөгжлийн түвшинг тодорхойлох аргачлалаар улсаа хаахана явааг олох гэж хичээв, үр дүн ч гарав, гэхдээ нэг их магтууштай үр дүн бол биш. Уг нь бол хаана яваа нь тодорхой харагдаж байна. Гэхдээ тэр нь чухамдаа бидний байх ёстой байр мөн үү гэдэг асуудал л анхаарал татаж буй юм. Одоогоос 25 жилийн өмнө манай улс экспортын 30%, ДНБ-ийхээ 25 хувийг уул уурхайн бус үйлдвэрлэлээс бүрдүүлдэг өнөөдрийн 12 хувьтай харьцуулбал жинхэнэ утгаараа аж үйлдвэржсэн орон байжээ гэдгийг бид мэдэж авсан. Гэвч өнөөдөр бид экспортынхоо 89 хувийг, ДНБ-ийхээ 18 хувийг уул уурхайгаас бүрдүүлдэг уул уурхайгаас бүрэн утгаараа хараат улс болон хувирсан нь эдийн засгийн бүтэцэд ихээхэн гаж өөрчлөлт орсон байгааг харуулж буй юм. Хамгийн харамсалтай нь бүтэцийн энэ гажуудал нь манай улсын тогтвортой хөгжлийн ирээдүйг боомилж буй төдийгүй хөгжлийн түвшин “аж үйлдвэрлэлийг эхлүүлсэн, дэд бүтцийн бүтээн байгуулалт”-аар тодорхойлогддог 2-р шатнаас ухарч уламжлалт аж ахуй, уул уурхайн олборлолт гэх 1-р шат, 2-р шатны завсар ирж хавчигдсаныг харуулж буй юм. Тиймээ, энэ 25 жилд бид үйлдвэрлэгч улсаас олборлогч, уул уурхайн түүхий эд экспортлогч улс болж хөгжлийн хувьд ухралд орсон.

Х.Батсуурь-Эдийн засагч -  
Улс төрийн Боловсролын Академийн зочин багш 2015.12.02



## **ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

***О.Тунгалаг “Тунгаамал төв” ТББ-ын  
гүйцэтгэх захирал***

Төрийн хэрэгт иргэдийн оролцоог хангах, иргэдийнхээ санал, хүсэлтийг авч, гаргаж байгаа шийдвэртээ тусгах асуудалд манай улс эртнээс анхаарч хуульчлан хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд энэ асуудалд илүүтэй ач холбогдол өгдөг болсон нь сайн хэрэг юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Ардчилсан нийгэм бол сүүдрээ нуудаггүй давуу талтай гэж би хэлэх дуртай. Гэтэл албан тушаалтнууд нээлттэй нийгэмд сүүдрээ ч харахаас айдаг болжээ. Бид өөрсдөө ч “бидний сүүдрийг хүн харахгүй байна. Бидэнд сүүдэр ч байхгүй” гэж бодоод байгаа болохоос биш монголын хэрсүү ард түмэн та бидний сүүдрийг байтугай, хөшигний ар дахь драмыг ч нэвт шувт уншиж харж, эгдүүцэх нь эгдүүцэж, бухимдах нь бухимдаж, шоолох нь шоолж байна” ..гэж шүүмжлэн хэлсэн билээ.

Иргэдийн оролцоог хангах, иргэдээс төрийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахад эрх зүйн орчинг шинэчлэх, иргэний боловсролыг дээшлүүлэх, төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах, төвлөрлийг сааруулах, төрийн анхан шатны байгууллагад эрх мэдлийг шилжүүлэх, хэвлэл, мэдээллийн байгууллагыг хараат бус хэлбэрээр ажиллуулах зэрэг өргөн хүрээтэй асуудлуудыг хөндөх шаардлагатай болно.

Одоо мөрдөгдөж байгаа олон хууль, тогтоомжид иргэдийн оролцоог хангах, тэдний зүгээс тавих хяналтыг сайжруулах, төрийн бус байгууллагуудаар төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх чиглэлээр тодорхой зүйл, заалтууд тусгагдсан боловч, хэрэгжилт нь тийм ч хангалттай байж чадахгүй байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуульд төрийн хэрэгт иргэдийн оролцоо, шаардлагатай мэдээллээр хангах эрхийг дараах байдлаар хуульчилсан байна. “Төрийн эрх мэдэл зөвхөн ард түмний мэдэлд байна, шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй, төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна.” гэж баталгаажуулж өгсөн билээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана” гэж тунхагласан байгаа.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолд “Үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн анхдагч үүрэг мөн. Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарна. Төрийн бодлого боловсруулах, төрд

хяналт тавихад төрийн бус байгууллагын тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшлийг дэмжинэ. Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны бүтээлч арга, хэлбэрүүдийг хөгжүүлнэ.” гэж заасан байна.

Төсвийн тухай хуульд зааснаар төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн төслийг боловсруулахдаа олон нийтэд танилцуулж, гарсан хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах, батлагдсан төсвийн талаарх мэдээллийг хуулийн хугацаанд нийтэд өгөх, төсвийн зарцуулалтыг тайлагнадаг болсон. Мөн орон нутгийн хөгжлийн сангаас авч хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод нээлттэй санал асуулга явуулж, хурал дээр гарсан саналыг хэлэлцэн тэргүүн ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгодог байхаар хуульчлагдсан нь иргэдийн оролцоог хангахад ихээхэн ач холбогдолтой шийдвэр болсон.

Шилэн дансны тухай хуульд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлэхээр заасан нь иргэдийн зүгээс төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих боломжийг бүрдүүлж өгсөн юм.

Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх журмын тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын тухай зэрэг хуульд иргэдийн оролцоог хангах чиглэлээр олон зүйл, заалтууд байгаа бөгөөд гагцхүү тэдгээрийг зөв хэрэгжүүлэхэд төрийн болон иргэний байгууллагууд санаачлага гарган ажиллах, иргэд өөрсдөө холбогдох хуулиудыг судалж, идэвх чармайлт гарган ажиллавал боломж их бий.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар Захиргааны ерөнхий хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль зэрэг олон хуулиуд батлагдаж, захиргааны байгууллагаас шийдвэр гаргахын өмнө иргэдийн саналыг авах, шийдвэрийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах, иргэний хяналтын идэвхжүүлэх талаар олон зохицуулалтуудыг шинээр баталгаажуулсан болно.

Хуульд заагдсан иргэдийн оролцоог хангах дээрх эрх мэдлийг иргэд хир зэрэг мэдэж, хэрэгжүүлж байна, эрх зүйн боломжоо ашиглах хүсэл, сонирхол тэдэнд аль хир байна, иргэдийн эрх зүйн мэдлэг ямар байгаа зэрэг нь өөрөө чухал асуудал юм. Эрх зүйн орчин хангалттай бүрдсэн боловч түүнийг иргэдэд сурталчилж, тайлбарлах ажил хийгдэхгүй, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн хүртээмж хангалттай биш, шаардлагатай мэдээллийг хэвлэл мэдээллээр хүртээмжтэй түгээхгүй байгаа зэрэг олон шалтгааны улмаас иргэдийн оролцоо харьцангуй муу байгаа нь судалгаанаас харагдаж байна.

- Хаанаас мэдээлэл авах талаар мэдлэггүй 68 хувь
- Мэдээлэл тараагддаггүй 70 хувь
- Хэрхэн оролцох талаар мэддэггүй 67 хувь

- Мэдээлэл авах талаар асуугаагүй 81хувь
- Төсвийн талаар мэдлэггүй 23 хувь
- мэдэх сонирхолгүй 13 хувь

Энэ дүн нь иргэдийг төрийн үйл хэрэгт оролцуулах, тэдний санал бодлыг төрийн байгууллагаас гарах шийдвэрт тусгах асуудал амьдралд хэрэгжихдээ харилцан адилгүй байгааг илтгэж байгаагаас гадна төрийн байгууллагаас хууль, тогтоомжийг сурталчлах, иргэдийн оролцоог хангах боломжийг бий болгох талаас нь илүү анхаарал хандуулахыг шаардаж байна.

Иргэдээ хамгийн ойр ажиллаж, тэдний саналыг сонсдог, иргэн, төрийн байгууллага хоёрын дунд гүүр болж ажиллах үүрэг хүлээсэн хүмүүс бол иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид билээ. Хурлын байгууллага, төлөөлөгчид иргэдийн оролцоог хангах үүрэгтэй учраас энэ асуудлыг дэлгэрүүлэн тайлбарлая.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч иргэдийн оролцоог хангах чиглэлээр хэрхэн ажиллах вэ?

1.Хуульд зааснаар иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд асуудал санаачлах эрхээ хэрэгжүүлэх;

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлогч, тухайн орон нутаг ямар асуудалд гол анхаарлаа чиглүүлж, хөрөнгө мөнгөө юунд зарцуулах, ард иргэдийн хүсэл, сонирхлыг судалж, тэдний хүчийг нэгтгэн, үр ашигтай ажил зохион байгуулах тухай шийдвэрийг гаргах үүрэгтэй байгууллага. Энэ үүргээ хэрхэн биелүүлж байгаад шат шатны Хурлын байгууллага, асуудал санаачилж, шийдвэр гаргуулах үүрэг бүхий иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүр дүгнэлт хийж, санаачлагатай ажиллах хэрэгцээ маш их байна. Энэ үүргийн хэрэгжилт шаардлагын түвшинд хүрэхгүй байгаатай олон хүн санал нэгдэнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал санаачилж оруулах, доод шатны Хурал, нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, төрийн бус байгууллагаас асуудал оруулахаар тавьсан саналыг ажил хэрэг болгож, шийдвэр гаргуулах талаар төлөөлөгчид идэвх гарган ажиллах нь юу юунаас илүү чухал байна. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлд Хуралд асуудал оруулах эрх бүхий субъектуудын тоог нэмэгдүүлж өгсөн. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан буюу тэргүүлэгчдийн хуралдаанд Хурлын Тэргүүлэгчид, ажлын хороо, түүнчлэн төлөөлөгч, тухайн нэгжийн Засаг дарга асуудал санаачлан иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэхээр оруулах эрхтэйн дээр, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд, сум, дүүрэг, баг, хорооны Хурал зохих дээд шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно. Харин асуудал оруулахаар бол төсөлдөө холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж хуралдаан болохоос 1-ээс доошгүй хоногийн өмнө иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд тарах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.

Тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгд Тэргүүлэгчдийн хуралдаан буюу бусад хуралд асуудал санаачлан оруулахаа Хурлын даргад мэдэгдэж, материалаа бэлтгэж ирүүлэх хугацааг тодорхой зааж өгсөн байдгийг төлөөлөгчид болон бусад албан тушаалтнууд судалж мэдсэн байх шаардлагатай.

Хуралд асуудал оруулах эрхтэй гэсэн дээрх хуулиар олгогдсон эрхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид мөн асуудал оруулах санал тавих эрхээ тухайн нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, доод шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн нийтийн хурал, баг, хорооны Засаг дарга нар, иргэдэд сурталчилж, санаачлагатай ажиллах хэрэгтэй байна.

2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар Хурлын байгууллага нь иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг зохион байгуулж, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг тайлбарлан таниулах, олон нийтийн үүсгэл санаачилгыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тухайн нутаг дэвсгэр дэх төрийн бус байгууллага, сүм хийдтэй харилцах үүргээ хэрэгжүүлэх;

Хурлын төлөөлөгчид тогтсон хугацаанд иргэдэд хууль тогтоомжийг сурталчлах, хэлэлцэгдэж байгаа хууль, бусад шийдвэрийн төслийн талаар танилцуулж, иргэдийн саналыг авч холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг тогтмол хийж байх үүрэгтэй. Иргэд хууль эрх зүйн мэдлэг дутмаг байдгаас шалтгаалж, эдлэх ёстой эрхээ бүрэн эдлэхгүй байх, эрх ашиг нь хохирох асуудал гаргахгүй байх талаас нь төлөөлөгчид санаа тавин ажиллах учиртай.

3.сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг хуульд заасан хугацаанд авах;

4.Иргэдийн баяр,тэмдэглэлт арга хэмжээг хамтран зохион байгуулах;

5.төлөөлөгчийн нэрэмжит ажлыг зохион байгуулах;

6.нийтээр дагаж мөрдөх, иргэдийн эрх ашгийг хөндсөн шийдвэрийн төслөөр санал авах;

7.иргэдийг холбогдох байгууллагын шагналаар шагнуулахаар уламжлах;

8.иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох албан тушаалтанд асуулга, асуулт тавих, хариуг авах;

9.зарлагдсан төслийг хэрэгжүүлэхэд иргэдэд зохих туслалцаа дэмжлэг үзүүлэх гэх мэт.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба төлөөлөгчөөс холбогдох албан тушаалтанд тавьсан асуулт, асуулгын хариуг сонсох журмыг боловсруулан батлуулж, асуулгын хариуг сарын тодорхой нэг өдөр сонсдог байвал сонирхсон байгууллага, иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцох боломжоор хангагдана гэж үзэж байна.

**Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж байгаа хэлбэрүүд:**

Нутгийн өөрөө удирдах байгууллагаас иргэдийн оролцоог хангах талаар ажиллаж байгаа арга хэлбэр сүүлийн жилүүдэд ихээхэн өргөжиж байгаа бөгөөд иргэдийн саналыг авч, тухайн засаг захиргааны нэгж жил бүрийн төсвөө баталдаг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг юунд зарцуулах, түүний гүйцэтгэлд хяналт тавих ажилд иргэдийн оролцох оролцоо шинэ шатанд гарсан гэж хэлж болно.

- Иргэний танхим, мэдээллийн самбар, цахим хуудсаар Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, авах;
- Санал асуулга зохион байгуулах;
- Хурлын болон төлөөлөгчийн “Нээлттэй хаалганы өдөр”, “Нээлттэй цаг” арга хэмжээг явуулах;
- Иргэний зөвлөл, Хяналтын зөвлөл байгуулан ажиллуулах;
- Үнэлгээ хийх ажилд иргэдийн төлөөлөл, төрийн бус байгууллагыг оролцуулах;
- Хамтарсан ярилцлага, санал солилцох уулзалтыг зохион байгуулах;
- Жагсаал, цуглаан, хэвлэлийн бага хурал хийх;
- Нийтийн сонсгол, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Цахим хуудас, мэдээллийн бусад хэлбэрээр иргэдийн санал, хүсэлтийг хүлээн тодорхой цаг хугацаанд авдаг байх;
- Саналын хайрцаг, дэвтэр ажиллуулах;
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан болон тэргүүлэгчдийн хуралдаан, бусад хурал, зөвлөлгөөнд иргэдийн төлөөллийг урьж оролцуулах;
- Нээлттэй утас ажиллуулах;
- Үзэсгэлэн гаргах, яармаг худалдааг зохион байгуулж иргэдийг оролцуулах
- Төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах, гэрээ байгуулж зарим ажлыг гүйцэтгүүлэх;
- Фокус ярилцлага зохион байгуулах гэх мэт.

**Иргэд, төрийн бус байгууллагууд Хурлын үйл ажиллагаанд оролцож байгаа хэлбэрүүд:**

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд асуудал оруулахаар санал тавих;
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны тайланг хэлэлцэхэд оролцох, иргэд, төрийн бус байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, үр дүнг тусгайлан сонсдог байх;
- Баг, хорооны иргэдийн нийтийн Хурлууд нутаг дэвсгэрийнхээ үйлчилгээний байгууллагын тайланг иргэдээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд үнэлгээ өгүүлэх;
- Иргэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд оролцож, үг хэлэх;
- Хурлаас гарах шийдвэрийн төсөлд санал өгөх, гарсан тогтоолтой танилцаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад оролцох;
- Архивын материалтай танилцах боломжтой байх.

Иргэдийн оролцоо сул байгаагийн гол шалтгаан нь иргэд оролцох эрхтэйгээ мэддэггүй, оролцох учраа олдоггүй, мэдсэн ч оролцохыг хүсдэггүй байдагтай холбоотой. Мөн иргэдийн зүгээс төрийн байгууллагад итгэх итгэл суларсан, тэднийг оролцуулах талаар нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын Тамгын газрын зүгээс санаачлага гаргаж ажиллахгүй байгаатай ч холбоотой юм.

**Цаашид яаж ажиллах вэ?**

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд хуралдааныхаа дэг, бусад журмаа шинэчлэх ажлыг хийх шаардлагатай байгаа юм. Ялангуяа Хурлын ил тод, үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дараах зүйлийг тусгах. Үүнд:

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны үеэр иргэд чөлөөтэй орж, ажиглах нөхцлийг бүрдүүлэх, явуулын хуралдаануудыг зарим асуудлаар зохион байгуулах;
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд иргэд асуудал оруулж хэлэлцүүлэх эрхийг хангах талаар хуралдааны дэгд тусгаж хэрэгжүүлэх, нээлттэй хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулах, иргэдийн саналыг авах ажлыг зохион байгуулах;
- Хуралдааны тов, хэлэлцэх асуудал, иргэдийн саналыг хэдийд сонсох, хэзээ санал хураах зэргийг урьдчилж мэдээлж байх;
- Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдуулж хуралдаанаас өмнө нээлттэй хэлэлцүүлэг хийх, иргэдийн саналыг авах хурал, цуглааныг

- зохион байгуулах, саналын хайрцаг ажиллуулах;
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны болон Тэргүүлэгчдийн хуралдааны тэмдэглэлтэй сонирхсон иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөл танилцах боломжийн талаар дотоод журмандаа тусган хэрэгжүүлэх, иргэдэд мэдээллээр үйлчлэх чиг үүргийг бий болгож, тэдний эрэлт, хэрэгцээг хангахуйц мэдээллийн санг бүрдүүлэх;
- Цахим мэдээллээ архивладаг, орсон өөрчлөлтийг хугацаа алдалгүй нэмж тусгадаг байхаас гадна иргэдээс ирж байгаа мэдээллийг цэгцэлдэг, санал, гомдлын биелэлтийн талаар иргэдэд буцаж хариу өгдөг байх;
- Нутаг дэвсгэрийн хэмжээнд ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудын судалгааг гаргаж, тэдгээртэй хамтарч ажиллах гэрээ байгуулан үйл ажиллагааг нь орон нутгийнхаа хөгжилд чиглүүлэх;
- Иргэний танхимын ажиллагааг тогтмолжуулж, байнгын мэдээлэл түгээж байх;
- Мэдээллийн яармаг, үзэсгэлэнг тогтсон хугацаанд нээн ажиллуулж байх;
- Иргэний нийгмийн байгууллагаар зарим төрийн ажил, үйлчилгээнд мониторинг хийлгэх, түүнд зарцуулах зардлыг төсөвтөө тусгах;
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг тойрогт нь тогтмол хугацаанд ажиллуулдаг журамтай болж, түүнийгээ мөрдүүлж ажиллах, төлөөлөгчдөөр иргэдэд мэдээлэл хийлгэж хэвшүүлэх, төлөөлөгчдийн үйл ажиллагаанд иргэдээр үнэлгээ өгүүлдэг болох;
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаан, Засаг даргаас гаргасан шийдвэрийг иргэд, байгууллагад хүргэдэг, тогтмол сурталчилдаг өдөртэй байх шаардлагатай гэж үзэж байна.

Ингэж ажилласнаар нутгийн удирдлагаас гаргах шийдвэрийн чанар сайжирч, иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдэж, ардчилал бодитой хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй, шударга, шуурхай, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангах нөхцөл бүрдэж төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд иргэний нийгмийн зүгээс хяналт тавих бодит нөхцөл нэмэгдэнэ. Мөн авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагаанд ахиц гарах, төрийн албанд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах, ашиг хонжоо олох, эдийн болон эдийн бус хэлбэрээр давуу ашигтай байдал болгох зэрэг хууль бус үйл ажиллагаатай тэмцэх ажилд тодорхой түлхэц үзүүлэх юм.

*О.Тунгалаг-КАС-Улс төрийн Боловсролын Академийн  
Зочин багш. 2015.12.06*

**“МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ҮҮСЭЛ,  
ХӨГЖИЛ, ТӨЛӨВИЛ ЦААШДЫН ХАНДЛАГА”**

***сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг нээж Улс төрийн боловсролын Академийн Гүйцэтгэх захирал М.Энхбатын хэлсэн үг: /***

Төр ёсны 2220 жилийн түүхтэй Монгол орны хувьд түүхэн цаг үе бүхэнд тодорхой бүлгүүд байж, улс төрийн үйл явц эрчимтэй хөгжиж байсан нь тодорхой. Монголын ард түмний олон мянган жилийн түүхийн тодорхой үеүүдэд, тухайлбал Нэгдсэн улс байгуулагдсанаас эхлэн Эзэнт гүрний үе, улмаар улс төрийн бутралын хүнд бэрх цагт ч нийгмийн тодорхой бүлэглэлүүд байсаар ирсэн хэдий ч өөрийн өвөрмөц онцлогтой Дорно дахины уламжлалт нийгэм болохын хувьд чухамхүү улс төрийн нам байгуулагдсан түүхийн асуудал нилээд хожуу XX зуунд холбогдох юм. Үүнтэй холбоотойгоор Монголын түүхийн чухам хэдий үед нь улс төрийн ямар нам, бүлгүүд буй болсон, тэдгээр нь улс төрийн тогтолцоонд ямар байр суурь эзэлж, нийгмийн удирдлагад хэрхэн оролцсон асуудал гарна. Түүнчлэн тэдгээрийн хэв маяг, зорилго бодлого, нийгмийн бааз суурь, бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалтын шинж төрх, улс төрийн үйл ажиллагааны арга хэлбэр зэргийг тодорхойлох шаардлага ч бас буй.

1911 оны үндэсний хувьсгалын нэг гол дүн бол хуучин нийгмийг шүүмжлэн, түүний гэм согогийг сайжруулах, шинэчлэх арга замыг эрэлхийлэгчдийг төрүүлсэнд оршино. Чухам тэдний дотроос тухайн цагийн Монголын нийгэмд хэд хэдэн улс төрийн бүлэглэлүүд ялгаран гарч, улмаар үйл явдлын өрнөлтөөр улс төрийн намын үр хөврөл болсон нууц бүлгэмүүд товойн гарсан болно. Энэ үйл явдал нь Монголд анх удаагаа улс төрийн нам байгуулагдах эх суурийг тавьсан бөгөөд бүтэн зууны туршид нэг намаас олон намын тогтолцоо болон төлөвших үйл явц үргэлжилж, эдүгээ ч нийгэм төрийн удирдлагад гол үүрэг гүйцэтгэж байна. Нэн ялангуяа 1990 оны үеэс өрнөсөн ардчилсан хувьсгалын үр дүнд Монголд олон намын тогтолцоо улс төрийн үзэгдлийн хувьд бодитой оршин үйлчлэх болсон билээ.

Энэ нөхцөл байдал нь улс төрийн үзэгдлийн төвшинд бодит хэлбэршлээ олчихоод байгаа олон намын системийг шинжлэн үзэж, түүний төлөвшилт хөгжлийн явцад нөлөөлж буй улс төрийн бодит орчин, хүчин зүйлүүдийг иж бүрэн утгаар нь судлах зорилтыг түүх, төр судлалын салбарт дэвшүүлэн тавьж байгаа юм. Иймд бид онол практикийн чухал ач холбогдол бүхий энэ асуудлыг өнөөдрийн бага хурлынхаа үндсэн сэдэв болгон тавьж Та бүхнээрээ хэлэлцүүлэхээр хуран цуглараад байна.

Онол практикийн бага хурлын гол зорилго нь Монгол оронд анхны улс төрийн нам байгуулагдан, хөгжин бэхжиж, нийгмийн удирдлагын тогтолцооны цөм болсон түүхийн дэвсгэр дээр хөгжлийн шинэ үе дэхь олон намын систем түүний төлөвшлийн онцлог, үндсэн шинж хандлагыг тодорхойлох явдалд оршино. Энэ сэдэвийг сонгож авахдаа:

Нэгдүгээрт: Монгол оронд улс төрийн анхны нам байгуулагдсаны түүхэн ач холбогдолыг тодорхойлох, Хоёрдугаарт: Улс төрийн тогтолцооны хүрээн дэх онолын болон практик шинжтэй аливаа асуудлыг бодитойгоор авч үзэх нөхцөл нь намын системийн төлөвшилтэй холбоотой байдаг хийгээд, Гуравдугаарт: Ардчилсан засаглалын үйл ажиллагаанд зонхилох байдлаар оролцон нөлөөлдөг намууд түүний бүрэлдвэр болсон намын системийн асуудлыг судлах нь төрийн удирдлага, төрийн зохион байгуулалтын бүтэц, түүний төлөвшилтийн асуудлыг боловсруулах ажлын анхдагч үндэс болдогийг тулгуур болголоо.

Өнөөдрийн бага хурлаара бид: Нэгд: Улс төрийн нам, түүний системийн тухай ойлголт, тодорхойлолтыг өгөх, Хоёрт: Монголд анхны нам үүссэн учир шалтгаан түүхэн нөхцөл байдлыг харуулах, Гуравт: XX зууны Монголын төр, нийгмийн удирдлагад намуудын эзлэх байр суурь, гүйцэтгэсэн үүргийг тодорхойлох, Дөрөвт: Монгол дахь олон намын тогтолцоо үүсэн бүрэлдсэн шалтгаан, нөхцөлийг тодотгох,Тавд: 1990 оноос хойшхи Монголын намын системийн төлөвшлийн онцлогийг авч үзэх зорилтуудыг дэвшүүлж байна.

“Монголын улс төрийн намуудын үүсэл, хөгжил, төлөвшил, цаашдын хандлага” сэдвийн судалгааны үндсэн эх сурвалж нь Монгол Улсын архивын баримтууд, улс төрийн нам судлалын онолын бүтээлүүд, Монголын намуудын үндсэн баримт бичгүүд / мөрийн хөтөлбөр, үзэл баримтлал/, сонгуулийн болон санал асуулгын дүн зэрэг эх хэрэглэгдэхүүн ба энэ сэдвийн хүрээнд хийгдсэн судалгааны холбогдох материалууд , ном зохиол, тогтмол хэвлэл болно.

Тухайн сэдвийн судлагдсан байдал: Хүн төрөлхтний улс төрийн сэтгэлгээний түүхэн хөгжлийн явцад намыг үзэх үзэл нарийн төвөгтэй замыг туулан, олон зүйлийн хүндрэл бэрхшээлтэй тулгарч ирсэн ч намын түүхийг судлах сонирхол хэзээ ч буурч байсангүй. Нам судлалыг жинхэнэ утгаар нь өнөөгийн ойлголтын төвшинд судлахад өрнөдийн нам судлаач эрдэмтэн – М.Острогорский, Р.Михельс, М.Вебер, М.Дюверже, Р.Арон, Дж.Сартори, Дж.Лапаломбара нар чухал үүрэг гүйцэтгэжээ.

Харин постсоциализмын орнуудад нам судлал, жинхэнэ утгаараа хөгжиж байгаагүй ч тухайн орны эрх баригч намын түүхийг Шинжлэх ухааны коммунизмын онолын хүрээнд марксист арга зүйд тулгуурлан гүн гүнзгий судлан боловсруулсан нь тодорхой. Энэ логик ч Монголд үйлчилсэн бөгөөд нийгмийн хөгжлийн тодорхой үе шат бүрт тус орны төрийн эрхийг барьж байсан цорын ганц намын түүх судлалын агуулга, үзэл хандлага, цар хүрээ өөр өөр байсан билээ. Гэхдээ энэхүү судалгаа нь шинжлэх ухааны хувьд үнэ цэнэтэй зүйл болохыг үгүйсгэх ёсгүй.

Монгол оронд улс төрийн нам үүссэн түүхийг судлах ажлын эхлэл бүр 1920-иод оны дунд үед тавигджээ. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараагаар улс орныхоо тусгаар тогтносон байдлыг бататган бэхжүүлэх, нийгмийг шинэчлэх зорилт дэвшигдэж, тэдгээрийг хэрэгжүүлэгч нь ардын төр, Монгол Ардын Нам хоёр байв.

Тийм ч учраас ХХ зууны Монголд нам хэмээх улс төрийн байгууллага буй болж, эрх чөлөөний тэмцлийг удирдан зохион байгуулж, улмаар нийгэм төрөө шинэчлэх, хөгжил дэвшилд хүрэх үйлсийг эхэлсэн түүхийг өгүүлсэн анхны ном товхимол гарч эхэлсэнээс Ц.Дамбадоржийн “МАН-ын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд” номыг энэ түрүүнд нэрлэх ёстой. Нэн ялангуяа түүнд орсон Д.Догсомын дурдатгал нь нууц бүлгэмийн үүсэл, эхэн үеийн үйл ажиллагааны тухайд үнэ цэнэтэй эх хэрэглэгдэхүүн болсоор ирсэн. 1930-аад оны эхээр МАН-ын анхдугаар их хурлын тухай Л.Дэмбэрэлийн бэсрэг товхимол бичигдэж, намын доторхи зөрөлдөөний тухай Ө.Бадрахын 2 дэвтэр зохиол гарчээ. Улмаар хувьсгалын түүхийг боловсруулах анхны оролдлого хийгджээ. Тэдгээрт МАН-ын үүсэл, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар үнэ цэнэтэй арвин баялаг мэдээ буй. 1950-иад он хүртэл МАН-ын түүх судлалын хүрээнд их төлөв дурдатгал дурсамжийн чанартай ном зохиолууд, зарим нэгэн баримтын эмхтгэл гарч байжээ.

Монгол улс үндэсний түүхч боловсон хүчинтэй болсон үеэс намын түүхийг судлах ажил нилээд эрчимжиж, 1955 онд Намын Төв хорооны дэргэд Намын түүхийн институт байгуулагдаж, профессор Д. Төмөр-Очир тэргүүтэй зохиогчдын хамтлаг байгуулагдаж “МАХН-ын түүхийн суралцах бичиг” бүтээлийг туурвисанаас хойш Монголын анхны улс төрийн намын талаар олон арван ном бүтээл, баримт бичгийн эмхтгэл, намын удирдагчдын хэлсэн үг, тавьсан илтгэл, гишүүдийн дурдатгал болон намын түүхийн олон асуудлаар хэдэн зуун өгүүлэл гарчээ. Түүнчлэн намын түүхийн ерөнхий болон тодорхой асуудлуудаар манай түүхчдийн бичсэн томоохон бүтээлийн тоонд Л.Бат-Очир, Лха.Бат-Очир, Д.Даш, С.Ичинноров, Г.Лхамсүрэн нарын зохиолууд зүй ёсоор орно. Эдгээр бүтээлүүдийн хамарсан асуудлын цар хүрээ асар өргөн тул энэ удаад зөвхөн дурдах төдийгөөр хязгаарласан болно.

Монгол оронд ардчилсан хөдөлгөөн үүсэж, нийгэмд олон ургальч үзэл дэлгэрэн хөгжсөнөөр эрдэмтэд судлаачид, улс төрчид олон намын систем хийгээд монголын намуудын төлөв байдал, хөгжлийн чиг хандлагыг сонирхон судлах явдал мэдэгдэхүйц өргөжиж байна. Өнөөдөр улс төрийн нам, намын системийн судлалын чиглэлээр Ж.Болдбаатар, А.Цанжид, В.Отгоннасан, А.Юндэндорж, М.Энхсайхан, Д.Баярхүү, Х.Гүндсамбуу, С.Содном, Б.Дэлгэрмаа, Д.Болд-Эрдэнэ, Б.Батжаргал, Д.Ганхуяг, Д.Ганбат нарын зэрэг эрдэмтэд, улс төр судлаачид болон улс төрчдийн судалгаа буй болжээ.

Өнөөдрийн бага хуралд “МАН-ын түүхэн замнал” гэсэн илтгэлийг аймгийн МАН-ын дарга, аймгийн Засаг Дарга, доктор Д.Чандмань тавина. “Монголын улс төрийн намуудын үүсэл, төлөвшил, цаашдын хандлага” илтгэлийг аймгийн Улс төрийн боловсролын Академийн захирал, улс төрийн ухааны магистр, улс төр судлаач М.Энхбат тавьж хэлэлцүүлнэ. Бага хурлын ажиллагаанд Дундговь аймагт үйл ажиллагаагаа явуулж буй улс төрийн намуудын төлөөлөл болж аймгийн Ардын намын дарга Д.Чандмань, аймгийн ИТХ-ын дарга Ц.Мөнгөнцоож, Ардчилсан Намын дарга Л.Данзанноров, Иргэний - Зориг намын

дарга Түмэндэмбэрэл, МАШСН-ын дарга Хүүбаян, Сайнцагаан сумын Ардын намын дарга М.Баянсан, сумдын ИТХ-ын дарга, Засаг Дарга, намуудын дарга нар, хэвлэл мэдээллийн сурвалжлагчид, улс төр судлаачид, түүх, нийгмийн ухааны багш нар иргэд сонирхогчид оролцож байгааг баяртайгаар мэдэгдье. Ингээд Та бүхнийг бага хурлынхаа ажиллагаанд идэвхтэй оролцохыг хүсч хурлын ажиллагааг нээснийг мэдэгдье. Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсэн ерөө. Баярлалаа.

*Бага хуралд тавьсан Монголын улс төрийн намуудын үүсэл, хөгжил, төлөвшлийн үйл явц” илтгэлээс:*

*Илтгэгч нь: М.Энхбат /УТБА/*

...Автономит эрхээ алдсанаар туурга тусгаар улсын үед ардчилсан үзэлтнүүдийн санаж сэдсэн бүхэн талаар өнгөрч монголчууд хүн төрөлхтний хөгжлөөс хол хоцорсон хэвээр үлдэх аюул дахин нүүрлэв. Монголын ард түмэн тооны хувьд ч, төрийн тусгаар тогтнолын хувьд ч мөхөх, сэхэхийн дэнсэн дээр байлаа. Харийн түрэмгийлэгчдийг жигшин эсэргүүцэх хүсэл эрмэлзлэл нь нийгмийн гүнд оршиж байсан бусад зөрчлүүдийн хамт илрэн гарч ирэв. Тэдгээр зөрчлүүдийн цар хүрээ, нөлөөлөл харилцан адилгүй ч нийгмийн бүхий л давхрагын дунд үл тэвчих байдлыг буй болгон нийт үндэсний хямралд хүргэв.

1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын гол үр дүн нь хуучин нийгмийг шүүмжлэн, түүний гэм согогийг сайжруулах, шинэчлэх арга замыг эрэлхийлэгчдийг төрүүлсэнд оршино. Чухам тэдний дотроос тухайн цагийн Монголын нийгэмд хэд хэдэн улс төрийн бүлэглэлүүд ялгаран гарч, үйл явдлын өрнөлтөөр улс төрийн намын үр хөврөл болсон нууц бүлгэмүүд үүссэн. Энэ бүгд нь 1921 оны ардын хувьсгалын шууд угтал болсон юм.

Монголын хувьсгалчид буурай хөгжилтэй оронд улс төрийн анхны нам байгуулан 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалыг оройлон манлайлж, ялалтанд хүргэсэн нь үнэхээр гавъяатай үйл хэрэг байсан. Нам байгуулахыг эрхэмд үзсэн нь дэлхий нийтийн жишигтэй ч, улс орны хувь тавиланд ч нийцсэн алсын хараатай сонголт байлаа. Монгол орон төрт ёсны олон зууны уламжлалтай ч, дэлхийн улс төрийн газрын зурагнаас арчигдах дөхсөн, сөнөж буй үндэстний жагсаалтад орж байсан улс орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг Монгол Ардын Намыг үүсгэн байгуулагчид дахин сэргээж, хамжлагын харилцааг халж, улс эх орондоо бүгд найрамдах засаглалыг тунхагласан билээ.

Энэ үйл явдал нь Монголд анх удаагаа улс төрийн нам байгуулагдах эх суурийг тавьсан бөгөөд бүтэн зууны туршид нэг намаас олон намын тогтолцоо болон төлөвших үйл явц үргэлжилж өнөөдөр ч нийгэм төрийн удирдлагад гол үүрэг гүйцэтгэж байна.1980-аад оны сүүлчээр Монгол оронд төржсөн нэг намын хүнд сурталт бүтцийг халж, ардчилсан тогтолцоог буй болгохын төлөө тэмцэл хүчтэй өрнөх болов. Энэ тэмцлийн явцад ард олны үндэсний ухамсар

сэргэн шинэ намууд төрж гарах болов. Монгол оронд улс төрийн шинэ намууд үүсэхэд нөлөөлсөн гадаад ба дотоод хүчин зүйлүүдийг дараах байдлаар ерөнхийд нь томъёолж болно. Үүнд: 1. 1980-аад оны дунд үеэс социалист систем задрах шинж тэмдэг илэрч, Дорнод Европын социалист гэгдэж байсан орнуудад ардчилал шинэчлэлийн үйл явц болсонтой зэрэгцэн БНМАУ-тай оршихуйн маш олон сэжмээр, түүний дотор үзэл суртлын бат нягт холбоосоор гагнагдсан ЗСБНХУ-д М.С.Горбачёвын өөрчлөн байгуулалт” өрнөж эхлэв.



“Перестройка” хэмээх тэрхүү өөрчлөн байгуулалтын гол зорилго нь хүнд сурталт тоталитар дэглэмийн уршгийг арилган, социализмыг өөрийнх нь хүрээнд шинэчлэхэд оршиж байсан боловч, социализмын сүйрлийг аварч чадсангүй. Гэхдээ түүний гол үр дүнд нь Дорнод Европын болон Азийн зарим оронд ардчиллын үйл явцыг түргэтгэхэд хүргэсэн юм. Энэ бүхэн нь Монголд ардчиллын үйл явц өрнөн, олон ургальч үзэл дэлгэрсний илрэл болсон шинэ намууд үүсэх таатай гадаад угтвар нөхцөл болжээ.



2. Намууд үүсэн бүрэлдэх үйл явцыг нэг намын уламжлалт бүтэц үр нөлөөгөө алдмагц гэнэтхэн буй болсон хэмээн хялбарчлан ойлгож болохгүй бөгөөд харин нийгмийн хямралын бүхий л үйл явцаар урт хугацааны туршид бэлтгэгдсэн зүй тогтолт үзэгдэл, тоталитари болон авторитар дэглэмийн өөрийнх нь гарцаагүй бүтээгдэхүүн байв. Өөрөөр хэлбэл шинэ намууд нийгмийн өөрийнх

нь гүнд хуримтлагдсан зөрчил, бэрхшээл гүнзгийрсэн хямралын үр дүн мөн. Учир нь нийгмийн “зогсонги байдал”, хямрал нь анги бүлгүүдийн доторхи ашиг сонирхлын бодит ялгарлын үйл явцыг шинэ өнгө аяс хэлбэрээр гүнзгийрэхэд хүргэж тэр нь тус оронд улс төрийн шинэ намууд үүсэн бүрэлдэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ.

3. 1980-1990 – ээд оны зааг үед олон түмэн хүнд сурталт, захиран тушаах тогтолцооны мөн чанарыг улам бүр ойлгон мэдрэхийн хирээр улс төрийн идэвхи нь сэргэж ирэв. Энэхүү хандлага нь залуучуудын болон нийгмийн тэргүүлэх сэхээтнүүдийн дунд илүү тод илэрч тухайн үед төр засгийн алдаатай бодлогыг илчилсэн ухуулах хуудас гудамж талбайд нааж, эрх баригчдыг шүүмжлэх, ардчилал, шударга ёсны төлөө тэмцэлд уриалах болов. Өгүүлэн буй үед “Цагийн толь” сонин гаргаж байсан УБДС-ийн оюутнууд, МҮЭ-ийн Соёлын төв ордны улс төр сонирхогчдын “Орчлон” клуб, МУИС-ийн физик математикийн

багш нар улс төрийн “Шинэ үе” бүлгийнхэн, “Залуу эдийн засагчдын клуб” зэрэг бүлгэм байгууллага буй болж байв. Улмаар 1989 оны 11-р сарын сүүлээр хуралдсан Залуу уран бүтээлчдийн улсын 2 –р зөвлөлгөөнд оролцогсод нийгмийн байдлыг хурцаар шүүмжлэн, шинэчлэлтийн үйлсийн төлөө шинэ байгууллага болох Монголын Ардчилсан Холбоог үүсгэхээ зарлажээ. Чухам энэ үеэс олон түмний идэвхи онцгой сэргэн идэвхжиж, оршин буй дэглэмийг эсэргүүцсэн, шүүмжилсэн, өөрчлөхийг эрмэлзсэн олон арван холбоод үүсэж эхлэв. МоАХ-ны дараагаар Ардчилсан Социалист Хөдөөлгөөн /АСХ /, Шинэ дэвшилт Холбоо, Эвийн Холбоо нэгдэн Шинэ дэвшилт холбоо байгуулагджээ. Цаашдаа 1990 –ээд оны улс төрийн тэмцлийн явцад Монголын ногоонтны холбоо /МНХ /, Монголын сүсэгтний холоо / МСХ /, Монголын малчин тариачны холбоо /ММТХ /, Монголын ажилчны нэгдсэн холбоо / МАЖНХ / үүсэж тэдгээрийн суурин дээр Монголын Ардчилсан Нам, Монголын Социал-Демократ нам, Монголын Ногооны Нам, Монголын Үндэсний дэвшлийн нам, Монголын Чөлөөт хөдөлмөрийн нам эхлэн байгуулагдав. Нам байгуулагдах үйл явц үргэлжилж Шашинтны Ардчилсан Нам, Монголын Хөрөнгөтний Нам, Малчин Тариачны Нам, Хувийн Өмчтөний Нэгдсэн Нам, Тусгаар Тогтнолын Нам, Нэгдсэн Нам, Сэргэн Мандлын Нам тус тус бий болж улс төрийн үйл ажиллагаагаа явуулах болсон. 1990 – ээд оны эх гэхэд Монголд 20 орчим нам байгуулагдсан түүхтэй. Тэдгээрийг ерөнхийд авч үзэхэд: 1.Эрх баригч нам, 2.Шинээр үүсч байгаа улс төрийн нам, эвсэл холбоод болон хөдөлгөөнүүд, 3. Улс төрийн үйл ажиллагаанд оролцдог олон нийтийн болон сайн дурын үүсгэл санаачлагын байгууллагууд хэмээн хувааж болох байлаа.

Ингэж Монголд олон намын төлөвшлийн гараа болох шинэ намуудын үүсэл бүрдэлтийн үйл явц эхэлсэн. Монголын намуудын үүсэл бүрдэлтийн үйл явц нь нам үүсэх нийтлэг жишиг хийгээд өвөрмөц онцлог зүйлийг өөртөө багтаан хослуул сан улс төрийн түүхэн үзэгдэл байсан.

Германы социологич М.Вебер улс төрийн нам үүсэл бүрдэлтийнхээ түүхэнд 3 үе шатыг дамждаг гэж үздэг. Үүнд явцуу бүлэглэл / язгууртны /, улс төрийн клуб, улс төрийн намууд гэж ангилжээ. Монголд улс төрийн нам үүсэх үйл явц нь тухайн үеийн нийгэм, улс төрийн амьдралын түүхэн өвөрмөц нөхцөл байдлын тусгал болсон улс төрийн шинжтэй бүлэг, бүлэглэлүүдээр дамжин хэрэгжсэн юм. Тийм бүлэглэлд 1919 оны зааг үеэс болон энэ зууны 1980 – аад оны сүүл үеэс тус оронд үйл ажиллагаагаа явуулж байсан бүлэг, бүлэглэлүүдийг багтааж болно гэж үздэг.

20-р зууны эхэн үед Монголд “ Консулын дэнжийн бүлэг”, “Хүрээний бүлэг”, “Ардын нам”, “Түшмэдийн нам”, “Ноёдын нам” нэртэй улс төрийн бүлэглэлүүд үйл ажиллагаагаа явуулж байсан бол 1980-аад оны сүүлчээр “Шинэ үе бүлгэм”, “Залуу эдийн засагчдын клуб”, “Дэвшилт залуучуудын эвслийг санаачлагчид”, “ Орчлон клуб” зэрэг бүлэглэлүүд ажиллаж байсан. Монголд эхэлсэн улс төрийн намууд бүрдэх үйл явц нь бүтцийн дараахь үндсэн хэлбэрүүдийг дамжин хэрэгжсэн байна. Үүнд: 1. Цаг үеэ бодитой ойлгож мэдэрсэн, нийгмийн

ухамсартай тэргүүний хэсгийн санаачилгаар байгуулагдсан бүлэг, бүлэглэл, клубын хэлбэр, 2. Эвсэл, холбоо, иргэний хөдөлгөөн, байгууллагын хэлбэр, 3. Улс төрийн намууд гэж ангилж болно.

Монголд улс төрийн намууд үүсэн бүрдэх процесс нь “доороос” өөрөө зохион байгуулагдах хэлбэр, нам дотроосоо болон намууд бие биенээсээ зааглан салах, намууд өөр хоорондоо нэгдэн нийлж зохион байгуулалтын нэгдмэл бүтцэд орох механизмаар аль алиныг нь дамжин хэрэгжсэн байна. Ардчилсан өөрчлөлтийн эхэн үед намуудын задралаас шинэ нам үүсэх үйл явц нэг биш удаа ажиглагдсан бөгөөд энэ нь тухайлбал, хэдхэн жилийн өмнө бат цул байсан МАХН-аас жигүүр гарч, тэр нь томроод МСМН



болох буюу эсвэл өөр нам руу хуйлрах үзэгдэл 1990 – ээд оны үед гарч байлаа.

1990-ээд оны эхэн үед МоАН-аас иргэний ардчилсан жигүүр тасран, ЧХН, БНН нэгдэн нийлж Нэгдсэн нам /НН / бий болсон, түүний дараахнаас /1992/ МоАН, МҮДН, МСМН, Нэгдсэн Нам гэсэн улс төрийн 4 хүчин нэгдэж МҮАН байгуулагдсан түүнчлэн МХӨНН, МТТН, ММТНН нийлж МУНН төрж гарсан зэрэг нь Монголд намуудын нэгдлээр дамжин шинэ нам төрж болох бодит боломж байгааг харуулсан юм.

Монголд намууд үүсэн бүрэлдэх үйл явцын үндсэн онцлог нь тэдгээрийн үүсэх үеийн үзэл баримтлал, нийгмийн төлөөлөл болон бүтэц зохион байгуулалтын бүрдэлтийн өвөрмөц шинж байдлаар нөхцөлдөж байна.

1990-ээд оны зааг үеэс нэг намт тоталитари засаглалыг эвдэж ардчилсан төр төвт тогтолцоонд шилжих нийгмийн бодит зайлшгүй хэрэгцээ шаардлагын улмаас Монголд улс төрийн шинэ намууд ойрмогхон олноор гарч ирсэн. Гэхдээ тэд цэгцэрсэн улс төрийн үзэл баримтлалын нарийн зааг ялгарлын төвшинд бус харин тоталитари дэглэмийг шүүмжилж эсэргүүцсэн олон түмний үзэл бодлын нийтлэг үнэлэмжинд тулгуурлаж байсан. Тодруулж хэлбэл, 1990 –ээд оны эхэн үеийн намуудын нийгмийн төлөөлөл бүтэц бүрэлдэхүүн нь баруун, зүүний сонгодог үзэл, онолоо дагаж түүнд тулгуурлах үндсэн дээр бүрдээгүй. Харин таньдаг мэддэг лидерээ дагах буюу мэргэжлийн чиглэл, цаг үеийн нийгмийн улс төрийн уур амьсгалыг хэрхэн хүлээн авснаараа нийлж нэгдэж тухайн намын нийгмийн дэмжигч хэсгийн гол цөмийг бүрдүүлж байсан. Жишээ нь: МСДН нь анх үүсэн байгуулагдахдаа их төлөв физикч математикч зэрэг байгалийн шинжлэх ухааны мэдлэг мэргэжил бүхий сэхээтний бүлгийн төлөөлөгчдийг, МҮДН нь эдийн засагчдыг эгнээндээ нэгтгэж байсан.

Дээр дурьдсан бүхнийг нэгтгэж хураангуйлж үзвэл дараахи хэдэн зарчмын дүгнэлтийг хийж болох байна. Нэгдүгээрт, олон арван жилийн турш оршин

үйлчилж байсан захиран тушаах тоталитари дэглэмийн уг мөн чанарыг илчлэн шүүмжилж түүнийг халж өөрчлөх гэсэн олон түмний нийгэм, сэтгэл зүйн уур амьсгал нь 1990-ээд оны үед шинэ үүсэж байгуулагдаж байсан улс төрийн намуудын нийгэм, улс төрийн үзэл баримтлалын сэтгэл зүйн дэвсгэр суурь болж байсан. Хоёрдугаарт, Монгол дахь улс төрийн шинэ намуудын нийгмийн төлөөлөл нь нийгмийн янз бүрийн бүлэг давхрааг багтааж байсан үндсэндээ нэг төрлийн шинжтэй байжээ. 1990-ээд оны эхэн үеийн нам, хүчнүүд нийгмийн тодорхой хэсэг бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлэхээсээ илүү нийгмийн нийт бүлэг, давхаргын нийтлэг эрх ашгийг бүхэлд нь буюу түүний зарим талыг төлөөлөх шинжтэй байв. Гуравдугаарт, 1990-ээд оны үеийн намууд тухайн үедээ үндэсний хэмжээнд өөрийн зохион байгуулалтын бүтцээ бүрдүүлж амжаагүй, цэгцрээгүй байсан.

1990-ээд оноос Монголд өрнөсөн Ардчилсан Хувьсгалын нэг үндсэн онцлог нь тус оронд улс төрийн намууд үүсэн бүрэлдэх үйл явцын зэрэгцээ тэдгээрийн төлөвшил хөгжих ерөнхий орчин, хүрээ, хүчин зүйлийн систем бий болж, намууд төлөвших үйл явцтай цаг хугацаа, орон зайн хувьд давцан явагдсан явдал юм. 1990 –ээд оны ардчиллын явцын өрнөлтийн үр дүнд бүрэлдэн бий болсон улс төрийн намуудын төлөвшилтийн үйл явцад:

Нийгэм, эдийн засгийн орчин/ улс орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн /, Эрх зүйн зохицуулалтын орчин / Нэг намын онц эрхийг халж, нам төрийн үүргийг зааглах эрх зүйн үндсийг бүрдүүлж, намуудын хууль, сонгуулийн хууль, парламентын, засгийн газрын, Ерөнхийлөгчийн болон шинэ Үндсэн хууль бусад холбогдох эрх зүйн актууд батлагдсан / Улс төр, засаглалын орчин / орчин үеийн ардчилсан улс төр, засаглалын тогтолцооны бүтэц бүрэлдүүн бий болсон /, Соёл, оюун санааны орчин / нэг туйлт үзэл үнэлэмжийн тогтолцооноос олон туйлт плюраль үнэлэмж прагматик үзэл хандлагад шилжсэн / Эдгээр орчин нөхцөл нь намын лидер, хошуучлагч, боловсон хүчин, нийгэм сэтгэл зүй, эрх зүйн болон мөнгө санхүү, нийгмийн бааз, дэмжигчдийн гэх зэрэг бусад олон цогц хүчин зүйлийн нөлөөллийн механизмаар дамжин тус орны улс төрийн хүрээний өвөрмөц үзэгдэл болох нам, намын системийн төлөвшилтийн үйл явцад нөлөөлсөн билээ.

### **ХОЁР: МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ТӨЛӨВШИЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА.**

Төлөвшилт хэмээх нэр томъёо нь нийгэм улс төрийн институт, субъектийг үйл ажиллагааны хүрээнд хэрэглэгдэж тэдгээрийн хувьсал, өөрчлөлтийн үйлчлэн орших динамик шинжийг илэрхийлж байдаг. Намууд үндэсний хийгээд төрийн засаглалын төвшинд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцад ардчиллын тулгуур үнэт зүйлсийг өөртөө шингээн төвлөрүүлж улс төрийн үзэл баримтлал, бүтэц зохион байгуулалт болон нийгмийн төлөөллийн хувьд хэлбэршин зүгширч институтжин төгөлдөржихийн хэрээр төлөвшин хөгждөг. Монголд

одогоор улс төрийн 20 орчим нам үйл ажиллагаагаа явуулж байна. Манай намууд өнгөрсөн хугацаанд улс төрийн үйл ажиллагааны зохих туршлага хуримтлуулж алдаа оноон дээрээ суралцан төлөвшин бойжих өсөлтийн үеийнхээ нэлээд хэсгийг туулсан нь тодорхой боловч улс төрийн нам хэмээх бүхэл бүтэн амьд организмын хувьд бүрэн төлөвшин цэгцэрч амжаагүй байна.

Үүнтэй үялдан судлаачдын нэг хэсэг нь Монголын өнөөгийн намуудпыг лидер тойрсон сонирхлын бүлэг гэж байхад нөгөө хэсэг нь төлөвшиж байгаа нам гэдэг. 1990 оны эхэн буюу ардчиллын үйл явцын өрнөлтийн төвөгтэй үед Монголын улс төрийн шинэ намууд нь тодорхой нэр хүнд бүхий лидер тойрсон бүлэглэл маягтай байсны улмаас удирдагчийн хэв шинж бүхий нам / харизматическо-вождийстская партия/ байснаа 1990-ээд оны дунд үеэс эхлэнэ үзэл суртал-улс төрийн өвөрмөц үнэлэмжинд суурилсан / идейно-политическая, доктринальная партия / хэв шинж бүхий нам болон хувирч цаашдаа прагматик сонгуулийн хэв шинж бүхий / прагматическая, избирательная партия / намаа үзэл бодолд тулгуурласан нам болгон төлөвшүүлэх хандлагатай байна гэж үзэж байна.

Ингэж үзвэл Монголын өнөөгийн намууд бол ардчиллын эхэн үеийн харизматик лидерүүдийн хэв шинж бүхий намын хэлбэрээс үндэсний хэмжээний зохион байгуулагдсан олон түмний хэв шинж бүхий парламентийн намын хэлбэрт шилжих үеийн өвөрмөц хэлбэр юм.

Монголд шинээр үүсэн бүрэлдсэн намуудын хувьд орчин үеийн парламентын ардчилсан шинж төрх бүхий нам болж төлөвших ерөнхий нэг шаардлага тавигдсан билээ. Харин энэхүү төлөвшилтийн үйл явц нь нийтлэг нэг улс төрийн орчин нөхцлийн хүрээнд гараагаа эхэлсэн. Гэвч Монголын намуудын хувьд парламентын нам болж төлөвших үйл явцын боломж нам тус бүрийн хувьд онцлогтой байдлаар нөлөөлсөн.

Орчин үеийн улс төрийн намууд парламентын нам болж төлөвших нь жам ёсны үзэгдэл бөгөөд ийм шинжийн намуудыг зөвхөн парламентын фракци, бүлгээр хязгаарлаж болохгүй гэж үздэг. Учир нь тухайн нам олон түмний өргөн дэмжлэгийг хүлээж төрийн бодлогод шүүд нөлөөлөн бодлого, зорилгоо хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц хангалттай тооны мандатыг парламентад авсан байх, намууд зөвхөн парламентад мандаттай байх нь хангалттай биш. Харин тэдгээр нь парламентын хүрээнд зохион байгуулалтын өөрийн гэсэн бүтэц буюу албан ёсны бүлэгтэй, үйл ажиллагаа нь тэр хүрээндээ тогтвортой хүч нөлөөтэй, харьцангуй бие даасан байх ёстой, парламентын намын үзэл баримтлал тодорхой цэгцтэй байхаас гадна зохион байгуулалтын үндэсний хэмжээний бүтэцтэй, үйл ажиллагааны хувьд хэлбэршин зүгширч , төлөвшсөн байх ёстой. 1990 оноос хойшхи хугацаанд манай намууд парламентын 6 удаагийн сонгуулийг дамжин төлөвшиж байгаа боловч тэдгээрээс парламентын намын шаардлага шалгуурыг хангасан нь ердөө хоёрхон.

1996-2000, 2004-2008, 2008 - 2012 онуудын УИХ дахь намуудын байршил, хүчний харьцаа төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцох тэдний оролцоо,

нөлөөлөл, эрх зүйн статусын шинж байдал гүйцэтгэх үүрэг зэрэг бодит хүчин зүйлүүдийг харгалзан үзвэл дээрхи хугацаанд Монголд хоёр намын тогтолцоо оршин үйлчилж байна гэж үзэх үндэстэй юм. Манай намууд өнөөдөр боловсон хүчний хувьд бэхжин сонгодог парламентын намын төвшинд хүрэхийн төлөө бүх арга боломжийг бүрэн дүүрэн ашиглах хэрэгтэй болж байна. Өнөөдөр манай парламентэд хүчтэй гуравдагч сөрөг хүчний дуу хоолой үгүйлэгдэж байна. 2000 оны УИХ-ын сонгуулийн дараа МҮАН, МСДН, МСМН, МШАН, МоАН-ын эрх барих дээд байгууллагууд ардчиллын төлөө намууд нэгдэх санал гарган улмаар 2000 оны 12-р сарын 06-нд тэдгээр намуудын нэгдэх их хурал хуралдаж АН-ыг байгуулсан. 2002 оны 2-р сарын 20-ны өдөр Иргэний – Зориг нам Бүгднайрамдах намтай нэгдэж Иргэний –Зориг- Бүгднайрамдах намыг байгуулсан. 2004 оны УИХ-ын сонгуулийн дараа “Эх орон –Ардчилал” эвсэл задарч улмаар Ардчилсан Намаас М.Энхсайхан тэргүүтэй хэсэг нөхөд өрх тусгайрлаж Үндэсний шинэ хэмээх намыг үүсгэн байгуулсан бол саяхан нэрээ өөрчилж Монгол Үндэсний Ардчилсан Нам болжээ. Иргэний Зориг Бүгднайрамдах нам 2 хуваагдаж, түүнчлэн МАХНамд МАНам болон МЭННамууд нэгдсэж, 2010 онд хуралдсан МАХН-ын 26-р их хурлаас МАХНам Монгол Ардын Нам гэсэн анхны нэрээ сэргээсэн бол хэсэг нөхдүүд МАХН болон Хамуг Монголын Хөдөлмөрийн намыг шинээр байгуулж Улсын дээд Шүүхэд бүртгүүлээ. Өнөөдөр парламентэд суудалтай Иргэний Зориг Нам, Ногооны намтай нэгдэх гэрээ хэлэлцээр төвөгтэй явагдаж байгаа бол МАХН, МҮАН, МУННам, Ардчилсан Хүчний Намууд эвсэх нэгдэх талаар мөн яриа хэлэлцээр тандалтын түвшинд явж байгааг судлаачид анхааралтай ажиглаж байна.

Монгол Улсын өнгөрсөн түүхтэй харьцуулбал олон намын тогтолцоо бий болсон нь гарцаагүй нийгмийн дэвшил байсан юм. Гэвч улс орны алс ирээдүйн эрх ашгаас авч үзвэл олон намын тогтолцоо гэдэг нь сэтгэл ханах үзүүлэлт яавч биш . Намуудын олонлог өөрөө улс орны хөгжлийг бий болгохгүй.Тэр тусмаа үзэл баримтлал нь төлөвшөөгүй нам гэдэг нь нам гэхээсээ цөөн тооны хүмүүсийн бүлэглэлээс цаашгүй бөгөөд тийм бүлэглэлүүдийн хоорондын тэмцэл олон түмнийг бүрэн төөрөгдөлд оруулахаас өөр үр дүнд хүргэхгүй.

Бүхэлдээ өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол оронд олон намын тогтолцоо бий болсон боловч тэдгээр намуудын цаашдын төлөвшилтөөс нийгмийн нүүр царай хамаарах тийм хөгжлийн шатанд МУлс тулж ирээд байна. Намууд ардчилагдаж байж нийгмийн ардчилал гүнзгийрэх ёстой.

Дэлхийн улс төрийн амьдралын нийтлэг жишгээс үзвэл хоёр намын тогтолцоо нь ардчилал харьцангуй өндөр төвшинд хүрсэн, хүмүүсийн улс төрийн ухамсар , соёл, үнэлэмж баримжаалал нь бодитой бөгөөд тогтвортой, улс төрийн намууд нь жинхэнэ нам шинж төрхөө олж, хэдийнээ цэгцрэн төлөвшчихсэн, нийгэмд эзлэх байр суурь, нөлөө нь хүчтэй олон түмний итгэлийг хүлээж чадсан тийм улс оронд илүү бодитой, үр нөлөөтэй үйлчлэх бололцоотой намын тогтолцоо юм.

Ардчиллын нөхцөлд хөл тавиад удаагүй, энэ талын туршлага мэдлэг гэхээр юм хомс, хүмүүсийн ухамсар соёлын түвшин дорой, мэдрэмж сул, улс төрийн бодитой үнэлэмж баримжаалал сонголтын тогтвортой үндэс бүрэлдэж чадаагүй, хэт улстөржин туйлшрах нийгэм-сэтгэл зүйн нөлөөлөлд өртөмтгий манай орны хувьд хоёр намын тогтолцоо хүссэн үр дүнд хүрэхгүй байх магадлал бий. Улс төрийн хоёр том хүчний тэнцвэрийг барьж, зохицуулах үүрэг бүхий гуравдагч хүчний байр суурь үгүйлэгдэж байна.

Монголд цаашдаа төрийн засаглалын тогтвортой үндэс болж чадах улс төрийн төлөвшсөн цөөн хүчтэй намуудаас бүрдсэн олон намын тогтолцооны өвөрмөц хэв маяг оршин үйлчлэх магадлал илүү их байна. Ер нь нийгмийн сэтгэл зүй, олон түмний сонирхол нь улс төрийн хоёрхон хүчний нөлөөлөл / эвслийн зөвшилцөлийн засагтай/ болон хэт олон намууд оршин үйлчлэхийн аль алиныг нь таашаахгүй байгаа юм. Ингэхээр Монголд цөөхөн хүчтэй төлөвшсөн улс төрийн намуудаас бүрдсэн олон намын тогтолцоо оршин үйлчлэх магадлал их байна.

Ардчилсан төрийн тогтолцоон дахь нам нь бусдаас ялгарах өөрийн үзэл онол, баримтлалтай байдаг. УТН-ын үзэл баримтлалын дотоод учир зүй, түүний онцлог талыг тусгайлан шинжлэх нь намын төлөвшилтийн үйл явцыг тодруулан үзэхтэй салшгүй холбоотой.

Намын улс төрийн үзэл баримтлалын агуулгад улс төрийн номлол, үзэл суртал, зорилго, бодлогын гол зарчмууд хамаарагддаг бөгөөд энэ нь намын бодлого, үйл ажиллагааны гол чиглэл, удирдамж нь болдог.

Монголын намуудын үзэл санааны төлөвшилтийн өнөөгийн үйл явц нь нам бүрт харилцан адилгүй жигд биш байсан. МАН, АН, ИЗН-уудыг харьцангуйгаар үзэл дагасан төлөвшилтийн үе болох сонголтын дараах үедээ явж байгаа намууд гэж үзэж болох юм. Харин үлдсэн намуудын хувьд нэг хэсэг нь идэвхтэй эрэл хайгуулын үе, нөгөө хэсэг нь сонгох үедээ явж байгаа гэж хэлж болно. Үзэл баримтлалынхаа суурь зарчим дээр тулгуурлан сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулах нь намуудын төлөвшлийн гол зарчим байх ёстой.

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэж үзвэл, манай намууд одоогоор ямар боловч улс төрийн үзэл баримтлалын тодорхой сонголт хийж, энэ хүрээндээ бие биенээсээ заагран ялгарч хөгжин төлөвших шаардлагатай байна. Тодруулж хэлбэл, намууд төлөвшилтийнхээ энэ цаг үед социал-демократ, либерал, консерватив үзлийн үнэт зүйлсийн хүрээнд заагран ялгарч, нэгдэн нийлэх зайлшгүй хэрэгцээтэй байна.

Нэгдэх нийлэх нь Монголын намууд монгол ахуй иргэншил, сэтгэлгээгээр нөхцөлдсөн цэвэр үндэсний онцлог бүхий үзэл санааны үнэт зүйлийг гол баримтлалаа болгох ёстой гэдгээр илэрдэг бол нөгөө талаасаа, хүн төрөлхтний нийтээр хүлээн зөвшөөрсөн ардчилсан улс төрийн үзэл номлол, үнэт зүйлсийг манай намууд илүүтэй баримтлах учиртай гэсэн байр сууриар тусгалаа олж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа 2011.03.02.



# **ЗУРГИЙН ЦОМОГ**

**“АРДЧИЛЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА”  
БАГА ХУРАЛ /ДУНДГОВЬ 2015.04.20/**



## “АРДЧИЛЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА”



**БАГА ХУРАЛ / Улаанбаатар 2015.11.20/**



## “АРДЧИЛЛАЛД ИРГЭДИЙН ОРОЛЦОО”



**БАГА ХУРАЛ / Өмнөговь 2015.10.30/**



## “ИРГЭДИЙН ОРОЛЦОО-ХӨГЖЛИЙН БОДЛОГО”



**БАГА ХУРАЛ / Дундговь 2015.09.25/**



